

НЭЭЛТТЭЙ УЛС ТӨР

БҮХ ДЭЛХИЙГ
БҮРХСЭН

 COVID-19





Конрад-Аденауэр-Сангаас эрхлэн гаргав.
Энэхүү бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул эшлэлгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно.
Бүтээлд нийтэлсэн материалын агуулга, мэдээллийн үнэн зөвийг зохиогчид хариуцна.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Монгол дахь Конрад-Аденауэр Сан:
ЙОХАНН ФУРМАНН, Суурин төлөөлөгч
С.ГАНЗАЯА, Хөтөлбөрийн менежер

Хүндэт редакторууд:
Шинжлэх ухааны доктор А.ЦАНЖИД
Др. Д.МЯГМАРСҮРЭН, Удирдлагын академийн МДИ-ын захирал

Нарийн бичиг:
Э.СУНДУЙ, Улс төр судлаач

Хэвлэлийн хуудас: 5.25 х.х

ZEGUN
PRESS

АГУУЛГА

ИРГЭНИЙ НИЙГЭМ:

- 6 Монгол дахь иргэний нийгмийн дүр төрх, иргэний нийгэм ба даяаршил
Ц.Батболд, МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор
- 12 Монгол Улсын Их Хуралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг хангах эрхийн асуудал
С.Номынбаясгалан, Хууль зүйн магистр
- 20 Иргэдийн оролцоо- орчин үеийн хэлбэрүүд
Ц.Дэлгэржаргал, Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор
- 25 Улс төрийн боловсрол ба ардчиллын хөгжил
С.Ганзаяа, Монгол дахь Конрад-Аденауэр-Сангийн хөтөлбөрийн менежер

ЦАХИМ ЗАСАГЛАЛ

- 30 Хөгжиж буй орнуудад цахим засаглалыг хөгжүүлэхэд тулгарч буй зарим асуудлууд
Г.Золзаяа МА, Отгонтэнгэр Их Сургуулийн багш
- 35 Хиймэл оюун ухаан (AI) хүмүүсийн амьдралд нөлөөлөх нь
Л.Галбаатар, МУ-ын Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн
- 40 Монголчуудын мэдээлэл дамжуулах, түгээх технологи, тогтолцоо, цуу яриа
А.Энхбат, ШУТИС, БХУС-ийн захирал, доктор, дэд профессор

ТӨР, УЛСТӨР СУДЛАЛ

- 48 Орчин үеийн үзэл суртлын чиг хандлага: хөгжлийн тайлал
Н.Отгонбаяр, Этүгэн Их Сургуулийн багш, улс төр судлаач
- 52 Төрийн албаны тухай шинэ хуулийн онцлог
О.Тунгалаг, “Тунгаамал төв” ТББ-ын гүйцэтгэх захирал
- 56 Намууд мөхөх үү? Намуудад тулгарч буй сорилт
Я.Төгөлдөр, ШУТИС-ийн Нийтийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор
- 63 Ардчилсан институт ба Монголын ардчиллын тухай эргэцүүлэл: Бид хаана явж байна вэ?
Д.Бумдарь, МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор, дэд профессор

БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ

- 70 Байгаль орчныг хамгаалах түүнд иргэдийн оролцоо
Б.Булган, МУИС-ийн Улс төрийн сэтгүүл зүйн магистрант
- 74 Бэлчээрийн мал аж ахуй ба байгаль орчин
А.Цанжид, ШУ-ны доктор, профессор

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

- 80 Бүх дэлхийг бүрхсэн COVID-19
Д.Мягмарсүрэн, Удирдлагын академийн МДИ-ын захирал, доктор



ЙОХАНН ФУРМАНН

**Монгол дахь Конрад-Аденауэр-Сангийн
Суурин төлөөлөгч**

МЭНДЧИЛГЭЭ

**Хүндэт Конрад-Аденауэр-Сангийн
найзууд аа,**

Монгол дахь Конрад-Аденауэр-Сангийн суурин төлөөлөгчийн газар нь Монгол Улсын ардчиллыг хөгжүүлэх талаар явуулж буй үйл ажиллагааг тууштай дэмжин төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ хүрээнд эрх зүйт төрийг бэхжүүлэх, нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийн зарчмыг олон нийтэд таниулах ажлыг 27 жилийн хугацаанд явуулж байна.

Бид улс төрийн боловсролыг түгээн дэлгэрүүлснээр улс төр, нийгмийн амьдралд идэвхтэй оролцдог иргэд төлөвшихөд хувь нэмэр оруулахыг эрмэлзэж байгаа юм.

Ваймерын Бүгд Найрамдах Улсын сургамжаас үзэхэд Ардчилал нь ардчилагчгүйгээр оршин тогтнох боломжгүй юм.

Эрхэм уншигч та бүхэн манай сэтгүүлийг байнга уншиж, ардчиллын үнэт зүйлс, үндсэн зарчим, 21-р зууны ардчиллын онцлогийн тухай мэдлэгээ чамбайруулахын зэрэгцээ өөрийн оронд болон дэлхий дахины ардчиллын үйл явц, саад бэрхшээл, гэтлэн давах арга замын талаар хэлэлцүүлэг ярилцлага өрнүүлэхэд идэвхитэй оролцож сэтгүүлийн дотны нөхөр байна гэдэгт гүнээ итгэж байна.

Та бидний хамтын чармайлт үр шимээ өгч Монгол Улс ардчиллын замд их амжилт олж, цэцэглэн хөгжих болтугай.

ӨМНӨХ ҮГ

Манай сэтгүүлийн ээлжит дугаар дэлхий дахинаа халдварт өвчин дэгдэж, олон хүн өвдөж, бас нас барж буй хүнд үед уншигчдын гарт очиж байна. Цар тахлын тархалт улс орон бүрт янз бүр байгаа зэргээс шалтгаалан ардчиллын талаар эргэлзэнгүй өнгө аястай үг яриа ч мэр сэр гарах болов. Зарим оронд иргэд хөл хорионы дэглэм зөрчих зэргээр задгайдуу байснаас болж тахал ихээхэн тархаж байгаа нь ардчиллын мөн чанартай холбоотой бус ардчилал бол эрх үүргийн шүтэлцээ юм гэдгийг ойлгоогүй, хуулинд захирагдах нь ардчиллын нэг хэм хэмжээ гэдгийг дугуу ухамсарласан хувь хүний үйлдлээс болж байгаа гэдэг нь эргэлзээгүй юм. Харин ч ковид-19 нь ардчиллын хэм хэмжээг сайтар сахих нь ямар чухал болохыг харууллаа. Түүнчлэн өнөөгийн нийгэм-улс төрийн амьдралд иргэдийн улс төрийн боловсрол ямар чухал болохыг давхар харуулж байна.

Манай сэтгүүл эл дугаартаа уламжлал ёсоор иргэдийн улс төрийн оролцоо, иргэний нийгмийн байгууллага, тэдгээрийн оролцоо, ач холбогдлын талаар цуврал өгүүлүүдийг нийтэлж байна. Улс орны улстөр, нийгэм, эдийн засгийн тогтолцоо эрүүл саруул байж, хөгжил дэвшилд хүрэхэд иргэдийн оролцоо чухлаас гадна, нөгөө талаас төрийн алба шударга, чадварлаг, үйл ажиллагаа нь үр нөлөөтэй байх учиртай. Энэ сэдэвт зориулсан өгүүлүүд бас нийтлэгдэж байна. “Чадварлаг, сайн захиргаатай байх нь тансаглал биш ээ” гэсэн оновчтой үг байдаг билээ. Цаашид ч бид энэ сэдвийг хөндөж, төрийн албаны өнөөгийн байдал, сайжруулах арга замын асуудлаар өгүүлэл нийтлэх болно.

Өнөө үеийн нэг онцлог бол аж үйлдвэрийн шинэ хувьсгал өрнөж, шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй дэвшлийн үр дүнд хүн төрөлхтний ажиллах, амрах, амьдрах бүхий л арга маяг өөрчлөгдөж байгаа явдал мөн. Үүнээс улбаалан гарч байгаа нэг шинэ үзэгдэл бол цахим засаглал юм. Цахим засаглал, цахим боловсрол, цахим худалдаа гэх мэт болон бусад олон салбарын “цахимууд” нь нэг талаас төрийн үйлчилгээг цахимжуулах, нөгөө талаас иргэдийн “цахим тайлагдалт”-ыг хэрэгжүүлэх шаардлагыг буй болгож байна. Уншиж бичиж чаддаггүй хүнийг бичиг үсэг үл мэдэгч гэдэг байснаа, одоогоос хэдхэн жилийн өмнө бичиг үсэг мэдэх нь хангалтгүй, түүний дээр компьютер ашигладаг байх хэрэгтэй гэдэг байсан бол одоо бүхий л төрлийн цахим хэрэгслийг ашигладаг байх хэрэгтэй болж байна. Энэ тухай сэдэв ч бас хөндөгдөж байгааг уншигчид ажиглах бизээ.

Сэтгүүлийн анхаарлын төвд байнга байдаг асуудлын нэг нь байгаль, экологи юм. Үүнд ч иргэний оролцоо чухал нөлөөтэй юм. Монголчууд байгаль дэлхийгээ хамгаалж, зохицон аж төрөх баялаг уламжлалтай. Түүнийг өнөө үед ч баяжуулан ашиглах нь өгөөжтэй байх болно.

Эцэст нь тэмдэглэхэд сэтгүүлд нийтлэгдэж буй өгүүлүүдийн дүгнэлт санал нь манай сэтгүүлийн бус, өгүүлэл бүрийн зохиогчийн байр суурь юм. Тиймээс уншигчид төрсөн санал сэтгэгдлээ зохиогчидтой хуваалцах боломжтой. Түүнд манай сэтгүүл зуучлагчийн үүрэг хүлээхэд бэлэн байна.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ



Ц.БАТБОЛД

МУИС-ийн ШУС-ийн Улс төр
судлалын тэнхимийн багш, доктор

Монгол дахь иргэний нийгмийн дүр төрх, иргэний нийгэм ба даяаршил

Дундад зуунаас капитализмд шилжих явцад иргэний нийгэм бүрэлдэж, хүмүүс төр, нийгмийн ялгааг ухамсарлаж эхэлжээ. Иргэний нийгмийн үзэл санаа нь улс төрийн сэтгэлгээний уламжлалд оршдог. XVII зуунд Голландад үүссэн анхны капитализмын эрхийн үзэл баримтлал нь Гуго Гроций, Барух Спиноза нарын үндэслэсэн хүний байгалийн жам ёсны эрхийн тухай үзэл юм. Энэ онолын гол таамаглал нь тэгш байдал бол хүмүүсийн байгалийн бодит нөхцөл байдал юм. Хүн төрөлхтөн байгалиас тэгш эрхтэй төрсөн. Тэгш эрх нь эрх чөлөөг агуулдаг тул хувь хүн бүр энэ эрх чөлөөг эдлэх эрхтэй. Энэхүү байгалийн тэгш байдал нь бие махбодийн болон сэтгэцийн чадварын тэгш бус байдалтай бүрэн нийцдэг гэж үздэг. Феодал эздийн харьяалалд байсан, эрх чөлөөгүй хамжлагат албатуудын оронд, капиталист үйлдвэржилтийн явцад хотуудад хөлсний хөдөлмөр эрхэлсэн ажилчин анги үүссэн байна. Хэн нэгэн газрын эзэн, эсвэл угсаа залгамжилсан сурвалжит язгууртнаас

хараат бус, өөрөө өөртөө эзэн болсон эрх чөлөөт хөлсний хөдөлмөр эрхлэгч хүмүүсийг Францын 1789 оны их хувьсгалаар гарсан “Хүний ба иргэний эрхийн тунхаг”-аас хойш улсын, эсвэл хотын иргэн хэмээн нэрлэж, албан ёсны иргэний байр суурийг бий болгожээ. Өчүүхэн бага хөлсөөр хөдөлмөрлөж амьдардаг эдгээр “ажилчин анги” эрхээ эдэлж чаддаггүй нь тэдний хэт ядуу байсантай холбоотой юм. Гэвч тэд эрхийнхээ төлөө тэмцэх оюун санааны нэгдлийг бий болгож эхэлсэн ч энэ нь коммунизмын зэрэглээг бий болгох үндэс болжээ. Тухайн үед харьцангуй цөөн боловч дунд ангид тооцогдох сэхээтнүүд болон жижиг бизнес эрхлэгчдийн эрх ашиг, сонирхлын жижиг нэгдлүүд үүсэж, төрд шаардлага тавих болсноор иргэний нийгмийн бие даасан хүрээнүүд бүрэлдсэн ажээ. Жон Локкийн зөвхөн иргэдийн ухамсартай сонголтод үндэслэсэн нийгмийн хэлэлцээрээр хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн эрхт хүчин л төрийн эрхийг барих ёстой гэсэн үзэл санаа нь иргэний нийгмийн оюун санааны үндэс болжээ.

ИРГЭНИЙ НИЙГЭМ ГЭЖ ЮУ ВЭ? (ОНОЛЫН ТОДОРХОЙЛОЛТУУД)

Иргэний нийгмийн үзэл баримтлал нь нийгмийн янз бүрийн бүлгүүдийн ашиг сонирхлыг илэрхийлсэн олон утгыг агуулдаг ч олонх эрдэмтэн судлаачид энэ нь ардчиллын үндсэн тулгуур гэж үздэг байна. Иргэний нийгэм гэдэг нь төр, улс төр, хувийн болон эдийн засгийн салбараас ялгаатай, хүмүүсийн сайн дурын үйл ажиллагааны хүрээ бөгөөд амьдрал дээр хүмүүсийн эдгээр харилцааны хил хязгаарыг тогтоох боломжгүй юм. Томас Гоббс зөвхөн төр л хувь хүний аюулгүй байдал, тайван амьдралын баталгаа болж чадна. Төр хүчтэй байснаар иргэний нийгэм цэцэглэн хөгжих боломжтой гэсэн санааг илэрхийлжээ. XVIII зууны хоёрдугаар хагаст иргэний нийгмийн тухай ойлголтыг үзэл баримтлалд оруулах томоохон өөрчлөлтийг Адам Фергюсон, Томас Пейн нарын олон сэтгэгчид хийсэн байна. А.Фергюсон хүн бүдүүлэг, энгийн байдлаас гарахын тулд дүрэм, ёс заншилд захирагдаж сурдаг. Иргэний нийгэм бол соёл иргэншлийн боловсронгуй хэлбэр мөн. ...соёлтой нийгэмд зиндаа зэрэглэл буюу иерархи шатлал, мэргэжлийн ялгаа, хөдөлмөрийн хуваарь нь ур чадварыг дээшлүүлж, худалдаа, үйлдвэрлэлийг ахиулахад хүргэсэн. Үүний үр дүнд “баялгийн эх үүсвэр нээгдэж”, иргэний болон арилжаа, урлагийн хамгийн төгс төгөлдөр байдал цэцэглэн хөгжих боломжтой юм гэж үзэж байв. Энэ үед иргэний нийгмийн үзэл баримтлалыг аажмаар боловсруулж, түүнийг төрөөс

ялгаж, иргэний нийгмийг өөрийн хэлбэр, зарчимтай болгосон. Энэ үеэс эхлэн иргэний нийгмийг зөвхөн төр рүү чиглэсэн төдийгүй төрийн эрх мэдлийг хязгаарлах (заримдаа бүр эсрэг зүйл) үүрэг гүйцэтгэхэд чиглүүлэх болсон. Жон Локк иргэний нийгмийг төрөөс тусдаа, бие даасан байгууллага бөгөөд хувь хүн, тэр дундаа хувь хүний эрх, өмч хөрөнгийг төрийн дур мэдэн хөндлөнгөөс оролцох явдлаас хамгаалах үүрэгтэй гэжээ (Merkel and Lauth 1998, 4; Schade 2002, 10).

Ш.Монтескье “Төрийн эрх мэдэлбаиргэнийнийгмийнхоорондын тэнцвэрт байдлыг онцолж, төрийн эрх мэдэл, хууль ёс нь иргэний нийгмийн хүч чадлаар хязгаарлагдах ёстой” гэж үзэж байжээ (Merkel and Lauth 1998, 5). Алексис де Токвиль “Америк дахь ардчилал” бүтээлдээ иргэний нийгэм бол ардчилсан сэтгэлгээ, хандлага, зан төлөв (хүлээцтэй байх, шударга ёс, итгэлцэл гэх мэт)-ийг хувь хүн бусад иргэн бүрээс сурч мэддэг ардчиллын сургууль бөгөөд тухайн нийгэмд төр, засаглалын монополь хүчирхийллийн олон хүчин зүйлээс хувь хүний эрх ашгийг хамгаалахыг зорьсон байдаг гэсэн санааг илэрхийлжээ. Ф.Гегель “Иргэний нийгэм бол гэр бүл, төрийн зохицол мөн. Ийм нийгэм нь хувийн өмч, социал ялгарал, сонирхлын олон янз байдал, бүлэг болон хувь хүмүүсийн харилцан үйлдэлд үндэслэгддэг. Уг нийгэм дотроо зөрчилдөөнтэй, олон ургалч, энэ нийгэмд эрх чөлөөт хүн бүр өөрийн зорилготой, бусад нь түүний хувьд юу ч биш. Сонирхлын олон янз байдлыг зохицуулахын тулд төрд бүх нийтийн сонирхлыг



илэрхийлж шийдвэр гаргах чадвартай дээд шүүгч /арбитр/ хэрэгтэй. Нийгэм зөвхөн төрийн удирдлагын хүчинд л “иргэний” байж чадна” гэжээ. Юрген Хабермасын “коммуникацийн үйл ажиллагааны онол”-д улс төрийн шийдвэрүүдийн хууль ёсны байдал нь зөвшилцлийн нээлттэй харилцаа, өөрөөр хэлбэл иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, тэдний шударга мэтгэлцээнээр хангагддаг гэж үздэг.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН МӨН ЧАНАР

Адам Смит эдийн засгийн талаас нь хувь хүний мөн чанарыг тодорхойлсон. Тэрээр хувь хүн өөртөө анхаарал тавьдаг, биеэ даасан, ашиг тустай, ашиг орлого сайтай, өрсөлдөх чадвартай байхыг хүсдэг. Хүн бүр өөртөө бусдаас илүү санаа тавьдаг. Хүний өөрийгөө хамгаалах байгалийн зөн совин, оюун санааны эхний ажил бол бие махбодийн аюулгүй байдал, тааламжтай орчин, түүнийг бий болгох хийж бүтээх хүсэл эрмэлзэл юм. Хувь хүний хүсэл эрмэлзлийн анхны

даалгавар нь өөрийнх нь зөн совин, өгөөмөр сэтгэлээс бус гадны хүчин зүйлсээс маш их хамааралтай байдаг. Тиймээс тэрээр үүнд хүрэхийн тулд нийгмийн аюулгүй байдал, хөгжил цэцэглэлт мөнхөд оршихуйг хүсдэг. Энэ нөхцөлд хувь хүн ихэнхдээ сайхан нийгмийн тухай утопи мөрөөдлөөс илүү бодит орчинтойгоо харьцаж, түүнийг сайжруулах зорилгоор бусадтай эвлэлдэн нэгдэж эхэлснээр янз бүрийн сонирхол бүхий иргэний нийгмийн бие даасан хүрээнүүд үүсдэг байна. Эндээс нийгмийн соёл, гэр бүл, ёс суртахуун, ёс заншил, билэг тэмдэг, бүх нийтийн бодит эрх чөлөөний асуудлаар дамжуулан хүмүүс нийгэм, эдийн засгийн асуудлаа өөрсдөө зохицуулах, эсвэл төрд шаардлага тавьдаг ажээ.

Хүний нийгмийн үндсэн таван бүрэлдэхүүн хэсэг байдаг. Энэ нь: хүн ам, соёл, материаллаг бүтээгдэхүүн, нийгмийн зохион байгуулалт, нийгмийн институц юм. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь нийгмийн өөрчлөлтийн объектив хүчин зүйлс бөгөөд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо нь объектив буюутухайлбал, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд улс төрийн засаглал, төрийн захиргааны шийдвэр, хэрэгжилтийг илүү бодитой, оновчтой болгоход иргэний нийгмийн оролцоо чухал үүрэг гүйцэтгэдэг. ТББ бол орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд байгуулагддаг ашгийн бус, иргэдийн сайн дурын зохион байгууламж бүхий, институцжиж буй бүлэг юм. Иргэний нийгмийн байгууллагууд (ТББ) нь засгийн газрын

төсвийг бүрдүүлэх, хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар олон нийтийн хэлэлцүүлгийг нэмэгдүүлэх, төрийн орлого, зардлын ил тод байдлыг дэмжихэд хувь нэмэр оруулж, хөгжиж буй орнуудын ил тод байдал, сайн засаглалыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж чадна. Тиймээс иргэний нийгмийн зохион байгуулах чадварыг сайжруулах, ялангуяа ахиц бүлгүүд өөрсдийн ашиг сонирхлыг илэрхийлэх хэрэгсэл болгох шаардлагатай байдаг.

ИРГЭНИЙ НИЙГЭМ ХААШАА ЯВЖ БАЙНА ВЭ?

Орчин үеийн иргэний нийгэм нь хөгжил дэвшлийн хэлэлцүүлэгт чухал байр суурь эзэлж, нийгмийн янз бүрийн бүлгүүдийн тодорхой байр суурь бүхий дуу хоолой, эрэлтийн асуудлыг орон нутгийн, үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд илэрхийлэхэд чиглүүлдэг болжээ. Энэ утгаараа

иргэний нийгмийн байгууллагууд нь төрийн эсрэг гэхээс илүүтэй төртэй хамтран ажиллах болсон байна. Хүчтэй иргэний нийгмийн гол давуу талуудын нэг нь хүн амын тодорхой хэсэгтэй нягт холбоо тогтоох замаар судалгаа, шинжилгээ хийж төрд ч, хувийн хэвшлийн аль ч хэсэгт төрөөгүй санаа бодлыг гаргаж шийдвэр гаргагчдад шинэ мэдээлэл хүргэх явдал юм. Энэ хүрээнд иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэхэд төрийн зүгээс тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлэхэд ч анхаарах шаардлага үүсэж байна. Өнөөгийн иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл нь хүний амьдрал, эрх чөлөө, боловсрол, хөгжил, нэр төр, зохистой ажил, нийгмийн шударга ёс, тэгш эрх, хүний хувийн болон хамтын эрхийг дэмжин ажиллахаас гадна нийгмийн халамжийн үүргийг ч сайн дурын хэлбэрээр гүйцэтгэх болжээ.



МОНГОЛД ИРГЭНИЙ НИЙГЭМ БАЙНА УУ?

Монголд 1990-ээд оноос хойш анх удаа иргэний нийгмийн бодит бие даасан хүрээ (ТББ, сонирхлын бүлэг, иргэний хөдөлгөөн гэх мэт) үүсч эхлэх улс төр, эдийн засаг, нийгмийн болон оюун санааны бодит орчин бүрэлдэж эхэлсэн. Иргэний нийгмийн оршин тогтнох нийгмийн үндэс нь дундаж давхарга бөгөөд тэдний (цалин, ажлын байр гэх мэтээс) хараат бус сэтгэлгээ нь өөрсдийн эрх, ашгийг нийгмийн шударга ёсонд нийцүүлэх сонирхлын үүднээс иргэний нийгмийн институцжсэн байгууллагуудыг санхүүжүүлэн оршин тогтноулдаг. Монголд одоогоор сонгодог утгаар дундаж давхарга бүрэлдэж чадаагүй боловч даяаршлын нөлөөгөөр олон улсын иргэний нийгмийн байгууллагуудын тусламжтайгаар ТББ-ууд санхүүжин оршин тогтнох болсон. Гадны ТББ-уудын дэмжлэг, туслалцаа нь эерэг, сөрөг олон үр дагаврыг бий болгож байгаа ч эерэг тал нь илүү давамгайлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, иргэний хөдөлгөөн Фридландын хувьцааныхаа үнийг унагаж, босгох бизнестэй холбоотой үүссэн хэдий ч иргэний нийгмийн тэмцлийн нэг чухал хэлбэрийг төлөвшүүлэхэд нөлөө үзүүлсэн байдаг. ТББ-ууд санхүүжүүлэгчийнхээ захиалгаар зорилгоосоо хазайсан үйл ажиллагаа явуулах, иргэний хөдөлгөөнүүд захиалагчийнхаа зорилгод нийцүүлэн шахалтын бүлгийн үүргийг гүйцэтгэх, эсвэл санхүүжилтийн эх үүсвэрээ олохын тулд шантажлагч бүлгийн үйл ажиллагаа явуулах зэрэг хандлага

ажиглагддаг нь ИНБ-ууд оршин тогтнох гэсэн “амь тэмцсэн” түр зуурын үзэгдэл юм. Монголын нийгэм, эдийн засгийн хөгжил дээшилснээр хүн амын олонх дундаж давхаргад шилжсэнээр ИНБ-ууд төлөвших болно.


ИРГЭНИЙ НИЙГЭМ БА ДАЯАРШИЛ

1980-аад оноос хойш төрийн бус байгууллагууд (ТББ) бүс нутаг, олон улс, дэлхийн түвшинд шийдвэр гаргах үйл явцыг ардчилах, хүний эрхийг хамгаалах, хамгийн хэрэгцээтэй хүмүүст үйлчилгээ үзүүлэх чухал хүчин болж ирэв. Даяаршсан засаглалын энэхүү өргөжүүлсэн үүргийг ойлгох, хүний тогтвортой хөгжлийг хангахад төрийн үүрэгт тодорхой хэмжээгээр сэтгэл дундуур байдаг боловч, иргэний нийгмийн илүү уян хатан, идэвхжсэн, төвлөрсөн бус бүтэц нь энэ үүргийг гүйцэтгэхэд шаардагдах ур чадвар, үүрэг хариуцлагатай болсоор байгаа гэсэн итгэл үнэмшил улам бүр тогтох болсон байна.

Сүүлийн жилүүдэд ТББ-уудын үйл ажиллагааны чиглэл орон нутгийн болон үндэсний түвшнээс олон улсын түвшинд хурдацтай өргөжиж байна. Даяаршлын хүрээнд болж буй институцийн өөрчлөлтөд НҮБ-ын агентлагууд, бүс нутгийн байгууллага, санхүү, худалдааны байгууллагууд, үндэстэн дамнасан корпорациуд зэрэг олон улсын оролцогчид, мөн засгийн газар хоорондын “дээд хэмжээний уулзалтууд” нь даяаршсан засаглалд улам бүр чухал үүрэг гүйцэтгэх болсон байна. Дэлхий дахины засаглалын харилцааны энэхүү хувьсан өөрчлөгдөж

буй тогтолцоонд ТББ-ууд харьцангуй хоцрогдолтой оролцож байгаа боловч дэлхий нийтийн хөгжлийн асуудалтай холбоотой олон улсын шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх арга замыг хайж байна.

Даяаршлын институцийн болон нийгмийн үр дагаврын талаарх НҮБ-ын Нийгмийн Хөгжлийн Судалгааны Институт (UNRISD)-ийн тайланд олон улсын эдийн засаг, санхүү, худалдааны байгууллагууд илүү их эрх чөлөө, эрх мэдлийг эдэлж байгаа боловч нийгмийн хариуцлагын хэмжээ зохих хэмжээгээр нэмэгдэхгүй байгаа нь анхаарал татаж байгааг онцлон тэмдэглэсэн байна. Энэхүү болзошгүй тэнцвэргүй байдлыг засахын тулд дэлхийн тавцанд ТББ-ууд үүрэг гүйцэтгэнэ гэж их найдаж байна. Гэхдээ энэ үүргийг гүйцэтгэхэд ТББ-ууд хангалттай үр дүнтэй байж чадах уу? Тэд олон улсын шийдвэр гаргахад чиглэсэн том гүрнүүд давамгайлсан форумд нэвтэрч чадах уу? Тэд дэлхийн засаглалын үйл явцад нөлөөлөхөд шаардлагатай уялдаа холбоо, ёс суртахууны эрх мэдлийг авч үлдэж чадах уу? түүнд хэрхэн хүрэх вэ? гэсэн асуулт тавигдсаар байна.



С.НОМЫНБАЯСГАЛАН

Хууль зүйн магистр

Монгол Улсын Их Хуралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг хангах эрхийн асуудал

Хууль зүйн толь бичигт нийтлэг байдлаар “хөгжлийн бэрхшээл ~ тахир дутуу хүн” гэдгийг өвчин, гэмтэл буюу оюун ухааны хомсдлын улмаас амьдралын үйл ажиллагаа нь хязгаарлагдмал болсон ба түүнд нийгмийн хамгаалалт зайлшгүй шаардлагатай байгаа болон бие организмын чиг үүрэг нь үлэмж сарниж, эрүүл мэнд нь муудсан этгээд” гэж тайлбарлажээ. Харин хууль зүйн үүднээс бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж үндэсний болоод олон улсын эрх зүйн хэм хэмжээнд “нийтлэг” байдлаар тодорхойлж байна. Энэ нь хэм хэмжээг “тогтоох” талаар олон улсын эрх зүйн болон дотоодын хууль тогтоомж нь тус тусдаа бие даасан эрх зүйн хоёр өөр салбар мэт боловч тэдгээрийг хэрэгжүүлэх нөхцөлд өөр хоорондоо нягт уялдаатай гэдгийг харуулж байна. Албан ёсны статистикийн мэдээлэл буюу нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээнд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоос “хөгжлийн бэрхшээлтэй” гэж тодорхойлогдсон хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэдэгт хамааруулж байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог (2014–2018 оны байдлаар) харахад (6 118) буюу 6.1 хувиар өссөн байна. Тодруулбал, төрөлхийн бэрхшээлтэй хүний тоо (11 277) буюу 31.6 хувиар

нэмэгдсэн, олдмол бэрхшээлтэй хүний тоо (5 243) буюу 8.5 хувиар буурсан байна. Түүнчлэн 0–15 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (2 357) буюу 20.7 хувиар буурсан, харааны бэрхшээлтэй хүний тоо (1 867) буюу 19.3 хувиар нэмэгдсэн, сонсголын бэрхшээлтэй хүний тоо (135) буюу 1.6 хувиар нэмэгдсэн, хэл ярианы бэрхшээлтэй хүний тоо (982) буюу 18.5 хувиар буурсан, хөдөлгөөний бэрхшээлтэй хүний тоо (3 187) буюу 17.3 хувиар нэмэгдсэн, сэтгэцийн бэрхшээлтэй хүний тоо (3 367) буюу 19.8 хувиар нэмэгдсэн, хавсарсан бэрхшээлтэй хүний тоо (2 838) буюу 28 хувиар буурсан, бусад төрлийн бэрхшээлтэй хүний тоо (1 382) буюу 4.4 хувиар нэмэгдсэн тус тус үзүүлэлттэй гарсан байна.¹ Иймд тухайн нийгмийнхээ бүтцийн тусгал болсон “төлөөллийн” тухай ойлголтоор хууль тогтоох байгууллага нь зарим талаар “тухайн улс үндэстний толин тусгал” нь болох ёстой. Энэ асуудалд улам бүр ач холбогдол өгч шийдвэр гаргахад харгалзан үзэх хандлага дэлхий нийтэд ажиглагдаж байна.

Тиймээс хууль тогтоох байгууллага нь эрэгтэй, эмэгтэй, хөгшин залуу, баян, ядуу хүмүүсийн “төлөөлөл” болоод тухайн нийгэм дэх янз бүрийн шашин, хэл соёл, үндэстэн ястны бүлгийн төлөөллийг оруулдгийн нэгэн адил “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг хангах” ёстой. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотой бөгөөд харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад (эдгээрээс бусад болон хавсарсан) гэсэн 6 ангиллаар авч үзэж байна.

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг “төрөлхийн” ба “олдмол” гэсэн ангиллаар тодорхойлж, тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн, харин амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол гэсэн төрөлд хамааруулж байна. 2018 оны эцэст “Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 105.7 мянган иргэн байгаагийн 59.7 мянга нь эрэгтэйчүүд, 46.0 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 44.4 хувь буюу (46 958) нь төрөлхийн, 55.6 хувь буюу (58 733) нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн байна. Энэ нь хүн амын дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өндөр байгааг харуулж байна. Улаанбаатар хотын хувьд 2018 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 35.6 мянган иргэн байгаагийн 19.7 мянга нь эрэгтэйчүүд, 15.9 мянга нь эмэгтэйчүүд, тэдгээрийн 15 956 нь төрөлхийн, 19 633 нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна. Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас

¹ (Мэдээллийн лавлах. <http://www.mlsp.gov.mn/uploads/news/files/2300865ec1b737c21899a7ebc7db42da23523c9e.pdf>)

баралтын голлох шалтгааны нэг нь осол болж байгаатай холбоотой юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг бэрхшээлийн төрөл, насаар авч үзэхэд бага, залуу насныхны дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй тохиолдол өндөр байснаа нас ахихын хэрээр олдмол бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэх хандлага байна.² Тиймээс сонгуулийн хууль тогтоомжид энэ асуудлыг тусгах хэрэгцээ шаардлага үүсч байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд “хөгжлийн бэрхшээлтэй иргэд Монгол Улсын Их Хуралд нэр дэвших 5 хувийн квот хүслээ” гэсэн гарчигтай нийтлэл цөөнгүй гарсан байна.

ҮНДСЭН АСУУДАЛ

“Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн (14.2.) заалт “тэгш эрхийн” агуулгыг илэрхийлээд зогсохгүй, түүний гол баталгаа нь болж байна. Энэ заалтад “бэлгийн чиг баримжаа”, “хөгжлийн бэрхшээл” зэргийг тухайлан заагаагүй боловч тэгш эрхийн ерөнхий үзэл баримтлалын хүрээнд эдгээр “онцлог шинж” –ээр нь хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглодог. Үүний үндсэн хуулийн үндэслэл нь “тэгш байдал” гэж үзээд тэгш байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимтай холбон тайлбарлаж ирсэн байна. Зарим улсад “үндсэн хуулийн ялгаварлан гадуурхахыг хориглох зарчим” гэж нэрлэдэг. Ийнхүү “Тэгш байдлыг хангах нь эрх чөлөөг хангах зарчмаас эх үндэстэй учраас эрх, эрх чөлөөг хангасан цагт тэгш байдал хангагдана” гэж үздэг. Тэгш эрхийг (хүн бүрт эрх тэгш хандах) хэрэгжүүлэхийн тулд тэгш байдлын (адил тэгш хүмүүст адил тэгш, “... Хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгогдох эрхтэй. С. Нарангэрэл “Улсын Их Хурлын сонгуульд эмэгтэй нэр дэвшигчдэд квот тогтоодог шиг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд квот олгох санал гаргаж байна” гэжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 1 дүгээр зүйлд “Энэхүү конвенцийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхүүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршино. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ” гэж зохицуулсан байна.

² (Мөн тэнд, 16–19, Эндрю Рейнольдс нар, 21)

Энэ конвенцийг Монгол Улс 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр соёрхон баталсан. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тэгш байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, 14-р зүйлийн 1 дэх хэсэгт хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш гэж тус тус заасан. Эдгээр заалт нь хүн бүрийн амьдрал адилхан чухал, хүн бүр хувь хүнийхээ хувьд адил үнэ цэнэтэй, хүн бүрт хүний ёсоор хандах үзэл санааг илэрхийлдэг. Мөн түүнчлэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 болон 26 дугаар зүйлд заасан хүн бүрийн шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрх энэ хүрээнд хамаарна.³

Иймд үндсэн хуульд “хөгжлийн бэрхшээл” гэж шууд нэрлэн тусгагдаагүй боловч Монгол Улсын олон улсын гэрээнд (Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн конвенцод заасан эрх “үндсэн эрх”-ийн түвшинд хамгаалагдана гэсэн үг) тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөг хөгжлийн бэрхшээлтэй хүн “бусдын нэгэн адил” эдлэх, хамгаалуулах боломжтой юм. Ийнхүү үндсэн хууль болоод олон улсын гэрээгээр баталгаажсан “хүн бүр ялгаварлан гадуурхагдахгүй байх” зарчмыг хэрэгжүүлэх нөхцөл журмыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж байна. Үүнийг бас хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах (disability equality) гэж нэрлэж болох юм. Улмаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн (цаашид “ХБХЭТК” гэх) талаарх Монгол Улсын анхдугаар илтгэлд “Үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн актуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлан ялгаварласан заалт одоогоор байхгүй бөгөөд хуулийн хүрээнд тэгш хамгаалуулах,.. зэрэг төрийн зүгээс үзүүлэх аливаа үйлчилгээнд тэгш хамрагдах боломж хуулиар нээлттэй байна” гэж тэмдэглэсэн байна. Энэ талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн (2018) судалгаанд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар үндсэн хуулиар заагдсан хүний эрхийг дэлгэрүүлэн тайлбарласан нь “хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх утгыг бүрэн дүүрэн илэрхийлж өгсөн” байна” гэж тэмдэглэсэн байна. Тэгвэл Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай (4.1.2) хуульд ““хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох

³ (Ч. Энхбаатар нар, 46; Сүнжид Д, 49, Ч. Энхбаатар 2007, 120-121)

хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно” хэмээн тайлбарласан байхын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүн “бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдоход нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих” үүрэгтэй гэсэн онцлог (30.3) зохицуулалт хийж, тэдгээрийн улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрх хэрэгжих нөхцөлийг хангаж өгсөн байна. Улмаар иргэдээс төрийг удирдах хэрэгт оролцох байнга давтагддаг, хамгийн өргөн эрх бол “сонгууль” юм. Тиймээс сонгуульд оролцогчдын эрхийг “тэгш” хангахын тулд Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэсэн заалтын “шаардлага”-ыг бүрэн хангасан Монгол Улс дахь үндсэн эрхийн хүрээ нь үндсэн хуульд “нэрлэгдсэн” болон “нэрлэгдээгүй” эрхээр тодорхойлогддог. Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. Иймд үндсэн хуульд томъёологдоогүй боловч Монгол Улсын олон улсын гэрээнд тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөг (үндсэн хуульд дурдагдаагүй учраас хамгаалагдахгүй гэж үзэж болохгүй) Монгол Улсад байгаа бүх хүн нэгэн адил эдлэх, хамгаалуулах боломжтой гэж үздэг. Хүний эрхийн үндэсний комисс, Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмж (780), Хууль зүйн судалгааны төв, Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайлан, бусад ном зохиолд энэ талаар тодорхой дурджээ.

Гэвч үндсэн хууль болоод сонгуулийн тухай хуулиар “Ялгаваргүйгээр төрийн байгууллагад, сонгуульд сонгох, сонгогдох эрхтэй, улс төрийн харилцаанд хүн бүр тэгш эрхтэй” хэмээн зохицуулсан байдаг боловч бодит байдалд тэгш хамрагдаж чадахгүй байгаагийн нэг жишээ нь “Улсын Их Хурлын сонгуульд сонгогдсон гишүүдийн дунд “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” байдаггүй. Эмэгтэй болон залуу төлөөлөгчдийн тоо хүн амын дунд эзлэх хувьтай

харьцуулахад хангалтгүй бага байна” гэж сонгогчийн материалуудад цөөнгүй тэмдэглэсэн байна. Үүнээс гадна дурдсан (ХБХЭТК)-ийн хэрэгжилтийн талаарх илтгэлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “улс төр, нийгмийн амьдралд оролцох” асуудлыг зөвхөн сонгох эрхийн (санал өгөх) хүрээнд авч үзсэн нь учир дутагдалтай болсон байна. Ийм хүмүүст тэгш байдал, тэнцүү боломжийг олгохын тулд зарим улс оронд хүн амд эзлэх хувь хэмжээгээр парламентын суудалд квот тогтоон хадгалсан байна. Жишээлбэл, Руанда улс үндсэн хуулиараа шийдвэр гаргах түвшний байгууллагын 30 хувийг эмэгтэйчүүдэд, 80 гишүүнтэй Төлөөлөгчдийн танхимийнхээ 24 суудлыг эмэгтэйчүүдэд, гурван суудлыг залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хуваарилсан байдаг байна. “Төрийг удирдах хэрэгт оролцох” эрх, эрх чөлөө нь Монгол Улсын (хөгжлийн бэрхшээлтэй гэдгээс үл хамааран) иргэний баталгаатай эдлэх улс төрийн эрх, эрх чөлөөний гол “цөм” нь бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэж баталгаажуулсан байна. Иргэн төрийг удирдахад оролцох эрхээ төрийн бүх шатны байгууллагад төлөөлөгч сонгох, өөрөө төрийн албан тушаалд сонгогдох буюу томилогдох, ард нийтийн санал асуулгад оролцох зэргээр хэрэгжүүлж байна. Монгол Улс дахь “сонгох, сонгогдох” эрхийн харилцааг сонгуулийн нэгдсэн хууль (consolidated electoral law)-аар зохицуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгуульд нэрээ дэвшүүлэх замаар төрийн үйл хэрэгт оролцох боломжийг “жигд” хангах хөшүүрэг болсон зохицуулалтыг бэхжүүлсэн байна. Ийнхүү Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд (хөгжлийн бэрхшээлтэй) иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангах боломжийг бүрдүүлсэн гэж үзэж болох юм. Энэ үндсэн дээр сонгуулийн хууль тогтоомж төдийгүй олон нийтийн зүгээс “хууль тогтоох байгууллагаас сонгуульд оролцох эрхтэй бүх сонгогчдын жинхэнэ оролцоог хангахад (Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн эрхийн тухай олон улсын (2002) хэм хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сонгуулийн үйл явцад ижил тэгш эрхтэй оролцуулахыг чухалчлан заасан) чиглэсэн үйлчилгээ явуулахыг улам бүр хурцаар шаардах болсон байна. Ийм оролцоог өргөжүүлэхэд чиглэсэн үйлчилгээ өндөр өртөгтэй байдаг учраас энэ асуудлыг хууль тогтоогчид “төсвийн” хязгаарлагдмал байдалтай уялдуулан авч үзэх хэрэгтэй” хэмээн үзэж байна. Намуудын сонгуулийн зардлын зарим

тайлангуудаас үзвэл, Нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах, нэр дэвшигчийг сурталчлах, уулзалт, хурал цуглаан зохион байгуулах, ажилтан, ухуулагч, шадар туслагчийн хөлс, урамшуулал, бичиг хэрэг, шуудан холбоо, шатахуун, унаа, томилолт, бусад гэсэн хэсгээс сонгуулийн зардал нийтлэг байдлаар бүрдэж, үүнд нэр дэвшигчийн “хувийн онцлог” байдалд холбогдох нэмэлт зардал тусгагдаж байгаагүй байна. Энэ байдлыг арилгах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдоход нь улс төрийн нам, эвсэл дэмжих үүрэг хүлээхийн зэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгах тухай эрх зүйн зохицуулалтыг хөшүүргийг Монгол Улсын сонгуулийн тухай хуульд бүрдүүлсэн боловч энэ нь бодит амьдрал дээр төдийлөн хэрэгжиж чадахгүй байна. Түүнчлэн сонгуулийн арга хэмжээ нь аливаа ардчилсан төрийн үндсэн чиг үүрэг тул холбогдох сонгуулийн байгууллагуудын хувьд “төрийн” санхүүжилтийн үндсэн эх үүсвэртэй холбон үзэх жишиг зарим улсад тогтсон байдаг байна. Ийм учраас холбогдох сонгуулийн байгууллага бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийнхээ “хувийн онцлог шинж” байдалд тулгуурлан, хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгуульд нэр дэвшвэл түүнд тохирсон байдлаар хандах шаардлагатай болсон байна. Ард түмнээс сонгогдон байгуулагдсан байгууллагад хүлээлгэсэн эрх мэдэл нь нэг талаас, сонгуулийн утга учрыг тодорхойлох тул Монгол Улсын Их Хурлыг төрийн дээд байгууллага гэж үзээд байгууллага дахь зан төлөв, харилцааны хэв шинжийн үүднээс авч үзвэл, аливаа байгууллагад зөвхөн дан ганц мэдлэг, мэргэжилтэй ажилтан бус, харин бүх талаар хөгжсөн “бие хүн” хэрэгтэй гэж үздэг. Өөрөөр хэлбэл, нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй бүтээлч оролцдог ухамсарт хүн болох талаас нь авч үзсэн байна. Тиймээс эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг “нийгмийн бүх бүлгийн төлөөлөл” шийдвэр гаргах түвшинд гарвал ямар ач холбогдолтой, нийгэмд ямар эерэг үр нөлөө үзүүлэх талаар хөндөх зайлшгүй хэрэгтэй болжээ.

ДҮГНЭЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн сонгуульд нэр дэвшиж, цаашлаад Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломж эрх зүйн хувьд нээлттэй боловч “хөгжлийн бэрхшээлтэй иргэн Монгол Улсын Их Хуралд сонгогдох боломж хязгаарлагдмал байна” гэж үзлээ. Хууль зүйн үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох

эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдоход нь улс төрийн нам, эсвэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй гэсэн боловч энэ нь бодит амьдрал дээр төдийлөн хэрэгжиж чадахгүй байна. Энэ үндсэн дээр “Үндсэн хуулиар тодорхойлогдсон сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд нь иргэн бүрийг “тэгш” хамруулах үүднээс Монгол Улсын Их Хурлын сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэн нэр дэвших болон сонгогдоход “тодорхой” квот тогтоож болох юм” гэж үзэж байна.



Ц.ДЭЛГЭРЖАРГАЛ

Удирдлагын академийн багш,
доктор, дэд профессор

Иргэдийн оролцоо - орчин үеийн хэлбэрүүд

Сүүлийн жилүүдэд манай улсад иргэдийн оролцоо ихээхэн анхаарал татсан сэдвийн нэг болсон. Төрийн захиргааны байгууллагууд иргэнд илүү ойр, нээлттэй, ил тод үйл ажиллагаа явуулах, аливаа бодлого, шийдвэрийг гаргах, хэрэгжүүлэхдээ иргэний оролцоог хангахыг хичээх болсон. Иргэний оролцоо гэдэг нь төрийн байгууллага, албан тушаалтнууд шийдвэр гаргахдаа иргэдийг сонсох, зөвлөлдөх, тэдний санал хүсэлтэд үндэслэх болон иргэдэд тайлагнах зэргээр хамтран ажиллаж, асуудлыг шийдвэрлэхийг хэлнэ. Гэхдээ өнөөдөр иргэний оролцоог хангаж байгаа хэлбэр, үйл ажиллагаа нь харилцан адилгүй, үр дүн нь хүссэн хэмжээнд хүрэхгүй байна. Иргэдийн оролцоо нь өөрөө аяндаа хэрэгжиж, үр дүн нь шууд гардаг үзэгдэл биш тул тодорхой хэмжээнд зохион байгуулалт, хөрөнгө мөнгө, хариуцах эзэн, оролцогчдын аль алиных нь зүтгэл шаарддаг¹.

Нөгөө талаас иргэдийн оролцоо үр дүнтэй байхад түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгслүүд, технологи нь ихээхэн

нөлөөтэй. Иргэнийн оролцооны арга хэрэгсэл нь асуудлын талаарх мэдээлэл авах, өгөх, санал асуулга авахаас эхлэн шийдвэр гаргах эрх олгож, иргэд хамтран шийдвэр гаргах хүртэлх олон янз байдаг. Жишээлбэл, иргэдийн санал асуулга, санал хураалт, хамжих засаглал, зөвлөлдөх ардчилал, иргэний танхим, иргэний оролцоот төсөв, оролцоот төлөвлөлт /interactive planning/, тоглолтын арга /тодорхой бүлгийн хүмүүсийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх/ болон иргэд улс төрийн сонгуульд саналаа өгөх, жагсаал цуглаанд оролцох, тодорхой асуудлаар гарын үсэг цуглуулах, иргэдийн хурал, захиргааны байгууллагуудад өргөдөл гарган хүсэлт тавих гэх мэт олон арга хэлбэрээр захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож болно.

¹ Иргэний оролцоо-II төсөл (2019). Иргэний оролцоо. Гарын авлага. УБ. хууд 44.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ХӨГЖИЛ

Монгол улсын хувьд иргэдийн оролцооны чиглэлээр сүүлийн 30 жилд өрнөсөн үйл явцыг, оролцооны хэлбэрүүдийг тоймлон авч үзвэл дараах дөрвөн үе шатанд хуваан авч үзэж болох юм.

Нэгдэх үе (1990-2000 оны эх). Энэ үе шатыг иргэний оролцооны шаардлага, ач холбогдлыг ухаарч ойлгосон анхны алхам гэж болно. Учир нь ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдан, анх удаа сонгууль явуулж, ардчиллыг ухаарч ойлгосон нь чухал явдал болсон. Мөн 1995 онд “Ард нийтийн санал асуулгын тухай хууль” батлагдсан. Энэ хууль одоо хүчин төгөлдөр үйлчилж буй, гэхдээ одоог хүртэл хэрэглэгдээгүй байгаа. Энэ үеийн иргэдийн оролцооны хэлбэр харамсалтай нь сонгуульд оролцох төдийхнөөр хязгаарлагдаж байв. Өөр бас нэг хэлбэр бол иргэдийн нийтийн хурал юм. Үүнийг Үндсэн хуулинд “Нутгийн өөрөө удирдах байгууллага бол...баг, хороонд иргэдийн нийтийн хурал, тухайн хуралдааны чөлөөт цагт түүний тэргүүлэгчид мөн” гэж заасан байдаг.

Хоёр дахь шат (2003-2008), иргэдийн идэвх оролцоо идэвхжсэн үе гэж үзэж болно. 2003 оноос иргэдийн идэвх, оролцооны асуудал өргөнөөр хэлэлцэгдэж, иргэний нийгмийн байгууллагууд төлөвшиж албан зохион байгуулалтын хэлбэрт орж, 2008 онд Засгийн газартай хамтран ажиллах Иргэний нийгмийн зөвлөл байгуулагдав. Улмаар төрийн

зүгээс иргэдийн оролцоог дэмжсэн хөтөлбөр, төсөл, бодлогын баримт бичгүүд гарсан. 2008-2012 оны МУ-ын 3Г-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасаны дагуу “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсвийн гүйцэтгэлд мониторинг хийх үйл ажиллагаанд төрийн бус байгууллагуудыг оролцуулах, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагааг эрчимжүүлэх тухай” 3Г-ын 2008 оны 3 сарын 12-ны өдрийн 93 дугаар тогтоол гарсан нь ололт байсан.

Гурав дахь үе (2008-2015), энэ үеийг иргэдийн оролцооны өрнөл гэж болно. 2009 онд иргэдийн санаа бодлыг сонсох, тэднийг шийдвэр гаргахад оролцуулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Иргэний танхим” байгуулсан, “Төсвийн тухай хууль”-аар “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн мөнгийг тухайн орон нутаг юунд зарцуулахаа иргэдээсээ асууж эрэмбэлэн шийддэг болсон. Ийнхүү төр иргэдийн өмнө хүлээх үүрэг, мөн иргэд хууль боловсруулах, төр, орон нутгийн шийдвэрт нөлөөлөн оролцох үүрэгтэйг тунхаглан иргэдийн оролцооны суваг, боломжийг олгож хоёр талт урсгалт хамтын ажиллагааны суурь тавигдсан.

Дөрөв дэх шат (2015 оноос - өнөөг хүртэл), энэ үеэс иргэд болон төр засаг аль аль тал нь иргэний оролцоог бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд эрх зүйн орчныг сайжруулахад анхаарч, олон улсын болон төр, төрийн бус байгууллагууд чамгүй их судалгаа хийв. Үүний үр дүнд сүүлийн 10 жилийн хугацаанд иргэний оролцооны чанарт ихээхэн нөлөөлсөн

Нийтийн сонсголын тухай хууль (2015), Хууль тогтоомжийн тухай (2015), Захиргааны ерөнхий хууль (2015), Зөвлөлдөх санал асуулгын тухай (2017), Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай (2011), Шилэн дансны тухай (2014), Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай (2015), Хот суурины газрыг дахин хөгжүүлэх тухай (2015), Төсвийн тухай (2011) зэрэг хуулиуд батлагдсан. Энэ бүхний үр дүнд иргэдийн идэвхи сэргэж төр, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд оролцох нь улам бүр нэмэгдсээр байна.

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ХЭЛБЭРҮҮД

Энэхэсэгт онолномлолд суурилагаасаа илүүтэй орчин үед улс орнууд иргэдийн оролцооны ямар хэлбэрүүдийг үр дүнтэй гэж үзэж, хэрэгжүүлж байгаа талаар өгүүлэе. Иргэдийн оролцоо гэдэг нь зөвхөн иргэний зүгээс гардаг нэг чигийн урсгалтай үйл явц биш, төр ба иргэн хоорондын хамтын ажиллагаа, зөвлөлдөх, түншлэх замаар иргэд шийдвэр гаргах бүх үйл явц ба үр дүнг нь хянахад оролцох тухай ойлголт байдаг. Ардчилсан нийгэмд иргэдийн оролцоо нь сонгуульд саналаа өгч, төр засгаа байгуулах улмаар төрийн бодлого боловсруулах, төсөв батлах ба хэрэгжүүлэхэд оролцох, үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих, хариуцлага тооцох механизмаар дамжин хэрэгждэг.

Иргэдийн оролцооны үндсэн хэлбэр нь хуулиар тогтоосон албан ёсны оролцоо болон сайн дурын болон албан бус оролцоо гэсэн хоёр

хэлбэр байдаг. Ихэнх улс оронд шийдвэр гаргах үйл явцад иргэдийг албан ёсоор оролцуулах асуудлыг хуульчилсан байдаг. Хуульчлахдаа шууд оролцооны арга хэрэгслээр, эсвэл тодорхой асуудлаар шийдвэр гаргалтад заавал оролцуулж байхаар заадаг. Жишээлбэл, иргэд төлөөллийн байгууллага, захиргааны байгууллагад өргөдөл, санал гаргах, хүсэлт тавих хэлбэрээр оролцдог. Энэ нь иргэд ямар үе шатанд хэрхэн оролцох болон ямар хил хязгаарыг давахгүй байх, ямар асуудалд оролцох зэргийг нарийн тодорхой зохицуулдаг байна. Харин иргэдийн албан бус оролцоо нь ихэнх тохиолдолд өөрсдийн санаачилгаар зохион байгуулагддаг. Тиймээс иргэдийн саналыг аль болох шийдвэрт тусгаж байх нь тэднийг идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Манай оронд сонгуульд оролцохоос гадна иргэдийн нийтийн хурал, цаг үеийн асуудлаар болдог багийн иргэдийн хурал зэрэг албан ёсны оролцооны хэлбэрүүд бий. Түүнээс гадна хот айл, саахалтын хэлбэрээр ажлаа зохион байгуулж, асуудлаа хамтран шийдвэрлэдэг, бэлчээр ашиглалт, байгаль хамгаалал, мал угаах зэрэгт хамтран ажилладаг баялаг туршлага бий. Сүүлийн үед хоршоолол, нөхөрлөл зэрэг хамтын үйл ажиллагааны хэлбэрүүд буй болж байгааг бас ашиглаж болох талтай юм.

ГАДААД ОРНУУДЫН ИРГЭДИЙН
ОРОЛЦООНЫ ХЭЛБЭРҮҮД

Иргэдийн оролцооны олон арга хэрэгслүүд байдаг бөгөөд арга хэрэгсэл бүр тодорхой зориулалт, зорилго, нарийн зохион байгуулалт, дараалал,

хэрэглэгддэг түгээмэл аргууд бий. Үүнийг хүснэгтээр үзүүлье (хүснэгт 1). Мөн нийтийн санал асуулга, иргэдийн хурал, тогтмол уулзалт, иргэдийн төлөөлөл бүхий зөвлөл, шуудангаар асуулга авах, бүлгийн ярилцлага,

Хүснэгт 1. Дэлхий улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг иргэдийн шууд оролцооны арга хэрэгсэл

АРГА ХЭРЭГСЭЛ	ЗОРИЛГО	ГОЛ АСУУДАЛ	ХАМРАХ ХҮРЭЭ	УЛС
Зөвлөлдөх санал асуулга (deliberative pooling)	Мэдээлэл өгч, иргэдээс санал авах	Иргэдийн сонирхсон асуудлууд	Тухайн улс үндэстний болон орон нутгийн түвшний асуудлууд	Бүх улс, гол төлөөлөл: АНУ
Иргэдийн оролцоот төсөв	Шийдвэр гаргагч, мэргэжилтнүүдийн зөвлөгөөг сонсох, зөвлөлдөх, иргэдийн шийдвэр	Орон нутгийн санхүү	Орон нутгийн түвшний асуудлууд	Бүх улс
Иргэдийн зөвлөл	Шийдвэр гаргагч, мэргэжилтнүүдийн зөвлөгөөг сонсож, олон нийтийн хэлэлцүүлгийг явуулах, хэлэлцүүлэгт нөлөөлөх	Орон нутгийн тодорхой асуудлууд болон төлөвлөгдсөн ажлууд	Орон нутгийн түвшний асуудлууд	Жишээ нь: Австрали, АНУ
Талбайн нээлттэй конференц	Иргэд, нийгэмд нөлөөлөх	Хөндөгдөж буй бүх асуудлуудын талаар санал санаачилгыг авах	Орон нутгийн болон үндэсний хэмжээний асуудлууд	Дэлхий даяар,
Төлөвлөлтийн арга	Иргэд, нийгэмд нөлөөлөх, зөвлөлдөх	Орон нутгийн болон бүс нутгийн тодорхой асуудал, төлөвлөлтийн асуудлууд	Орон нутгийн болон бүс нутгийн асуудлууд	Их Британи, ХБНГУ

цаг хугацаа, оролцогчдын тоотой байдаг (Батсүх.Ш, Долгоржав.Я, Ганцоож.Б, 2014, хуудас 21) байна. Мэдээж иргэдийн оролцооны түвшин, цар хүрээ, хэлбэр нь улс орон бүрт харилцан адилгүй байх нь тухайн улсын улс төрийн тогтолцоо, соёл, иргэдийн сэтгэлгээний онцлогоос ихээхэн хамааралтай байдаг. Ерөнхийдөө улс орнуудад

түүвэр судалгаа, цахим оролцоо, хот айл, үндэстэн ястны бүлгээс санал авах, хөршийн холбоогоор санал авах, иргэн санаачилгаараа оролцох гэх мэт аргуудыг өргөнөөр хэрэглэж байгаагаас хамгийн үр дүнтэй хэрэгждэг хэлбэр бол судалгаанд хамрагдсан хотуудын 26 хувь, улс орнуудын 24 хувь нь нийтийн санал асуулгыг хамгийн үр дүнтэй арга гэж сонгон хэрэгжүүлж байна².

² Berner, 2001. Spring

Сүүлийн жилүүдэд мэдээлэл, холбооны технологийн хөгжил нь иргэд төр засгийн үйл ажиллагаанд оролцох, саналаа илэрхийлэх, олон нийтийн сүлжээгээр хэлэлцүүлэг хийх зэрэг шинэ хэлбэрүүд нэвтэрч байна. Хүн ам ихтэй, өргөн уудам нутагтай, төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагааг тэр бүр хүргэх боломж хомс зарим орнуудад цахим оролцоо (e-participation)-ны аргыг хэрэглэх хандлага өргөжиж байна. Иргэд шийдвэр гаргах үйл явцад цахим хэлбэрээр оролцох тухай санаачлага 2000 оны эхээр АНУ, Европт бий болсон ба төр, иргэдийн хоорондын харилцааг ойртуулах, хялбарчлах, мөн шийдвэр гаргах үйл явцыг түргэтгэхэд үр дүнгээ өгч эхэлсэн байна.

ДҮГНЭЛТИЙН ОРОНД ...

Төр, захиргааны шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах нь зөв шийдвэр гаргах, хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэхэд нөлөөлнө. Гэвч иргэдийн оролцооны ямар хэлбэрийг хэрэглэх нь улс орон бүрт харилцан адилгүй байх ба тухайн улсын улс төрийн тогтолцоо, соёл, иргэдийн сэтгэлгээний онцлог, боловсролын түвшнээс ихээхэн хамааралтай. Манай улсад дэлхийн улс орнуудын хандлагын нэгэн адил цахим оролцоог дэмжиж байгаа. Гэхдээ нийгмийн бүлгүүдийн ялгаатай байдлыг харгалзан үзэх ёстой. Боловсрол мэдлэгтэй, цахим орчноос шуурхай мэдээлэл авч чаддаг хэсэг болон чаддаггүй бүлэг манай нийгэмд байгааг мартаж болохгүй. Иймээс төр мэдээлэл түгээх, иргэдийн оролцоог

хангахдаа зөвхөн цахим суваг ашиглаад нийгэмд хүргэсэн гэж үзэж болохгүй. Мэдээлэл дутуугаас болж хамгийн ихээр хохирдог нийгмийн бүлэг бол орлого багатай, эмзэг бүлгийн, өндөр настай, алслагдмал амьдардаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг. Монгол улс хүн амаа бичиг үсэгтэн болгоход өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа, хөдөлгөөнүүдийг өрнүүлсэн. Түүний үр дүнд Монгол улсын хүм ам бичиг үсэгтэн болж чадсан. Энэ туршлага маань бидэнд хүн амаа дижитал тайлагдалт, дижитал соёлыг түгээхэд туршлага болох юм. Энд цахим оролцоог зөвхөн технологи биш соёл болгож төлөвшүүлэх, түүний тулд нийтээрээ цахим платформ, апп, сайтуудыг хэрэглэж чаддаг болох асуудал чухал юм. Хүн чаддаг зүйлээ түлхүү ашигладаг. Тиймээс бид дижитал шилжилтийг удаан бөгөөд тогтвортой хийж байгаа ч илүү эрчимжүүлэх шаардлага тулгарч байна. Төр, захиргааны байгууллагууд цахим оролцоооны шийдлийг илүү хялбарчлах, иргэдэд ойлгомжтой болгоход анхаарах хэрэгтэй. Тухайлбал, заавал апп суулгаж оролцох үйлдлийг багасгах. Энэ нь иргэдэд илүү ойлгомжгүй байна. Ядаж л бид цахим иргэний үнэмлэхээ энд ашигладаг болох хэрэгтэй юм. Дижитал соёл нь хэрэглэгч төвтэй байх буюу тэдэнд хэрэглэхэд хялбар байх, датад суурилсан шийдвэр гаргалт, хамтын ажиллагаа, нээлттэй соёл, дижитал сэтгэлгээ болон хурдтай, уян хатан арга барил гэж ойлгож болно.



С.ГАНЗАЯА

Конрад-Аденауэр-Сангийн
хөтөлбөрийн менежер

Улс төрийн боловсрол ба ардчиллын хөгжил

БАРУУН ЕВРОП, ХӨГЖИНГҮЙ ОРНУУД: ЭДГЭЭР ҮГИЙГ СОНСОХОД ЯМАР ОЙЛГОЛТУУД ТӨРЖ БАЙНА?

Техник, технологи, хөгжил, хүний эрх, нийгмийн төгс шахуу тогтолцоо. Аль ч талаар жишиг болсон эдгээр орнууд энэ их амжилт, эдийн засгийн чадавхид яаж хүрснийг түүхийн ой санамжийг ухраан нэг үзье. Аливаа хөгжилд тогтвортой болон байнгын гэсэн ухагдахуунууд хөгжлийн салшгүй хэсэг болдог. Тэртээ 1700-д оны сүүлээр францчууд хамжлагат ёсыг халах тэмцлээс өнөөгийн ардчилал, хүний эрхийг хамгаалах хөдөлгөөнүүд үүсэж, тал бүрээр салбарлан хөгжжээ. Ийнхүү шинэ үеийн ардчилал нь 100 гаруй жилийн хөгжлийн түүхтэй аж.

МОНГОЛ ОРОН АРДЧИЛЛЫН ТҮҮХЭЭ ХЭДИЙД ЭХЛЭВ?

Манай улс 1990-ээд оноос хойш ардчиллыг үндсэн зарчмуудын дагуу хөгжүүлж ирсэн, нийгэм- эдийн засгийн тогтолцоо, гадаад харилцаандаа олон бахархам амжилт олсныг дурдах ёстой бөгөөд шилжилтийн орнуудтай харьцуулахад ардчиллын үлгэр жишээ оронд тооцогдох хэдий ч бид өнөөдөр улс орныхоо хөгжилд, өдөр тутмын амьдралдаа сэтгэл хангалуун биш байгаа нь нууц биш. Харин нааштай нэг мэдээ нь Монгол Улс удаан, зөрчилтэй ч гэсэн зөв замаар явж буйг Бертельсманн Сангийн шилжилтийн индекс¹ харуулна. Энэхүү судалгаагаар Монгол улс 129 орноос 2015 онд 40-р байранд орж байсан бол 2019 онд 34-р байранд жагссан байна. Бид дээгүүр байранд жагсахгүй байгаагийн шалтгаан нь эдийн засгийн өсөлттэй байгаа ч зөвхөн тодорхой бүлэг хүмүүст баялаг хуваарилагдаж байгаа нь ардчилал эрсдэлд орсныг харуулж байгаа юм.

¹ Шилжилтийн индекс ВТИ 2019, Бертельсман сан,
<https://www.bti-project.org/de/index/status-index/>

Үүнээс ардчиллын ямар ч суурь ойлголтгүй байсан, хөрш гүрний социалист дэглэмийн нөлөөнд хамгийн удаан байсан улсын ард түмэн тогтолцоо өөрчлөгдөж, бүхнийг тэгээс эхэлсэн ч хамгийн хүнд хэцүү цаг үеэ давж туулсан байтлаа улам том үсрэлт хийх цаг үед бид яагаад хэт удаашралд оров гэсэн асуулт аяндаа урган гарах юм.

Засгийн газрын тогтворгүй байдал, улс төрийн намуудын санхүүжилтийн тунгалаг бус байдал, төрийн албаны халаа солио, залуучуудын зарим бүлгийн улс төрийн идэвхи сул, заримынх нь гажуудсан байдалтай байгаа гэх мэт олон нөхцөл үүнд нөлөөлж байна. Залуучуудын улстөрийн оролцооны эл хоёр гажуудал нь тэдний улс төрийн боловсрол дутагдалтай байгаагаас үүдэлтэй байна.

ЯАГААД УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Улс төрийн боловсрол, иргэдийн оролцоо болон улс төрийн намын төлөвшил нь ардчиллыг тогтворжуулж, улс орныг унан доройтох аюулаас хамгаалж байдаг. Иймд иргэдийн улс төрийн боловсролыг хангах, урьдач нөхцлийг бүрдүүлж, хөгжүүлэх нэн чухал юм. Улс орныхоо Үндсэн хуулиар тогтоосон тогтолцоо, онцлогийг ойлгосон, улс төрийн мэдлэг, боловсролтой иргэд л улс төр, нийгмийн үйл явцад оролцож чаддаг. Дэлхийн II дайны дараа бүхий л талаараа унан доройтсон Германд улс төрийн сангуудыг байгуулах үеийн үндсэн зорилго нь улс төрийн боловсрол, улс төрийн соёлыг дэмжих асуудал байсан юм. Учир нь ардчилал бол заяагдмал биш (байнга хөгжүүлэх шаардлагатай) бөгөөд засаглалын ямар ч систем төгс ардчилсан байдаггүй. Тиймээс учир зүй нь олдохгүй мэт боловч цогц, түвэгтэй ардчилал нь оршин тогтноход улс төрийн наад захын боловсрол зайлшгүй шаардагдана.

Өдөр тутмын амьдралд гарч байдаг улс төрийн шийдвэрүүдийн цаад санаа, цаашдын үр дагаврыг иргэд мэдэж, тооцож, шаардлагатай тохиолдолд бодлогод оролцох учиртай юм. Иргэд мэдээлэлгүйгээр, тэдний оролцоогүйгээр шийдвэр гарч байвал тэр нийгэмд ардчилал хэлбэр төдий л оршин байгаагийн илрэл.

АРДЧИЛАЛД ТӨЛӨВШСӨН ИРГЭД ХЭРЭГТЭЙ БАЙДАГ: ТӨЛӨВШСӨН ИРГЭН ГЭЖ ХЭН БЭ?

Улс төр талаас нь харвал төлөвшсөн иргэн гэдэг бол Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө ухан ойлгож өөртөө болон улс орондоо үр ашигтайгаар эдэлж чаддаг, үүргээ ухамсарлан хэрэгжүүлж, хуулийг дээдэлдэг иргэн юм. Иргэдийн оролцоо хангагдах, иргэд шийдвэрт

нөлөөлөх бүхий л асуудлын нэгэн томоохон хүчин зүйл нь иргэд мэдээлэлтэй, улс төрийн боловсролтой байх явдал аж.

ХБНГУ нь ерөнхий боловсролын хичээлээр дамжуулан улс төрийн хичээлийн шаталсан сургалтыг явуулдаг. Энэ нь улс төрийг, ардчиллыг сонирхох мэдрэмжийг сэрээж, шийдвэрт нөлөөлж чаддаг, бодол санаагаа нийгмээсээ болоод орчин тойрныхноосоо айдасгүйгээр илэрхийлэх чадвартай, улс төрийн үйл явцыг ойлгодог, оролцдог иргэн төлөвшихөд нөлөөлдөг. Зөвхөн дунд сургуулийн хичээлээр зогсохгүй улс төрийн институцууд иргэдийн оролцооны боломжуудын талаар иргэдэд үндсэн мэдлэг олгодог. Герман улс нь эдгээр шаталсан сургалт, улс төрийн бүхий л төрлийн боловсролд зориулж тодорхой санхүүгийн эх үүсвэрийг төсөвтөө төлөвлөж, түүний дагуу зарцуулдаг. Улсын төсөв нь иргэдийн татварын мөнгөөр бүрддэг, энэ нь ид ажиллах насны залуучууд байнгын өндөр татвар төлсөөр тэтгэврийн насанд очиход эргээд өндөр тэтгэвэр авч ийнхүү нэгэнтээ нийгмийн хариуцлага, хамаарал үүсэж эргэх холбоосоор нийт систем эрүүл өнгөжин төлжин урагшилдаг байна.

Герман улс иргэдийн боловсрол болон судалгаанд 2019 онд 18,3 тэрбум евро² зарцуулсан байна. (Энэхүү мөнгөн дүнг Монгол болон



ХБНГУ-ын Боловсрол, судалгааны яам

<https://www.bmbf.de/de/der-haushalt-des-bundesministeriums-fuer-bildung-und-forschung-202.html>

бусад орны боловсролд зориулж буй төсөвтэй шууд харьцуулах боломжгүй юм.) Энэхүү зорилготой, системчилсэн сургалтын үр дүнд хүүхэд, залуучуудад танин мэдэхүйн чадавхи сууснаар иргэд улс төрийн тогтолцоо, олон улсын харилцаа, гадаад бодлого, нийгэм, эдийн засгийн талаар болон тэдгээрийн хоорондын уялдааг ойлгож мэддэг болно. Ялангуяа улс төрийн систем, түүний үйл ажиллагааны

² ХБНГУ-ын Боловсрол, судалгааны яам, <https://www.bmbf.de/de/der-haushalt-des-bundesministeriums-fuer-bildung-und-forschung-202.html>

талаарх мэдлэг чухал ач холбогдолтой.

Дараагийн алхам нь улс төрийн боловсролын үр дүнгээр иргэдийг үйлдлийн чадавхтай болгох бөгөөд энэ нь мэдлэг, чадамж гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Жишээлбэл иргэд үйл явцад өөрсдөө оролцох асуудал: Улс оронд тулгамдаж буй асуудлын талаар улс төрийн шийдвэр гаргах бол түүнийг хэн хариуцдаг, шийдвэр гаргах үйл явц хэрхэн явагддаг талаар мэддэг байвал иргэд үйлдлийн чадавхтай болно гэсэн үг.



Иргэдийн оролцоо

Улмаар иргэн улс төрийн тодорхой үзэл баримтлал, ойлголттой болж үзэл бодлоо хамгаалж, нотолж чаддаг болвол үйлдлийн чадавхтай болж байгаа юм. Ардчилал байнгын тогтвортой хөгжих явцад иргэд тухайн байгаа нийгэм, оршин буй засаглалын хэлбэрт нааштайгаар ханддаг байх нь бас чухал. Эдгээр чадварыг эзэмшсэнээр улс төрийн бодлогод идэвхтэй оролцож, урт хугацаанд нөлөөлөх нөхцөл бүрдэх юм. Улс төрийн боловсролын ачаар олон хүн улс төрийг ойлгодог болж, улс төрийн үйл явцад идэвхитэй оролцоно. Улс төрийн салбарт эдгээр чадавхийг буй болгож хөгжүүлснээр тухайн тогтолцоогоо хамгаалж, хэм хэмжээ, үнэт зүйлийг хүлээн зөвшөөрч, бататгана. Гэвч улс төрийн боловсрол түгээх, иргэд нь улс төрийн үйл явцад хангалттай хэмжээнд оролцоотой болох нь удаан хугацааны нөр их хөдөлмөр, зүтгэл байдаг бөгөөд үүний үр өгөөжийг өнөөдөр бид хүртэхгүй байж болох ч бидний дүү нар, хойч үе хүртэнэ.

Улс төрийн боловсролгүйгээр ардчилал оршин тогтнох боломжгүй юм. Тал нутгийн ууч сэтгэл, сэтгэлгээ нэвт шингэсэн, нүүдэлчин ахуйгаас өвлөгдсөн хүн хүнээ дээдлэх эрхэм ёстой улсын хувьд Азийн чадварлаг, ардчиллын үлгэр жишээ орон байх нь бидний холын биш ойрхны ирээдүй билээ.



ЦАХИМ ЗАСАГЛАЛ

Хөгжиж буй орнуудад цахим засаглалыг хөгжүүлэхэд тулгарч буй зарим
асуудлууд

Хиймэл оюун ухаан (AI) хүмүүсийн амьдралд нөлөөлөх нь



Г.ЗОЛЗАЯА

Отгонтэнгэр Их Сургуулийн багш

Хөгжиж буй орнуудад цахим засаглалыг хөгжүүлэхэд тулгарч буй зарим асуудлууд

Цахим засаглал нь зөвхөн уламжлалт мэдээллийг интернэтээр хүргэх, төрийн албан ёсны вебсайт, төрийн албан хаагчдад компьютер олгох, платформ үүсгэх зэргээр хязгаарлагдахгүй.

Цахим засаглал гэдэг нь төрийн мэдээлэл, үйлчилгээг цахимаар эсвэл бусад дижитал хэрэгслээр иргэдэд хүргэх юм. Хөгжингүй, хөгжиж буй орнуудад цахим засаглал үр өгөөжийн хувьд ижил байдаг бөгөөд иргэд, бизнес эрхлэгчид, төрийн байгууллагуудад олон давуу талтай. Тухайлбал, төрийн мэдээ, мэдээлэл, үйлчилгээг аль ч өдөр, хүссэн цагтаа авах боломжтойгоос гадна хүнд суртал, цаг хугацаа зарлагдахаас сэргийлдэг. Цахим засаглалыг хэрэгжүүлснээр төрийн үйл ажиллагааг хялбаршуулах, өртгийг бууруулах боломжтой. Өөрөөр хэлбэл, төрийн үйл ажиллагааг үр ашигтай, зардал багатай, ил тод, иргэдэд ойр байлгах үр дүнтэй арга бол цахим засаглал, төрийн цахим үйлчилгээ юм.

(Alawneh, Al-Refai, & Batiha, 2013; Venkatesh, Chan, & Thong, 2012).

Цахим засаглалыг хөгжүүлэхийн тулд улс орнууд өөр өөрийн стратеги, урт хугацааны бодлого боловсруулахаас гадна “Electronic readiness” буюу уг засаглалыг хэрэгжүүлэхэд бэлэн байдал хэмээгддэг мэдээлэл харилцааны технологийг ашиглан эдийн засаг, төрийн халамж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай чадвар, чадавхийг төгөлдөржүүлэхэд анхаарч байна. Цахим засаглалыг хэрэгжүүлэх үе шат олон янз байдаг ч НҮБ-ын ASPA судалгаагаар гарсан дараах үе шатууд түгээмэл юм. Үүнд,

1. “Emerging”- Цөөн хэдэн албан ёсны сайтуудаар дамжуулж төрийн мэдээллийг түгээх, мэдээлэл нь наад захын, хязгаарлагдмал шинжтэй.
2. “Enhanced”- Төрийн сайтууд нэмэгдэх, улмаар мэдээллүүд илүү төрөлжиж, динамик шинжтэй болох.
3. “Interactive”- Хэрэглэгчид


Хүснэгт 1: Уламжлалт болон цахим засаглалын ялгаа

УЛАМЖЛАЛТ ЗАСАГЛАЛ	ЦАХИМ ЗАСАГЛАЛ
Дээрээс доош шаталсан захиргаатай	Үйлчилгээний шатлалгүй
Үйлчлэгч төвтэй	Үйлчлүүлэгч төвтэй
Дүрэм журам, зөвшөөрөл зэрэг дээр суурилан шийдвэр гардаг	Нэгдсэн үйлчилгээтэй
Чиг үүргийг холбогдох газруудад хуваарилан гүйцэтгэдэг	Нэг газраас олон үйлчилгээ авах боломжтой
Удаан, хүнд суртал их	Түргэн шуурхай, ашиглахад хялбар

төрийн маягт, албан бичгийг цахим шуудангын хаягаар хүлээн авах, интернэтээр татаж авах боломжтой. Уулзалт хийх, санал

л ихэнх улс орнууд хангаж байгаа юм. Дани улс 2018 оны байдлаар иргэдийн 89% онлайн үйлчилгээ авдаг гэсэн үзүүлэлтээр цахим засаглалыг

Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI) /Бүс нутгаар/ 2018 оны байдлаар
(Эх сурвалж: United Nations E-Government Survey 2018)




хүсэлт өгөх зэргийг веб сайтаар дамжуулан харилцах, хийх боломжтой.


- 4. “Transaction”- Үйлчилгээний төлбөр, гүйлгээг онлайнаар хийх.
- 5. “Seamless”- Онлайн үйлчилгээг төрөлжүүлэх, төгөлдөржүүлэх.

Хөгжиж буй орнуудад сүүлийн 20 жилд төрийн салбарыг шинэчлэх чиглэлээр бага зэрэг ахиц гарсан ч хөгжил удаашралтай байна. Дээрх үе шатуудаас эхний хоёр үе шатыг

тэргүүлдэг. Хөгжиж буй орнуудын нэг болох Египет улс иргэдийн 2% цахим үйлчилгээг ашиглаж байна. Манай улсын хувьд 2018 онд Цахим засаглалын индекс (E-Government Index)-ээр 193 улсаас 0,58 оноогоор 92

(Эх сурвалж: UN E-Government Development Index, August 27, 2018)





дугаар байранд жагссан. Тус индексийг гаргахад дөрвөн гол индексээр хэмждэг нь: 1. Хүний нөөцийн индекс (Human capital index), 2. Цахим оролцооны индекс (E-participation index), 3. Цахим үйлчилгээний индекс (Online service index), Харилцаа холбооны дэд бүтцийн индекс (Telecommunication infrastructure index) зэрэг юм.

Дээр дурдсан дөрвөн үзүүлэлтүүдээс

КАТЕГОРИ	СААД БЭРХШЭЭЛ
ТЕХНИКИЙН	- Мэдээлэл харилцаа холбооны технологийн дэд бүтэц - Нууцлал - Аюулгүй байдал
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН	- Менежмент - Хамтын ажиллагаа - Боловсон хүчин - Удирдлага, ажилчид, иргэдийн технологийн мэдлэг, ур чадвар
НИЙГМИЙН	- Хууль, эрх зүйн зохицуулалт - Нийгмийн хуваагдал, талцал - Соёл
САНХҮҮГИЙН	Өртөг өндөр³

графикт үзүүлснээр Хүний нөөцийн индексийн хувьд Монгол улс Цахим засаглалын индексийн үзүүлэлтүүдийн хувьд бусад гурван индексээс хамгийн өндөр үнэлгээтэй байгаа боловч 2004 онд 0.87 байсан бол 2014 онд 0.91, 2018 онд 0.74 үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл манай улсын давуу тал хүний нөөц байгаа боловч тоон үзүүлэлт жил ирэх тутам буурч байна.



Цахим оролцоо 2008 оноос хойш эрчимтэй нэмэгдэж байгаа мөн Цахим үйлчилгээний үзүүлэлт 2004 онд 0.19 байсан бол 2018 онд 0.6 индекс болж өссөн нь сайшаалтай юм. Харин манай улсын анхаарах шаардлагатай гол индекс бол Харилцаа холбооны дэд бүтцийн асуудал юм. Уг индекс нь таван үзүүлэлтээс бүрддэг. Үүнд: 100 хүн тутамд ногдох интернет хэрэглэгчийн тоо, 100 оршин суугч тутамд суурин утасны шугам, 100 хүн тутамд ногдох гар утасны хэрэглэгчдийн тоо гэх мэт. Нийслэл хотод дээрх үзүүлэлтүүд сайн боловч хөдөө орон нутагт харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх ажил удаашралтай байна. Монгол улсын цахим засаглалын индексээр 2010 онд 53 дугаарт, 2014 онд 65 дугаарт,

2018 онд 92 дугаарт эрэмбэлэгдсэн буюу жилээс жилд буурч байгаа гол шалтгаан нь дэд бүтцийн хөгжил удаашралтай байгаатай холбоотой юм. Ялангуяа бүс нутгийн улс орнуудаас хөгжлийн хувьд ганцаар хоцрох эрсдэл бий болоод байна.

ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД

Стандарт, техникийн дэд бүтэц, хувийн нууцлал, аюулгүй байдал, хараат бус байдал зэрэг нь цахим засаглалд тулгамдаж буй томоохон бэрхшээл юм. Үүнээс гадна 1000 хүнд ногдох компьютерийн тоо 416 байгаа бол бага орлоготой орнуудын хувьд уг харьцаа нь 1000 хүн тутамд 6 байна⁴. Мөн компьютерийн тоног төхөөрөмж. Цахим бэлэн байдал, мэдээллийн технологи, бичиг үсгийн мэдлэг, дижитал төхөөрөмж ашиглах, нэвтрэх, удирдах, мэдээллийг үнэлэх чадварыг олгох шаардлага зүй ёсоор бий болж байна.

Нууцлалын зохих түвшний баталгаа, мэдээллийг хамгаалахтай холбоотой хувь хүний хувийн нууцыг хамгаалах, цахим засаглалыг ашиглахад итгэх итгэлийг нэмэгдүүлэх, иргэдийн нэр, хаяг, утасны дугаар, хөдөлмөрийн түүх, эмнэлгийн бүртгэл ба эд хөрөнгийн бүртгэлийг төрөөс ашиглахад шаардлагатай хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгоход бэрхшээл үүсч байна.

ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

Манай улс цахим засаглалыг

хөгжүүлэхийн тулд Цахим засаглал Үндэсний хөтөлбөр, Бүгд Найрамдах Эстони Улсын Цахим засаглалын академи байгууллагуудын хооронд “Хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж, цахим татварын нэгдсэн системтэй болсон гэх мэт ажлууд хийгдэж байгаа ч сайжруулах олон асуудал байсаар байна. Дижитал шинэчлэл нь урт хугацааны хүчин чармайлт, тууштай байдал, манлайллыг шаардахаас гадна дараах арга замуудыг ашиглах боломжтой юм.

Олон нийтийн салбарын шинэчлэл: Нордикийн орнуудын цахим засаглалын ололт амжилт нь олон нийтийн салбарын өргөн цар хүрээтэй шинэчлэлийн үр дүн бий болсон байна. АНУ-д гэмт хэргийн гаралтыг бууруулсан цагдаагийн хэлтсийн мэдээллийн технологид оруулсан хөрөнгө оруулалт нь байгууллагын зохион байгуулалтын томоохон өөрчлөлтөөс үүдэлтэй байв.

Иргэдийн оролцоо: Цахим засаглалыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах, санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах нь чухал юм. Иргэд төртэй харилцан санал бодлоо солилцоход харилцааны холбооны бүхий л хэрэгсэл (захиа, утас, факс, и-мэйл, интернэт гэх мэт) ашиглах шаардлагатай. Нөгөө талаар хөгжиж буй орнуудын цахим засаглалын асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй стратеги нь техникийн дэд бүтцийг нийгэм, зохион байгуулалт, бодлогын өөрчлөлттэй хослуулах явдал чухал юм.

⁴ World Bank, World Development Indicators, 2003
<http://www.worldbank.org/data/wdi2003/>

ДҮГНЭЛТ

Дэлхийн олон оронд цахим засаглалыг нэвтрүүлж, хэрэгжүүлж эхэлснээр төрийн үйлчилгээний зардлыг бууруулах, үйлчилгээг сайжруулах, иргэд, албан хаагчдын цаг хугацаа хэмнэх, нийтийн салбарын үр ашгийг нэмэгдүүлэх, олон улсад өрсөлдөх чадварыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Цахим засаглал, интернэт нь нийгмийн бүтэц, үнэт зүйлс, соёл, бизнес явуулах арга хэлбэрүүдэд чухал өөрчлөлт оруулж байна. Үүнийг хөгжүүлэхийн тулд шинэлэг төслүүдийг хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг нэвтрүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, засгийн газрын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэний нийгмийг дайчлах зэрэг нь тэргүүлэх ач холбогдолтой юм.



Л.ГАЛБААТАР

**МУ-ын Шүүхийн ёс зүйн
хорооны гишүүн**

Хиймэл оюун ухаан (AI) хүмүүсийн амьдралд нөлөөлөх нь

Одоогийн хиймэл оюун ухааны талаар нэгдмэл тодорхойлолт байхгүй. Хиймэл оюун ухаан гэдэг нь оюун ухаан шаарддаг зүйлийг хийх чадвартай машины үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн шинжлэх ухаан, онол, арга техникийн ойлголтыг багтаасан ерөнхий нэр томъёо юм. Зарим судалгааны дүнгээс харахад, 2030 он гэхэд дэлхий даяар 800 сая ажилтан хиймэл оюун ухаан бүхий машинд ажлын байраа алдана гэсэн судалгаа гарсан байна. Үүнтэй уялдаатайгаар 2030 он гэхэд дэлхий даяар 375 сая хүртэлх хүн шинэ мэргэжлийн ангилалд шилжих шаардлагатай болж магадгүй байна.¹

Үүнтэй холбоотойгоор олон нийтийн дунд “Хиймэл оюун ухаан (Artificial intelligence) гэдэг нь манай цаг үеийн хөгжлийн гол технологи юм. Хиймэл оюун ухаан зөвхөн бидний хэрхэн амьдрах, харилцах, ажиллах, аялахыг өөрчлөхөөр хязгаарлагдахгүй бөгөөд хиймэл оюун ухаанд суурилсан шийдэл нь өвчин эмгэг, хуурамч мэдээллээс эхлээд цахим орчин дахь үзэн ядалт,

хот суурингийн хөдөлгөөн хүртэлх манай нийгмийн суурь асуудлуудыг засах болно” гэх ойлголт түгээмэл тархжээ.²

ОЛОН НИЙТИЙН ЭНЭ ОЙЛГОЛТ ХЭР ЗӨВ БЭ ГЭДГИЙГ ЭРГЭЦҮҮЛЬЕ.

Хиймэл оюун ухааны талаарх одоогийн сурталчилгаа нь хиймэл оюун ухаан өөрөө манай нийгмийн гол асуудлуудыг шийднэ гэх ташааралтай ихээхэн холбоотой. 2018 онд АНУ-ын Конгрессын сонсголын үеэр хуурамч мэдээлэл, үзэн ядалт, хувийн нууцлалтай холбоотой асуудал хөндөгдөхөд Фэйсбүүкийн гүйцэтгэх захирал Марк Зукерберг “үүнийг хиймэл оюун ухаан засна”, “ирээдүйд эдгээр асуудлыг шийдэх технологи бий болно” гэх хэллэгийг хэд хэдэн удаа ашигласан. Бусад салбарын бизнес эрхлэгчид, технологийн салбарын мэргэжилтнүүдийн амлаж буйгаар бол хиймэл оюун ухаан бүхий технологи, бүтээгдэхүүнүүд нь хавдрыг эрт оношлох, татварын луйврыг тодорхойлох, хот суурин газарт

тээврийн хэрэгслийг үр ашигтай чиглүүлэх, олон нийтийн газар дахь нийгмийн эсрэг, гэмт зан байдлыг тодорхойлох болно.


Нийгмийн асуудлыг технологи шийдэх болно гэсэн яриа нь технологи ба нийгмийн түүхэн дэх дахин давтагдах сэдэв болж байна. “Технологийн шийдэл” нь нийгмийн болон улс төрийн шинж чанартай асуудлуудад математикийн шийдлийг хайж байдаг.



- Өөрөө явагч тээврийн хэрэгсэл нь зарим шалгуураар бол хот дотор илүү аюулгүй зорчих боломжтой боловч хотын хүн амын өргөн хүрээг хамарч чадахгүй.
- Шүүлтүүрийн програм хангамж нь хуурамч мэдээлэл, үзэн ядсан үг хэллэгийг илрүүлэхэд илүү сайн байж болох ч, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх ба хор хөнөөлтэй үг хэллэгийн хоорондох тэнцвэрийг үргэлж төгс байдлаар, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд хангаж чадахгүй.

Эдгээр асуудал нь үндсэндээ нийгмийн шинж чанартай тул технологийн хувьд түүнд нэг л зөв хариулт байдаггүй.

“Хиймэл оюун ухаанаар эд зүйлсийг хийх” тухай яриа нь автомат байдлаар




ажиллах технологид суурилсан хүний хөдөлмөр, нийгмийн харилцаанд илүү хамаатай. Хиймэл оюун ухаанд суурилсан бүтээгдэхүүн нь ердийн байдлаар гарч ирэхгүй, хүний гараар бүтдэг. Өөрөө явагч тээврийн хэрэгсэл, дүрс илрүүлэх шийдэл гэх мэт хиймэл оюун ухааны ердийн төхөөрөмж, үйлчилгээ нь арилжааны ашиг сонирхол, норматив таамаглал бүхий компаниудын бүтээгдэхүүнүүд бөгөөд эдгээр шинжийг бүтээгдэхүүн өөртөө агуулсан болно. Үүнээс гадна, хиймэл оюун ухааны бүтээгдэхүүнүүд нь математикийн нарийн төвөгтэй загвар боловсруулах, зургаас зургийн хооронд дүрс таньдаг болох гэх мэтээс эхлээд хүний асар их хөдөлмөрийн үр дүн. Тиймээс, хиймэл оюун бүхий үйлчилгээ, төхөөрөмж нь тогтоосон шалгуурын дагуу ирээдүйд бүрэн ажиллагаатай байсан ч гэсэн “үүнийг хиймэл оюун ухаан засна” гэх хэллэг төөрөгдүүлсэн хэвээр байх болно. Асуудлын дийлэнх нь үндсэндээ нийгмийн шинж чанартай байдаг бөгөөд математикийн шийдлээс ангид байдаг. Хиймэл оюун ухааны технологи нь бие даасан хэрэгсэл биш, харин хүн ба нийгмийн бүтээсэн зүйл юм. Эндээс бодит үнэн тодорхой болж байгаа байх. Хиймэл оюун ухаан бүх зүйлийг

засч чадахгүй, харин хүн хиймэл оюун ухааныг ашиглаж зарим зүйлийг засах боломжтой байдаг. Хиймэл оюун ухааны технологи дахь хурдацтай хөгжил нь олон оролцогчдод нийгэмд тулгарч буй сорилтод хариу үйлдэл үзүүлэх боломжийг илүү олгодог. Эдгээр технологи нь нийгмийн олон салбарт шинэчлэл хийхэд хувь нэмрээ оруулж, бидний амьдрах хэв маяг, харилцаа холбоо, ажил, аяллын хэв маягийг өөрчлөх болно. Гэхдээ түүнийг автоматаар олон нийтийн сайн сайхны төлөө ажиллана гэж хэлэх боломжгүй.³ Хиймэл оюун ухааныг олон салбарт хэрэглэж буй боловч, хүний эрх, хувийн халдашгүй байдлыг хангахад зарим бэрхшээл учирч байна. Тухайлбал,

- Лондонд 1 хүнийг баривчлахын тулд 13,200 хүний царай скайнерджээ. Хүний царай төрхийн мэдээллийг цуглуулах нь хүний эрхэм чанарыг хөнддөг. Энэ жишээнээс харахад, хиймэл оюун ухаанд суурилсан царай таних технологийн тусламжтайгаар хүний эрхийг хамгаалахын тулд өөр хүний эрхийг бас зөрчиж байна⁵.
- АНУ-д тус улсын Стандарт, технологийн үндэсний судалгааны хүрээлэнгээс АНУ-ын Засгийн газрын одоо ашиглаж буй царай таних технологийн ашиглалтад судалгаа хийжээ. Ингэхдээ, нийт 8,49 сая хүний 18,27 сая

зургийн мэдээллийн санг судалсан байна. Судалгааны үр дүнд, Ази болон Африк гаралтай Америк хүмүүс, уугуул Америкчуудын царайг хиймэл оюун ухаанд суурилсан мэдээллийн санд буруу тодорхойлох явдал их байжээ. Үүний уршгаар буруу хүнийг гэмт хэрэгт сэрдэх, шалгах үр дагавартай байна.

Энэ мэт бодит асуудал байгаа тул Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (OECD) 2019.05.22-ны



өдөр баталсан анхны “Хиймэл оюуны ухааны бодлогын талаарх Засгийн газар хоорондын стандарт”-д дараах таван зөвлөмжийг өгсөн байна⁶:

- Хиймэл оюун ухааны судалгаа, хөгжилд хөрөнгө оруулах;
- Хиймэл оюун ухааны цахим экосистемийг дэмжих;
- Хиймэл оюун ухааныг дэмжих бодлогын орчныг бүрдүүлэх;
- Хүний чадавхийг бий болгож, хөдөлмөрийн зах зээлийн шилжилт-өөрчлөлтөд бэлтгэх;
- Хиймэл оюун ухаанд итгэх олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх⁷.

⁵ Facial recognition technology scans 13,200 people in London but results in just one arrest. @lizziedearden Tuesday 3 March 2020 19:30 <https://www.independent.co.uk/independentpremium/uk-news/facial-recognition-london-arrests-met-police-oxford-circus-westminster-a9373191.html>

⁶ A US government study confirms most face recognition systems are racist. MIT Technology Review. Artificial Intelligence Dec 20, 2019 <https://www.technologyreview.com/f/614986/ai-face-recognition-racist-us-government-nist-study/>

⁷ OECD. Recommendation of the Council on Artificial Intelligence <https://legalinstruments.oecd.org/en/instruments/OECD-LEGAL-0449>

Түүнчлэн, Европын холбооноос хиймэл оюун ухааныг ашиглахтай холбоотой ёс зүйн болон хууль зүйн зохих зохицуулалт бий болгохоор зорьж байна. Энэ хүрээнд 2020.02.19-ний өдөр Европын комиссоос хиймэл оюун ухааныг ашиглах итгэлцлийн орчин бүрдүүлэх “Цагаан ном” болон аюулгүй байдал, хариуцлагын асуудлаарх тайланг хэвлүүлжээ. Энэхүү “Цагаан ном”-д хиймэл оюун ухааныг хөгжүүлэх, нутагшуулах судалгааны ажлыг хөнгөвчлөх, гишүүн орнуудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ болон ирээдүйд Европын холбооны зохицуулах байгууллагаас холбогдох хууль зүйн шаардлага тогтоох, түүнийг хэрэгжүүлэх бодлогын хувилбарыг дэвшүүлжээ⁸. Харин дурдсан тайланд хиймэл оюун ухааныг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахдаа зорилтот болон эрсдэлд суурилсан арга замыг эрэлхийлэх, тодруулбал, хиймэл оюун ухааныг ялгаатай түвшинд хэрэглэхэд ялгаатай буюу харилцан адилгүй эрсдэл бий болж буйг харгалзан үзэх хэрэгтэй гэжээ⁹.

Үүний тулд, их өгөгдлийг нээлттэй, харилцан уялдаатай ашиглах эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хэрэгжүүлэх нь хиймэл оюун ухааны зүй зохистой, үр ашигтай хэрэглээ болох юм. Монгол Улсад хувийн өгөгдлийг хамгаалах хууль

тогтоомж байхгүй. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас “Өгөгдөл хамгаалах тухай” хуулийн төслийг 2018.09.24-ний өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд олон нийтэд хэлэлцүүлсэн¹⁰.

Тус хуулийн төсөлд:

- “өгөгдөл хариуцагч” гэж хуулиар эрх олгогдсоны дагуу, эсхүл өгөгдлийн эзнээс олгосон зөвшөөрлийн дагуу хувийн өгөгдлийг боловсруулах зорилго болон арга хэрэгслийг тодорхойлж буй төрийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн өмчит хуулийн этгээд, иргэн, байгууллагыг;
- “өгөгдөл боловсруулагч” гэж өгөгдөл хариуцагчаас өгсөн заавар, журмын дагуу хувийн өгөгдлийг боловсруулж буй төрийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн өмчит хуулийн этгээд, иргэн, байгууллагыг хэлнэ гэж тусгасан.
- энэ хууль батлагдахаас өмнө боловсруулсан хувийн өгөгдөлд өгөгдлийн эзний зөвшөөрлийг авахад энэ хуулийг хэрэглэнэ.

НҮБ-аас 2019 онд зохион байгуулсан “Интернетийн засаглалын форум”-ын үеэр, өгөгдөлд хандах, боловсруулах нь цөөн хэдэн томоохон технологийн компаниудын хүрээнд хамаарч буйг шүүмжилсэн бөгөөд жижиг бизнесүүд, хөгжиж буй орнуудад нийгмийн сайн сайхны төлөө өгөгдлийг харилцан хуваалцах,

⁸ European Commission. White Paper on Artificial Intelligence - A European approach to excellence and trust. Brussels, 19.2.2020

COM(2020) 65 final https://ec.europa.eu/info/files/white-paper-artificial-intelligence-european-approach-excellence-and-trust_en

⁹ European Commission. Report on safety and liability implications of AI, the Internet of Things and Robotics. Brussels, 19.2.2020

COM(2020) 64 final https://ec.europa.eu/info/files/commission-report-safety-and-liability-implications-ai-internet-things-and-robotics_en

¹⁰ Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл, 2019.09.24 <http://cita.gov.mn/wp-content/uploads/2018/09/ugugdul-hamgaalah-tuhai-huuli-in-tusul-1.pdf>

¹¹ IGF 2019. Best Practice Forum on Internet of Things, Big Data, Artificial Intelligence. Final BPF Output Report. January 2020. https://www.intgovforum.org/multilingual/filedepot_download/8398/1915

хамгаалах, нээлттэй өгөгдлийн үндсэн дээр хиймэл оюун ухааны үр шимийг бүгд хүртэх хэрэгтэйг зөвлөжээ¹¹. Өгөгдлийн хэмжээ их байх нь хиймэл оюун ухааны системийг хөгжүүлэхэд чухал хэдий ч, тухайн өгөгдлийн чанар чухал болохыг мартаж болохгүйг мөн зөвлөжээ. Үүнээс гадна, хувийн халдашгүй байдлыг хүндэтгэх, өгөгдлийн өмчлөл нь хиймэл оюун ухааныг хөгжүүлэхэд зүй бус саад болохгүй байх, өгөгдлийн хүртээмжийг сайжруулах, өгөгдлийг хуваалцах урсгалын үр ашгийг нэмэгдүүлэх нь хиймэл оюун ухаан бидний амьдралд эергээр нөлөөлөхөд шууд хамааралтайг НҮБ-ын “Интернетийн засаглалын форум”-ын тайланд дурджээ.

Товчхондоо, хиймэл оюун ухаан бол хүний удирдлага, зааварчилгаатайгаар хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулах технологийн багц шийдэл юм. Энэхүү эерэг талыг нь улам хөгжүүлэх, хиймэл оюун ухааныг сөргөөр ашиглахаас сэргийлэх нэг арга зам нь хиймэл оюун ухааныг ашиглахад баримтлах ёс зүйн дүрэм, эрх зүйн зохицуулалт болж байна.



А.ЭНХБАТ

ШУТИС, БХУС-ийн захирал
Доктор, дэд профессор

Монголчуудын мэдээлэл дамжуулах, түгээх технологи, тогтолцоо, цуу яриа

Монгол ардын “Алтан Гургалдай Хаан” гэдэг баатарлаг туульд их сонирхолтой мөрүүд бий. Хаан аян хийгээд бусдын албат ардыг хурааж аваад буцахдаа: “Би одоо түрүүлэе. Та нар миний гурвалжин зурсан газар үдлээд, дугуй зурсан газар хоноглоод, миний хойноос ирээрэй” гэж хэлээд яваад өгөв гэнэ хэмээн гардаг. Хаан газар орны бартаа саад, аюул, онцлогийн талаар мэдээллийг араасаа ирэх албат арддаа үлдээж байна. Энэ зан үйл бидний үеийг хүртэл уламжлагдан ирсэнгүй. Мөн Алтан Гургалдай хаан аян дайнд яваад нутагтаа иртэл амьтан хүн үзэгдэхгүй байв. Тэгээд гэрийнхээ бууцан дээр иртэл “Уяанаас нь алд шар бичиг уяатай байв гэнээ. Түүнийг очоод үзсэн чинь цэцэн гоо дагина хатны захиа байв гэнэ. Чи голомтоо хутгаж үзээд галаа унтарсан байвал миний хойноос битгий очоорой. Унтраагүй байвал миний хойноос очоорой. Ерэн таван толгойтой Ендэр хар мангастай нэгдэж суугаад явлаа шүү” хэмээн

тууль үргэлжилдэг. Энд захиа, бичиг сүүлд нэмэгдэж баяжигдсан байх. Гэхдээ ийм өгүүлэмж Монгол ардын баатарлаг туульсад элбэг тохиолдоно. Ямартаа газарт тэмдэг зурах, асаасан түүдэг галын нурам зэргээр мэдээлэл дамжуулж авч байсны балар эртний баримт. Хожим төр улс үүсэн хүчирхэг цэрэг армитай болсон нүүдэлчид дайны талбарт мэдээлэл солилцохдоо туг сүлдний хөдөлгөөн, их бага хэнгэрэг дэлдэх, бүрээ бишгүүр татах зэргээр олон хэмнэлтэй дуу авиа гаргах, янз бүрийн өнгөтэй утаа гаргах, дуут сум зэргийг өргөн ашигладаг байжээ. Энэхүү цэрэг эрсийг дайны талбарт удирдан мэдээллээр хангах технологи нь Монголчуудын байлдан дагуулалтын амжилтын нэгэн нууц байсан биз ээ. Харин өнөө үед ...

ОРЧИН ҮЕИЙН ТУХАЙ ЦУХАС ӨГҮҮЛЭХ НЬ

Мэдээл дамжуулах, түгээх гэхээр шууд л “цахим ертөнц”, “цахим улс төр” гэх ойлголтууд санаанд бууж байна. Энэ орчинд хэн их мэдээлэлтэй нь биш, харин хэн их мэдээлэл дамжуулж, түгээж байдаг нь бусдыгаа байлдан дагуулдаг. Олон нийтийн сүлжээнд дуу хоолойгоо өргөх нь хувь хүний эрх чөлөөний хамгийн том илрэл болон манай нийгэмд төлөвшиж байна. Төр засаг, цагдаа хүчний байгууллагууд ч гэсэн өөрсдийн албан ёсны цахим хуудастай болж, олон нийтийн сүлжээнд идэвхтэй мэдээлэл түгээх төдийгүй, түүнээс авсан мэдээллийг нотолгоо баримт болгон үндэслэн шийдвэр гаргах хэмжээнд нэгэнт хүрчээ. АНУ-ын ерөнхийлөгчөөр Доналд Трамп сонгогдсон тэр цаг үеэс эхлэн “жиргээний/твиттер/ертөнц” нь улс төр, олон улсын харилцааны талбар болон өргөжсөн. Үнэхээр гайхмаар том том шийдвэрүүдээ Трамп ерөнхийлөгч жиргээчдэд эхэлж танилцуулж байна. Харин манай одоогийн ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш “жиргээний идэвхи” нь даруухан болоод байгаа.

Тийм ээ, цахим ертөнц бол үнэхээр мэдээллийг маш хурдтай түгээх, тараах гол талбар болоод байна. Хэвлэлийн хурал зарлаж сүржигнэх байдал нэгэнт хуучирч улиг болжээ. Ийнхүү мэдээллийг хурдтай, анхдагч эх сурвалжаас нь шууд авч байгаа нь хүмүүсийг цахим ертөнцөөс улам хамааралтай болгож, цаг наргүй уяж байна. Твиттер, фэйсбүүк бол жинхэнэ “ховыг базаж” өгдөг мэдээллийн их

ертөнц. Тэнд та ганцаардана гэж үгүй. Хүний нийгмийн бүхий л харилцаа бий. Онцлог нь нүүр нүүрээрээ тулахгүй, чамайг заавал бусад нь таних ч албагүй. Тиймээс зоригтой байж, хэн ч болж болох давуу талтай. Одоо твиттер, фэйсбүүкт ч тэр албан болон албан бус бүх мэдээлэл дамжуулалт зэрэг явагдаж байна. Харин энэ удаад бид Монголчуудын мэдээлэл дамжуулах, түгээх уламжлалт технологи, тогтолцоо, цуу яриа хэрхэн баримт болж байсан түүхүүдийг сөхөж үзэхээр шийдлээ.

ТӨРИЙН АЛБАН ЁСНЫ ШУУДАН ХАРИЛЦААНЫ ТОГТОЛЦОО

Асар уудам газар нутгийг эрхшээн суудаг нүүдэлчдийн хаад, ноёдод төрийн мэдээлэл дамжуулах найдвартай, шуурхай алба үүсгэх зайлшгүй шаардлага гарах нь мэдээж. Тиймээс Монголчууд элчин харилцаанд онцгой ач холбогдол өгдөг уламжлалтай. Мөн ямар ч элч халдашгүй дархан эрхтэй байх ёстой. Ийнхүү элчийн халдашгүй байдлыг дархалж, хуульчилж өгснөөрөө өвөг дээдэс маань дэлхийн дипломат харилцааны түүхэнд үнэлж баршгүй хувь нэмэр оруулжээ.

Хэлэх үг элчийн аманд буй. Мэдээллийн нууцыг хадгалах үүднээс хаад ноёдын албан бичиг, захидал элчийн амаар дамжиж байжээ. Мөн “дуу бариулах” гэж ойлголт бий. Дамжуулах мэдээллээ мартагч гээд байвал өөрийн элчдээ толгой холбоод дуу болгон цээжлүүлээд илгээх жишээтэй. Мөн бичиг, захидал илгээн,

тамга тэмдэг хэрэглэж байсан ч бий. Ийнхүү Өгэдэй хааны үе хүрэхэд тэрээр шуудан харилцаанд шинэчлэн хийж, байнгын өртөөг байгуулсан билээ.

Тэртээ XIII зуунд Монголчууд хүний түүхэнд байгаагүй, цаашдаа ч гарах боломжгүй асар уудам хуурай газрыг нэгэн захиргаанд оруулав. Богд Чингис хаан ийм өргөн уудам, түмэн янзын хэл, соёлтой, олон зуун хот балгадтай Их эзэнт улсыг үлдээгээд тэнгэрт халив. Гэрээслэл ёсоор түүний гутгаар хөвгүүн Өгэдэй хаан эцгийн их орыг залгасан байна. Монголчууд ямартаа ч алтан, мөнгөн гэрэгэ бүхий элч илгээдэг, өнөө цагийн гадаад паспортыг орлосон тэрхүү гэрэгэ үзүүлсэн элч хэн бүхнээс хэрэгцээтэй эд зүйлийг дайчлан гаргуулах эрхтэйгээр үл барам, тухайн газар орон луу явахдаа өөрийн сонгосон замаар дураар довтлогддог байв. Мэдээж хаад ихэс дээдэс элчийг ийнхүү бүрэн эрхээр дархалж өгсөн нь мэдээллээ аль болох хурдан түргэн авч, түгээх гэсэнтэй холбоотой. Гэвч Их Монгол улсын газар нутаг дэндүү уудам. Мөн элч нар ч гэрэгэ үзүүлэн эрх ямбаа эдлэн, хүссэн замаараа зорчих нь мэдээлэл дамжуулах хурдад нөлөөлж байв. Тиймээс Өгэдэй хаан 1235 онд уургын улааг халж, суурин өртөөг байгуулсан юм. Монголын нууц товчоонд “Уулгалахуйн элчийн явдал удаан буй. Улс иргэнээ зовоон буй” гэж тэмдэглэсэн нь энэ шинэчлэлийн шалтгааныг тодоос тод заажээ. Ийнхүү зүг зүгийн мянгат бүрээс замчин, улаачин гаргаж, тодорхой хот суурингуудад өртөөг байгуулах их үйлсийг Чанай, Булхадар

ноёдод даалган Өгэдэй хаан өөрийн ах Цагаадайд хариуцуулсан байдаг. Харь нутаг орныг захиран суусан Цагаадай, Бат нар ч их улсын нийслэл Хархорин хот руу угтуулан зам өртөөг байгуулж эхэлснээр дэлхийг захирах Монгол хаад төрийн хамгаалалт, хангамж бүхий мэдээлэл дамжуулах асар том сүлжээг бий болгон хянах болсон юм. Эдгээр өртөө, улаатай алдарт Торгоны зам давхцан хөгжиж байлаа. Академич Ч.Далай асан бүтээлдээ: Өгэдэй хааны үед бүрэн бус тоогоор 1500 өртөө байсан гэдэг мэдээ байдаг. Өртөө дотроо том, дунд, бага гэж хуваагдана. Чухал том өртөөнд 1000 гаруй өртөөчин, дунд зэргийн өртөөнд 500 шахам өртөөчин, бага өртөөнд 100 шахам улаач байсан хэмээн бичжээ. Хожим энэхүү суурин өртөө байгуулсан ажлаа Их Монгол улсын Далай хаан Өгэдэй өөрийн дөрвөн сайн үйлийн нэг хэмээн дурдан Монголын нууц товчоонд мөнхөлсөн байдаг. Түүний байгуулсан өртөөгөөр тэр үедээ Ромын Папын элч Плано Карпини, Францын Гильом де Рубрук, Арабын Ибн Батутта нар аялан тэмдэглэлдээ дэн буудлын үйлчилгээ, мэдээлэл хэр хурдан хүрдэг тухай тэмдэглэн үлджээ. Үүнийг бичигч миний бие өнөө хэр бараг хэвээрээ хадгалагдан ирсэн Турк, Иран дахь XIII зууны Монгол ноёдын эзэмшилд байсан өртөөний дэн буудлууд, хаалттай захуудаар аялан гайхан биширч байснаа дурсахад таатай байна. XX зуун гэхэд Богд хааны Монгол улсад 250 орчим морин өртөө байсан бөгөөд Ардын засаг ч эдгээр өртөөг өвлөн авч “Өртөөний дүрэм”-

ийг шинэчлэн тогтоов. 1949 онд ардын аж ахуйтныг морин өртөөний албанаас чөлөөлсөн бол 1960 онд Өгэдэй хааны анхлан байгуулсан өртөөг бүрмөсөн татан буулгажээ. Энэ бол Монгол төрийн албан ёсны мэдээлэл дамжуулах шуудан харилцаа орчин үеийн техник, технологид зайгаа тавьж өгсөн хэрэг юм.

АМНААС АМ ДАМЖИХ МЭДЭЭЛЭЛ

Лавтай ХХ зууны эхэн гэхэд Монголчууд дэмий ярьж хов базах их дуртай болжээ. Ялангуяа зун цагт нүүдэлчин эрчүүдэд хийгээд байх ажил ховор найр наадам, яриа хөөрөөн дээр л гол эрч хүчийг зарцуулдаг байсан бололтой. 200 орчим жил Манжийн манлайллыг хүлээн зөвшөөрч дайн тулаанаас хол хөндий ажин түжин, амгалан байсан нь амьдралын хэв маягийг ихээхэн өөрчилжээ.

(1235 онд Торгоны зам дагуу баригдсан Зазадин дэн буудал, Турк улс, Коняа хотоос 22 км зайтай. Гэрэл зургийг А. Энхбат. 2014)



Оросын нэртэй дипломатч, тагнуулч, түүхч Иван Михайлович Майский 1919-1920 онд эрдэм шинжилгээний томилолтоор бүтэн жил хагас Монгол

оронд ажиллаж 1921 онд Эрхүү хотноо “Орчин үеийн Монгол” (Автономит Монгол ХХ зууны гараан дээр) хэмээх алдартай бүтээлээ хэвлүүлжээ. Тэрээр Монголчуудын мэдээлэл дамжуулах, түгээх нууцыг Монгол хүний сониуч, гэнэн томоогүй байдалтай холбож үзсэн байдаг. Түүний бүтээлд: Монголчууд өөр хоорондоо уулзахаараа сонин юу байна гэж яриагаа эхэлдэг. Тэгээд сонссон дуулснаа хоёулаа бүгдийг дэлгэдэг. Биднийг замд явж байхад нутгийн сониуч хүмүүс бидэн дээр байнга шавдаг байлаа. Хээр давхиж яваа нутгийн монгол манай экспедицийн ачаа хөсөг явж байгааг алсаас харсан бол тэр доороо бидний зүг хурдална. Тэд бидэн дээр давхиж ирээд л амар мэнд асууна. Биднийг ямар улс вэ гэж мэдэхийг оролдоно. Тэгснээ хаанаас хааш явж байна? Ямар хэргээр яваа вэ? гэх мэтийн олон асуулт тавьж зохих хариулт сонсоод ярих юмтай болсондоо баярлаж нөхөддөө дуулгахаар тэр доороо л эргээд онгон ногоон тал руугаа давхиж одно. Ийм маягийн уулзалтыг бид олон үзсэн.

Тэд орой үдэш манай майханд тал талаас ирнэ. Гал тойрч суугаад бидний алхах гишгэх, хөдлөх болгоныг дагаад хүүхэд шиг нүд цавчрахгүй ширтэнэ. Заримдаа эдгээр сонин зочинд оройн хоол цайнаасаа илүүчлэн өгч яриа өдвөл тосож аваад жолоогүй мэт энэ тэрийн тухай ярьж гарна. Бас сониуч зангаа үзүүлж өгнө. Яриагаа өндөрлөөд мориндоо мордоод тал тал тийшээ гарахдаа, их баян /өдөр болгон нэг хонь гаргадаг/ сонин маягийн хампаан ирсэн байна, худалдах бараа байхгүй гэнэ, зөвхөн л олон юм

асуугаад “бичиж аваад” байх юм, бас “газар нутаг сонирхох” юм гэсэн яриа бусдадаа дуулгахаар давхиж одно. Энэ “монгол цахилгаан шуудангийн” ачаар манай экспедицийн тухай мэдээ бидний очих газарт биднээс хэдийнээ түрүүлээд хүрчихсэн, биднийг очихыг хүлээсэн байдал цөөнгүй ажиглагдаж байлаа. Ер нь Монголын тал нутаг уудам цөл хээр боловч ямар нэг мэдээ уугуул нутгийнхны яриасаг, сониуч байдлын ачаар гайхалтай түргэн тардаг юм билээ.

(Зазадин дэн буудал, дотор тал.
Гэрэл зургийг А. Энхбат 2014)



Энэхүү шинжилгээний экспедицийн орчуулагчаар тухайн үеийн Нийслэл хүрээний Монгол сургуулийн багш байсан, хожим Ардын Гэгээрлийн яамны сайд асан Эрдэнэбатхаан гуай ажилласан байдаг. Тиймээс Майскийн ажиглалт илүү бодиттой, шинжилгээний тайлан болох дээрх бүтээл алдартай болоход нөлөөлсөн биз.

Нээрээ ч Монголчууд бид бол гайхалтай сониуч, хүний хэрэгт дуртай ард түмэн. Үнэн биз дээ гэхээр хэн тэгэж байна гэж дахин асуудаг гэж байгаа. Нүүдлийн ахуй бол нэг айл нөгөө

айлаасаа ялгагдах зүйлгүй байдгаараа онцлог. Мөн айл, хөрштэйгээ өдөр бүр уулзаад байхгүй. Гэр бүлийн ажил үүргийн хувиар нь хүүхэд, хөгшин гэж ялгахгүй, ахуйн шинжтэй. Өдөр бүр нийгмийн харилцаанд оролцож, бум бужигнаж, түм түжигнэсэн газраар явах бололцоо олгохгүй. Тийм хот суурин ч ховор. Иймээс нэг тийм мэдээллийн өлсгөлөн, дутагдалтай байна гэсэн үг. Тэгээд л сонин сайхан юутай, хоёр чихний араар хийчих хов жив юу байна гэж мэндлэх жишээтэй. Харин энэ хэрэгцээг нь бадарчин, аяны, явуулын хүмүүс, хоноц хангана.

БАДАРЧИН

Эдгээр мэдээлэл түгээгч, цангаа тайлагч нарын нэг том төлөөлөл бол бадарчин юм. Бадарчин бол бурхан шашны хуварга болсон лам хүн билээ. Буддын лам нар төгс гэгээрэлд хүрэхийн тулд хорвоогийн нүглээс зугтааж, агуй, сүм хийдэд даяанчлан, мацаг барин, сахил санваар сахин ганц нэгээр амьдарч хүн хартай уулзахаас ч зайлсхийдэг. Харин бадарчин лам бол эсрэгээрээ аль болох олны газраар явж, айл хунар хэсэж, хоол унднаас гадна эхнэр, хүүхэн ч эргүүлнэ. Тиймээс “бадарчин явсан газар балагтай, батгана суусан газар өгтэй” гэх Монгол ардын зүйр үг гарсан байх. Гэлээ гээд ард түмний дунд бадарчин гуайн нэр хүнд тийм ч муу байсангүй. Тэдний тухай явган шог яриа, үлгэр домог зөндөө тархжээ. Голдуу ухаантай, сэргэлэн бадарчин баян харамч эрийг дөнгөсөн тухай өгүүлэмжтэй. Тухайн цаг үед ийнхүү мэдээлэл түгээх, мөнцуглуулах боломж,

бололцоо хэрэн хэсүүчлэн явдаг гэдэнд л олддог байсан нь ойлгомжтой. Мөн Богд хаан дэргэд хурал хурах, мөргөл хийх нэрээр халхавчлан олон орноор тагнуул туршуул хийн мэдээлэл цуглуулдаг том гарын бадарчингууд ч байсан гэдэг. Магадгүй тийм учраас “айлын ховыг авгай нар, улсын ховыг бадарчин зөөдөг” гэсэн хэлц үг гарсан байх.

Монгол хэлэнд сайд гэдэг үг бараг ганцхан тохиолдолд хоч, доромж үг болдог тэр нь “Ховын сайд” юм. Хов жив эрхэлсэн эсвэл “мэдээлэл, харилцаа холбоо” эрхэлсэн төрийн сайд биш л дээ. Гэхдээ айл амьтан, ах дүү, нутаг нугынхныхаа хооронд хов живийг зөөдөг, түүнээс нь болоод хүмүүс эе эвдэрдэг. Тэгээд л тэр муу “ховын сайд”-аас боллоо хэмээн халаглах. Монгол хэлэнд “муу үг модон улаатай” гэх зүйр цэцэн үг бий. Утга нь муу үг тарахдаа хурдан. Үүний нэг нь цуу яриа. Монголчууд цуу тараахдаа ч гарамгай ард түмэн. Өөрөөр хэлбэл мэдээллийн үнэн зөвийг үл харгалзан хурдан түргэн түгээдэг гэмтэй, ингэхдээ бүр давс хужир ч нэмнэ. Энэхүү цуу яриа тараах технологийг “чулуу” болгон өрсөлдөгчөө намнах арга ХХ зуун эхэн хагаст дэлгэрч, хэрэгжсэнийг улс төрийн хэлмэгдүүлэлтийн түүхээс харж болно.

ЦУУ ЯРИА ХЭРЭГТЭНГ ЯЛЛАХ БАРИМТ НОТОЛГОО БОЛСОН НЬ

Түүхийн ухааны доктор Д.Өлзийбаатарын шинэхэн хэвлүүлсэн “Лхүмбийн хэрэг” бүтээлдээ уг хэргийн гол зангилаа болох цэргээс

оргосон буриад залуу Ш.Дамдины тухай “Японы тагнуулын газрын даргын тогооч болсон, 50 үсэрдэг гар буутай, нутагтаа нууцаар 15 хоног ирээд буцсан, сумын хоршооны дарга түүнийг нь мэддэг гэнэ лээ, нутгийн хүмүүстэйгээ холбоотой байдаг, банчин Богдын тагнуул, сумнаас бус юм гүйцэхгүй хурдан морьтой” гэх зэрэг цуу яриаг Дотоодыг хамгаалах газар өөрсдөө тараасан гэх дүгнэлт хийжээ. Хөөрхий хилс хэрэгт гүтгэгдэж буй хүмүүсийн тухай мэдээлэл нь тодорхой эх сурвалжгүй, он сарын багцаа муутай байдгаараа нийтлэг. Эдгээр нь ердөө цуу яриа, хов төдий зүйлийг чухал баримт болгож байсны илрэл ажээ. Энэ үед нууц нэртэй “мэдээлэгч” гэх албан тушаалтан бий болж, нөгөө цуу яриа, хов живийг тоо баримтыг өсгөн, ердийн нэг хэрүүлийг улс төрийн ноцтой хэрэг болгон матаас, нууц мэдээлэл болгоод До яамны комиссаруудад илгээдэг. Тэд нар нь ийнхүү өөрсдийнхөн нисгэсэн бор шувууг нууц мэдээлэл болгон цаасан дээр буулгуулж, хэдэн зуун хүний амийг авч одох, хэдэн мянган хүнийг амьдын зовлонд унагах аймшигт хэргийнхээ гол баримт нотолгоо болгодог байжээ.

Тухайн үед хамгийн түгээмэл тарсан цуурхал бол Коминтерний төлөөлөгч Ш.Элиавагийн илтгэлд буй лам нарын зүгээс тарааж буй гэх “Банчин-Богд ялагдашгүй цэргийнхээ хамт Монголд ойртон ирж байгаа тухай цуурхал” юм. Энэ үг хожим олон хүний амийг авч одсон билээ. Монголын уран сайхны “Тунгалаг тамир” кино дээр төр засгийг эсэргүүцсэн Тариатын

ардын хөдөлгөөний гол найдвар нь мөнөөх “ялагдашгүй цэрэгтэй, удахгүй ирэх Банчин Богд” болдог нь түүхээс нэг их хол зөрөхгүй хэрэг явдал билээ.

ТӨГСГӨЛ

Аливаа мэдээллийн үнэн худал, зөв бурууд эргэлздэггүй, дүгнэлт хийдэггүй, ач холбогдолтой эсэхийг сонирхдоггүй шууд л дамжуулдаг гэнэн сониуч зан бидэнд их бага хэмжээгээр уламжлагдсаныг өнөөгийн Монголчуудын цахим ертөнцөөс харж болно. Худал үгийг мянга давтал үнэн болдог гэдэг. Нийтлэг төрх гэвэл цахим ертөнц хязгааргүй их мэдээллийг тулгана, бид ч чадлынхаа хэрээр шейр, лайк хийж түгээнэ. Дээр нь энэ цахим ертөнц хил хязгааргүйг тэмдэглэх хэрэгтэй. Хэн гуай, хаанаас ч ямар ч мэдээллийг оруулж, түгээж болно. Зарим улс орнууд цахим ертөнцийг хянах, зохицуулах оролдлого аль хэдийн хийгээд эхэлсэн. 2018 оны 4-р сард АНУ-ын сенатчдын өмнө мэдүүлэг өгөх үедээ Фейсбүүкийг үүсгэн байгуулагч М. Цукерберг “Бид фейсбүүкийг буруу зорилгод ашиглахаас сэргийлж чадаагүй” гэсэн. Ийм л байна. Үнэн худлын хооронд алга дарам зай бий гэдэг. Харин сүүлийн үед “ятгах тусам улам улам нягтал” гэдэг болсон байна лээ.



ТӨР, УЛС ТӨР СУДЛАЛ

Орчин үеийн үзэл суртлын чиг хандлага: хөгжлийн тайлал

Төрийн албаны тухай шинэ хуулийн онцлог

Намууд мөхөх үү? Намуудад тулгарч буй сорилт

Ардчилсан институт ба Монголын ардчиллын тухай эргэцүүлэл: Бид хаана
явж байна вэ?



Н.ОТГОНБАЯР

Этүгэн Их Сургуулийн багш,
улс төр судлаач

Орчин үеийн үзэл суртлын чиг хандлага

Хүн төрөлхтөн үзэл суртлын ширүүн сөргөлдөөнд орж, ЗХУ, АНУ тэргүүлсэн хоёр лагерьт хуваагдан, эвлэршгүйгээр дайсагнаж байсан цаг саяхан. Гэтэл XX зууны төгсгөлд ЗХУ задарч, социалист систем устан, үзэл суртлын мөнөөх сөргөлдөөн үгүй болов. Америкийн эрдэмтэн Фрэнсис Ё.Фукуяма үзэл санааны хувьсал дуусгавар болж, либерал ардчиллыг дэлхий улс орнууд хаа сайгүй хүлээн авч байгааг тунхаглах болсон.

ҮНЭХЭЭР ҮЗЭЛ СУРТАЛ ХҮН ТӨРӨЛХТНИЙ ОЮУН БОДЛООС ЭГНЭГТ АРИЛСАН ЮМ ГЭЖ ҮҮ?

Фукуяма болон түүний үзэл санааг дагагч эрдэмтэд нэг зүйлийг зуурам боджээ. Үзэл суртлын хувьсал төгсөж, либерал ардчилал өргөн тархлаа гэх бодол нь өөрөө ямар нэгэн үзэл суртлын илрэл юм. Үзэл суртал чанадын утгаараа үгүй болно гэж хэзээ ч байдаггүй. Учир нь хүн төрөлхтний хөгжил, дэвшлийн чиглүүр нь үзэл суртал мөн. Тэгвэл эндээс үзэл суртлын ямар хэлбэр бидний амьдралд даяар шинжтэй болж байна вэ, шалтгаан нь юунд оршино вэ гэх асуулт урган гарч байна.

Шинжлэх ухаан, техник технологи урьд байгаагүй хурдаар хөгжиж, үүнийгээ дагаад хүний мэдлэгийн хүрээ асар ихээр тэлэгдэж байна. Хатуу догмчилсон гэхээсээ илүүтэйгээр орчин цагийн шаардлагад нийцсэн уян хатан, олон асуудлыг шийдэх тайлал болсон үзэл суртлын цогц илрэлийг хүн төрөлхтөн бултаараа эрэн хайх болжээ. Улс төрчид ч энэ үйлийг түүчээлж, баруун төвийн болон зүүн төвийн үзэл санаа эрчээ авч байна.



ЗҮҮН ТӨВИЙН ҮЗЭЛ САНАА

1830 оны долдугаар сард Францад бий болсон хувьсгалын явцад “зүүн төвийн бодлого” гэх ойлголт бий болсон бол зүүн төвийн үзэл санаа төлөвшиж өнөөгийн төрхөө олсон нь XX зуунтай холбогдоно (Schroeder 1996, 742). Зүүн төвийн үзэл санааг ганц социал демократ үзлээр төлөөлүүлэн ойлговол эндүүрэл болох бөгөөд олон олон үзэл санаа, сургаалын бүрдлийг өөртөө багтаасан цогцолбор үзэл суртал юм. Орчин үед зүүн төвийн үзэл санаа нь дараах зарчмыг амьдралд хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэх болсон.

Үүнд:

1. Хүний үндсэн эрх, эрх чөлөөг дээдлэн хамгаалж, ялгаварлан гадуурхах явдлыг тэвчих:
2. Нийтээр хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлж, баян, хоосны ялгааг арилгах:
3. Олон ургалч байдал, олон тулгуурт төрийн зохицуулалт бүхий эдийн засгийг хөгжүүлэх:
4. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдээ хамгаалж, эдийн засгийн эрх тэгш байдлыг чухалчлах:
5. Хөдөлмөрийн хөлс, ажлын байрны нөхцөлийг дээшлүүлэх замаар ажилгүйдлыг багасгах:
6. Бүх нийтийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэврийн нэгдсэн үнэ төлбөргүй тогтолцоо бий болгож, нийгмийн эмзэг давхаргад төр, олон нийтийн зүгээс үзүүлэх дэмжлэгийг чиглүүлэх:
7. Байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн баялагийг зохистой ашиглах:

8. Хүн амын орлогын төлөвт нийцүүлж уян хатан татварын бодлого явуулах:
9. Хариуцлага, хяналтын тогтолцоог бүх түвшинд чангатгах зэрэг болно (Schroeder 1996).

Социал демократизм, нийгмийн либерализм, ардчилсан социализм, экосоциализм, экофеминизм, экоанархизм гэх мэт олон үзэл суртлын бүрдлийг өөртөө багтаасан цогцолбор үзэл санаа нь зүүн төвийн үзэл юм. Энэ ч учраас зүүн төвийн үзэл нь дээр дурдсан бүх үзэл суртлын бүрдлийг багтаасан есөн зарчмыг номлодог байна.

ТЭГВЭЛ БАРУУН ТӨВИЙН ҮЗЭЛ ГЭЖ ЮУГ ХЭЛЭХ ВЭ?

Английн эрдэмтэн Эдмунд Берк, Бэнжамин Дизраэли нарын үндэс, суурийг нь тавьсан баруун төвийн үзэл санаа дэлхийн II дайны дараагаас улс орнуудад эрчимтэй тархах болсон. Өмнө дурдсан зүүн төвийн үзэл санааны нэгэн адил олон олон үзэл суртлын бүрдлийг өөртөө багтаасан цогцолбор шинжтэй үзэл санаа болно. Судлаачдын үзсэнээр дараах зарчмыг номлодог байна. Эдгээрт:

1. Хүн ам, цагаачлалын талаар хатуу бодлого баримтлах:
2. Байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх бодлого баримтлах:
3. Язгуур хэл, соёл, уламжлалаа хадгалах, хамгаалах:
4. Эдийн засаг дахь төрийн оролцоог багасгаж, нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх:
5. Хүн бүрийн боломж, бололцоог бүхий л нээн илрүүлэхийн зэрэгцээ бүх нийтийн эрх ашиг, ашиг сонирхлын нийцлийг чухалчлах:
6. Нийгмийн ёс суртахууныг хангах, хадгалах:
7. Сүсэг бишрэл, үнэт зүйлээ дээдлэх:
8. Төрийн эрх мэдлийг хариуцлагажуулах:
9. Ардчилал, хүн төрөлхтний эв санааны нэгдлийг хангах зэрэг болно.

Урьд өмнө үзэл суртал хэн нэгэн ухаантны оюун бодолд боловсорч, зэр зэвсэг, зохион байгуулалтгүй олон түмний түрэлтээр нийгмийн практикт хэрэгждэг байсан бол өнөөдөр энэ байдал бүрнээ арилжээ. Ямар нэгэн үзэл онолыг хэт догмчлон шүтэхгүйгээр нийгмийн гүнээс гарч буй хэрэгцээ, шаардлагад тулгуурлан үндсэн үзэл санаа, номлолоо цогцлоон босгох, хувирган өөрчлөх уян хатан шинж чанартай болжээ. Үүнийг зүүн төвийн болон баруун төвийн үзэл санаанаас тодорхой харж болох байна (Adams 1995, 347-56).

ДҮГНЭЛТ ХЭСЭГ

Өмнөх үзэл суртал консерватизм, либерализм, коммунизм, фашизм, нацизм, анархизм зэрэг нь хатуу системчлэгдсэн, хувьсан өөрчлөгдөх боломжгүй, хэн нэгэн ухаантны тархинд бүрэлдэн дараа нь хөөрөлд авсан зохион байгуулалтгүй олон түмний түрэлтээр нийгмийн практикт хүчээр хэрэгжих зүй тогтолтой байсан бол өнөөдөр үзэл суртлын энэ шинж бүрэн арилж, өөрчлөгджээ. Энэ бол үзэл суртал төгсөж буй явдал огтоос биш юм. Үзэл суртал чанадын утгаараа үгүй болно гэж хэзээ ч байдаггүй.

Бичвэрт үндэслэн судлаач дараах дүгнэлтийг хийж байна.

Үүнд:

1. Дэлхий дахинаа үзэл суртлын төгсгөл бий болсонгүй, шинэ түрэлт үүсэж байна.
2. Энэхүү түрэлт нь баруун төвийн болон зүүн төвийн үзэл санааны хэлбэрээр илэрч байна.
3. Үзэл суртлын шинэ түрэлт уян хатан, нийгмийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан, байнга хувьсан өөрчлөгддөг байх шинж чанарыг чухалчлах болсон.
4. Шинэ түрэлтийн үед үзэл сурталд хил хязгаар тогтооход төвөгтэй, цогцолбор шинж чанартай болж байна.



О.ТУНГАЛАГ

**“Тунгаамал төв” ТББ-ын
гүйцэтгэх захирал**

Төрийн албаны тухай шинэ хуулийн онцлог

Төрийн албаны тухай хууль өмнө нь 2 удаа шинэчлэгдэж тухайн цаг үеийн тулгарч байсан асуудлуудыг боловсронгуй болгон сайжруулсаар ирснийг энд дурдах хэрэгтэй. Амьдрал өөрөө баян, хөгжлийг дагаад өөрчлөгдөх нөхцөл байдлууд үүсэж байдгаас гадна хуулийг хэрэгжүүлэгчдээс зарим сөрөг үйлдлүүд гаргаж байсан учраас зайлшгүй шинэчлэл хийх шаардлага бий болсон юм.

Монгол Улсын Их Хурал Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү шинэ хуулиар төрийн албан хаагчдад тавигдах шаардлага өндөрсөж, тэдгээрийн эрх, үүрэг илүү тодорхой болсны дээр төрийн байгууллагад тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлж өгснөөрөө ач холбогдолтой гэж үзэж байна.

Төрийн албаны тухай хууль шиэнчлэгдсэнээр улс төрөөс хараат бус, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндэс бүрдэж, төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн алба хаах шалгуур нь зөвхөн мэргэшлийн болон уг албыг

гүйцэтгэх мэдлэг, чадвар, мэргэжлийн ёс зүйгээр тодорхойлогддог нөхцөл баталгаажлаа. Төрийн албанд зөвхөн шатлан дэвших зарчмаар томилгоо хийгдэх түүнд тавигдах олон талын хяналтыг бий болгосны дээр хууль зөрчсөн албан тушаалтан өөрөө хариуцлага хүлээх болсон нь үр дүнтэй зохицуулалт юм. Мөн Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрх, бүтэц бүрэлдэхүүнийг өргөжүүлж, хараат бус ажиллах нөхцөл бололцоог хангасан нь хуулийн хэрэгжилтийг хангуулахад зохих нөлөө үзүүлэх болно.

Та төрийн жинхэнэ албанд ажиллахаар өөрийгөө бэлтгэж байгаа бол дараах шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:

- Монгол Улсын иргэн байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;
- Монгол хэлний ярианы болон бичгийн чадвартай байх;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй байх;
- Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх /2008 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс өмнө 18 нас хүрсэн, түүнчлэн эмнэлгийн магадлагаагаар эрүүл мэндээр тэнцээгүй, хуульд

заасан бусад үндэслэлээр цэргийн жинхэнэ албанаас түр буюу бүрмөсөн чөлөөлөгдсөн иргэнд энэ хуулийн шаардлага хамаарахгүй/

Төрийн албан хаагч болохын тулд заавал төрийн албаны шалгалт өгч тэнцсэн байх ёстой. Төрийн албаны шалгалт нь ерөнхий шалгалт, тусгай шалгалт / тухайн албан тушаалын/ гэсэн 2 төрөлтэй байх бөгөөд ерөнхий шалгалтыг төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй, хуульд заасан нийтлэг шаардлагыг хангасан иргэнээс, тусгай шалгалтыг албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд төрийн тухайн байгууллагад, төрийн бусад байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас, төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс тус тус авдаг. Ерөнхий шалгалтыг жилд хоёроос доошгүй удаа, тусгай шалгалтыг сул орон тоо гарсан тухай бүрд төрийн албаны төв байгууллага зохион байгуулах бөгөөд төрийн жинхэнэ албаны нөөцөд байх хугацаа гурван жил байна. Түүнчлэн төрийн жинхэнэ албаны шалгалт авах журмыг зөрчсөн, уг үйл ажиллагаатай холбоотой хуурамч тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргасан болон хуульд заасан бусад тохиолдолд хариуцлага ногдуулахаар заасныг анхаарах нь чухал.

Шалгалтын бүтцэд ерөнхий мэдлэг, монгол бичиг, дүн шинжилгээ хийх гэсэн 3 шалгалт багтдаг, эдгээр нь тус тусдаа босго оноотой, гурван шалгалтын нийлбэр дүн буюу 65-аас дээш оноотой байвал төрийн албанд тэнцдэг зохицуулалттай. Өнгөрсөн оны 11 дүгээр сарын шалгалтад 8 мянга гаруй иргэн бүртгүүлээд 7 мянга гаруй нь шалгалтад орж гурван шалгалтын дүнгээр 1116 хүн тэнцсэн нь харьцангуй бага дүн юм. Ерөнхий шалгалтын босго үнэлгээг даваад, монгол хэлний шалгалт өгөөд тэнцсэн хүн бол сайн үзүүлэлттэй гэсэн үг.

Төрийн албаны албан тушаалтанд тавигдах тусгай шаардлагыг өмнө нь журмаар зохицуулдаг байсан нь өөрчлөгдөж, хуулийн нарийн зохицуулалттай боллоо. Төрийн нарийн бичгийн дарга болохын тулд төрийн албанд 16 жил ажилласан байх, түүнээс доош албан тушаалд ч ажилласан жилийн болон доод шатны албан тушаалд ажилласан байх хугацааг заасан шаардлагыг хангасан байхаар болсон. Ингэснээр төрийн албанд доод түвшнээс нь ажилласан хүн шатлан ахих буюу чадахуйн “мерит” зарчмаар дэвшиж, төрийн захиргааны хамгийн өндөр албан тушаалтан болох боломж нээгдсэн болно. Шатлан дэвшүүлэхэд мэргэжил, мэдлэг, ур чадвар, туршлага, хариуцлага, ёс зүй гээд бүхийл үзүүлэлтийг харгалзана. Төрийн албан хаагчдыг албан тушаал дэвшүүлэх, зохих шатны сургалтад хамруулах, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулах асуудлыг тэдгээрийн ажлын гүйцэтгэл, үр дүнд тулгуурлан шийдвэрлэнэ.

Төрийн албан хаагч нь /улс төрийн албан хаагчаас бусад/ улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй, улс төрийн нөлөөнөөс ангид байж, зөвхөн төрийн ашиг сонирхолд захирагдан Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэн ажиллах үүрэгтэй. Дээрх шаардлагуудаас гадна одоо ч хэвээр мөрдөгдөх дараах шаардлагыг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна. Аристотелийн “Улс төр” номд бичсэнээр “төрийн албан хаагч” нь

1. Оршин байгаа улс төрийн байгууллагыг хүлээн зөвшөөрсөн байх;
 2. Төрийн албаны ёс журмыг дагаж, оногдсон үүргээ гүйцэтгэж чаддаг байх;
 3. Үнэнч шударга байх ёстой.
- “Төрийн албан хаагч тухайн төрийн байгууллагыг хүлээн зөвшөөрөхгүй эсэргүүцэж муулаад сууж байна гэдэг бол

малаа чононд өгөхөөс сийхгүй малчин шиг ч юм уу. Жинхэнэ хуулийн нэг үндэс нь шударга ёс. Хуулиас гадуур шударга ёс байдаггүй. Хууль шударга байвал

хариуцлага хүлээлгэнэ. Улс төрийн албан хаагч нь төрийн албаны томилгоонд аливаа хэлбэрээр оролцож, нөлөөлөх гэж оролцсон нь нотлогдвол огцрох үндэслэл



хуулийнхаа хүрээнд шударга ёс байх ёстой. Хууль биелүүлэх ажлыг төрийн албан хаагчид эрхэлдэг учраас хуулийн биелэлтийг зохион байгуулах үүрэг бол төрийн албаны үйл ажиллагааны амин сүнс юм. Хуулиа мэд, судал, дараа нь хаана юунд хэрэглэж болохыг нь амьдрал дээрээ ойлго, улмаар эдэлж сур” гэж гавьяат хуульч Б.Чимид гуай хэлсэн нь одоо ч үнэ цэнэтэй хэвээр байна.

Шинэ хуульд төрийн албанд томилогдохоор нэр дэвшсэн хүн эсвэл төрийн албаны томилгоонд хамаарч байгаа албан хаагчийн томилгооны асуудалд улс төрийн албан тушаалтны болон бусад нөлөө бүхий албан тушаалтны зүгээс нөлөөлөх гэж оролдсон бол энэ тухай тэмдэглэл үйлдээд Төрийн албаны зөвлөлд өгөхөөр заасан. Төрийн албаны зөвлөл түүнийг хянаж үнэн, зөв эсэхийг нь тогтоож үнэн нь тогтоогдвол

болохоос гадна томилогдсон албан тушаалтанг уг албан тушаалаас нь халах үндэслэл болно. Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр болсон нь маш зөв зохицуулалт бөгөөд эдийн засгийн арга нь илүү нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах чиг үүрэг шинээр нэмэгдсэн. Мөн төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүрэгтэй Олон нийтийн хяналтын зөвлөл

ажиллахаар хуульд шинээр тусгагдсан нь хяналтын зохистой хэлбэр юм.

Энэ хуулийг эрх бүхий албан тушаалтнууд хэрэгжүүлж ажиллавал сонгууль бүрийн дараагаар төрийн албан хаагчид ажлаасаа олноороо халагддаг, хэн нэгэн даргын дарамтанд хэзээ халагдах бол гэсэн айдастайгаар албан үүргээ гүйцэтгэх, төрийн албанд хоноцын сэтгэлээр хандах гаж тогтолцоо үгүй болох юм.

Хуулийн дээрх зохицуулалтууд хэрэгжсэнээр төрийн албан хаагчийн төрийн албандажиллах баталгаахангагдаж, тогтвортой, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэхээс гадна тохиолдлын хүн төрийн албанд орох боломж хязгаарлагдаж, заавал хэн нэгэн албан тушаалтны цүнхийг барих, эсхүл аль нэгэн улс төрийн намын гишүүн байх шаардлага үгүй болох болно.



Я.ТӨГӨЛДӨР

ШУТИС-ийн Нийтийн удирдлагын
тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор

Намууд мөхөх үү? Намуудад тулгарч буй сорилт

Улс төрийн нам мөхөх үү? Намгүйгээр төрийн засаглал хэрэгжиж болох уу? гэх асуултууд багагүй тавигдах болжээ. Хариултыг нам яагаад бий болсон? нийгэмд нам ямар үүрэгтэй вэ? гэсэн логикийн асуултаас эхлэх хэрэгтэй гэж бодож байна. Намын үүсэл хөгжлийн түүхээс харахад шүүмжлэлтэй хандсан олон баримтууд байдаг ч намгүйгээр улс төрийг төсөөлөх орчин үеийн улс төрийн засаглал хараахан бий болоогүй байна. Орчин үеийн улс төрийн нам судлалд судалгааны онол-арга зүй, практикийн түвшинд намын тухай уламжлалт ойлголт, төсөөллийг өөрчлөх шаардлага тулгарч байна. Учир нь улс төрийн намыг юу гэж ойлгохоос улс төрийн харилцаанд оролцох түүний дүр үүргийг зөв тодорхойлох боломжтой юм. Судлаачдын дунд улс төрийн намыг тодорхойлж буй дараах хэд хэдэн нийтлэг хандлагууд байна.

Үүнд: УЛС ТӨРИЙН НАМ БОЛ:

- Үзэл санаа нэгтнүүд чөлөөтэй эвлэлдэн нэгдсэн нийгмийн чөлөөт, сайн дурын бүлэг, холбоо;
- Төр, засаглалын харилцааны гол оролцогч, засаглалын төлөөх байгууллага;
- Мэргэжлийн болон мэргэшсэн улс төрчдийн байгууллага;
- Нам бол улс орны улс төр-эдийн засгийн бодлого тодорхойлох үүрэг хүлээгч улс төрийн институт;

Дээрх тодорхойлолтуудад улс төрийн намыг ойлгох гол гол түлхүүр санаанууд агуулагддаг. Тодруулбал: Нэгд, улс төрийн нам бол ижил төстэй үзэл санаа, итгэл үнэмшил, үнэт зүйлсээрээ эвлэлдэн нэгдсэн сайн дурын нэгдэл гэж үзэх хандлага, хоёрт, нам бол улс төрийн засаглалд оролцох сонирхолтой, түүнийхээ төлөө өрсөлдөх чадвартай улс төрийн мэргэжлийн байгууллага, гуравт,

нам нь нийгэм, улс төрийн чадварлаг манлайлагчдын өрсөлдөөний талбар, төвлөрөл бүхий байгууллага, дөрөвт, улс төрийн нам аливаа нийгмийн улс төр-эдийн засгийн бодлого боловсруулж, бодлогын нам байж, нийгэмд хүлээх хариуцлага, ёс зүйн өндөр хэм хэмжээтэй байх санаанууд ажиглагдаж байна. Нөгөө талаас дээрх тодорхойлолтуудад улс төрийн намын суурь ойлголтыг багтаасан ч ерөнхий нийтлэг агуулгаараа намыг улс төрийн мэргэжлийн “байгууллага” хэмээн үзэж буй дүгнэлтийг хийж болно. Иймд улс төрийн намыг гүнзгийрүүлэн судлахад “улс төрийн мэргэжлийн байгууллага” талаас нь судалж, орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны нам судлалын дараа дараагийн судалгааны хэлэлцүүлгийн сэдвүүд өрнөнө гэж бодож байна.

1. УЛС ТӨРИЙН НАМЫН ЧИГ БАРИМЖАА БОЛОН ҮЗЭЛ СУРТЛЫН ХУВЬД ГАРЧ БУЙ СОРИЛТУУД:


Нам бий болох үндсэн шалтгаан болоод өөр хоорондоо ялгарах үндсэн арга зам нь намын үзэл суртал юм. Улс төрийн үзэл суртал нь нэг талаас хэсэг бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлэх, хамгаалах үзэл санаа, үзэл баримтлалуудын нийлбэр цогц, нөгөө талаас улс төрийн засаглалын хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны шинжийг хангах үнэт зүйлсийн илэрхийлэл гэж үздэг.



Анхны улс төрийн намын систем Англияс эхлэлтэй боловч орчин үеийн утгаараа Америкт үүссэн гэж үздэг. Энэхүү зураг нь 1800 оных бөгөөд тухайн үеийн Америкийн Бүгд Найрамдах нам, Ардчилсан намын анхны партизанууд нь холбооны улсын тулгуур багана байх болно гэсэн агуулгатайгаар хэвлэгдэж байжээ.

Эндээс улс төрийн үзэл баримтлал, үзэл суртал нь бие биенээсээ хамаарах ойлголтууд боловч ялгагдах онцлогтой юм. Тодорхой хэсэг бүлгийн үзэл санаа, үзэл баримтлалуудын нийлбэр нь үзэл суртлыг бий болгох бөгөөд үзэл суртал нь харьцангуй өндөр түвшинд системчлэгдэн боловсруулагдсан байдгаараа онцлогтой. Сүүлийн үед намын үзэл суртлын асуудалд олон янзын хандлагууд гарч, үзэл баримтлалгүйгээр улс төрийн нам оршин байх боломжтой эсэхэд маргаан мэтгэлцээн явагдаж байна.

Үүнийг түүхээс сөхөн үзвэл:



Орчин үеийн улс төрийн намуудын чиг баримжаа ба практик байдал


20-р зууны аж үйлдвэрийн хувьсгалын үеэс технократуудаас “үзэл суртлыг хуурмаг” хэмээн үзэх шүүмжлэлт хандлага хүчтэй дэлгэрсэн байдаг. 1960 онд Д.Беллийн “Үзэл суртлын төгсгөл” нэртэй бүтээл гарч, өрнөдийн нийгэмд “үзэл сурталгүйжүүлэх” үзэл санааны байр суурь өрнөсөн юм. Гэхдээ удалгүй 1970-аад оноос дэлхийн улс орнуудад ардчилсан үзэл баримтлалын давалгаа эхэлж, дахин үзэл суртлын үнэт зүйлс, түүний олон ургальч байдлыг дэмжсэн хандлагууд гарч эхэлсэн. Харин 21-р зууны эхэн үеэс буюу өнөөгийн улс төрийн намуудын үзэл баримтлалд интеграци явагдаж, нийгмийн хөгжлийн тулгамдаж буй асуудалд бодлогыг чиглүүлэх хандлага ажиглагдаж байна. Энэ нь нийгэмд намуудын үзэл суртлын ялгаатай байдал зайлшгүй эсэхэд эргэлзээ төрүүлж, намуудын чиг баримжааг тодорхойлох арга зам болж чадахгүй байгаад шүүмжлэл гарах болж, үгүйсгэх байдалд хүргэж байна. Улс төрийн үзэл суртлын гол бүтээлийн (“Үзэл суртлын элементүүд”) зохиогч Дестют де Траси үзэхдээ ямар ч тохиолдолд улс төрийн нам байгаа цагт улс төрийн үзэл суртал оршино гэсэн санааг дэвшүүлсэн бөгөөд “нийгэм, улс төрийн бүлэг, улс төрийн нам, хувь хүний үйл ажиллагаандаа баримтлах үнэт зүйл, зарчмуудын цогцыг үзэл суртал гэж үзсэн. Тиймээс орчин үеийн улс төрийн нам үзэл баримтлалгүйгээр оршин байх боломжгүй бөгөөд цаашлаад намын системийн хэв маяг, ялгаа онцлогийг тодорхойлох боломжгүй болох юм. Эцэстээ энэ үзэгдэл даамжирвал улс төрийн намын нийгмийн төлөөллийг хангах суурь зарчим алдагдаж, нийгэмд олон ургальч үзэл санааны өрсөлдөөний механизмгүй болоход хүрэх тул намуудад үзэл баримтлалаа илүү ялгаатай байдлаар танин

мэдүүлэх, илэрхийлэх онол болон практикийн томоохон сорилттой тулгарч байгааг харуулж байна.

2. НАМ БОЛ УЛС ТӨРИЙН ЗАСАГЛАЛД ОРОЛЦОХ СОНИРХОЛТОЙ, ТҮҮНИЙ ТӨЛӨӨ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ УЛС ТӨРИЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОХЫН ХУВЬД:

Улс төрийн нам байх шалгуурын гол үзүүлэлт бол сонгуулиар төрийн засаглалд оролцох, өрсөлдөх чадвартай байгууллага байх ёстой. Энэ шалгуураас улс төрийн нам болон төрийн алба, засаглалын харилцааны зааг ялгааг тодорхой болгох, төрийн засаглалд оролцогч талуудын зохистой оролцооны хэлбэрийг хуульчилж, хэрэгжүүлэх нөхцлийг тодорхой болгохыг шаарддаг. Гэтэл төр бол улс төрийн намаар хэрэгждэг гэсэн уламжлалт улс төрийн соёлын тогтсон ойлголт постсоциалист орнуудын улс төрийн системд ажиглагдсан хэвээр байна.

Улс төрийн философич Ремон Арон бүтээлдээ “.., намуудын зорилго бол засаглалыг хэрэгжүүлэх биш, харин засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох явдал...” гэж бичсэн байдаг. Эндээс үзэхэд ардчилсан улс төрийн системд төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд намын зохистой



оролцоог хуульчилж, орчин үеийн улс төрийн намын өрсөлдөх чадварыг түүний оролцооны чадамжаар тодорхойлох нь удаах шинэ сорилтын нэг гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, улс төрийн нам төрийн засаглалыг хэрэгцүүлэх цорын ганц субъект биш, бусад оролцогч талуудын хамтын удирдлагаар хэрэгжүүлэх хуульчилсан оролцоо гэдгийг дахин авч үзэх хэрэгтэй юм.

3. МЭРГЭЖЛИЙН БОЛОН МЭРГЭШСЭН УЛС ТӨРЧДИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОХЫН ХУВЬД:

Нам бол өвөрмөц зохион байгуулалтай, өөрийн бүтэц, бүрэлдэхүүнээрээ ялгардаг улс төрийн байгууллага. Энэ агуулгаар нам нь нийгэм, улс төрийн лидерийг шилж, сонгох, элит лидерүүдийг бэлтгэх үйл ажиллагаа багтдаг. Улс төрийн нам байхын тулд төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох чадварлаг хүний нөөцтэй, улс төрийн албан хаагчдыг шилж, сонгох, бэлтгэн төлөвшүүлэх механизм ажиллаж байхыг зүй ёсоор шаарддаг. Өндөр мэдлэг ур чадвартай, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх нь намын төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох чадварыг тодорхойлох үзүүлэлт байхаас гадна нийгмийн улс төрийн соёлыг төлөвшүүлэх, иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх хүчин зүйл болдог. Харин практикт нам мэргэжлийн улс төрийн байгууллага болохын хувьд энэ үүрэг хэрхэн хэрэгждэг талаар нийгэм, олон нийтийн зүгээс шүүмжлэлд өртөж байгаа нь орчин үеийн улс төрийн намуудын өмнө тулгамдаж буй асуудлын нэг болж байна. Жишээ болгож манай улсын нөхцөлд дэлгэрүүлэн тайлбарлавал 2019 оны шинэчилсэн Монгол улсын төрийн албаны тухай хуулинд зааснаар:

- Төрийн улс төрийн албан тушаал
- Төрийн захиргааны албан тушаал
- Төрийн тусгай албан хаагч
- Төрийн үйлчилгээний албан хаагч гэсэн 4 төрлийн албан хаагчийг тусгасан байдаг.

Улс төрийн албан тушаалтнаас бусад нь төрийн албаны тухай хуулинд зааснаар мэргэжлийн болон төрийн албаны шалгалтыг өгч, тэнцсэн тохиолдолд ажиллах эрх нээлттэй болдог. Харин улс төрийн албан тушаалтан нь ямар ч шалгуур, нөхцөлгүйгээр ажиллах эрх нээгдэж, төрийн албаны ёс зүйгүй үйлдлүүд газар авсан нь намын нэр хүндэд сөргөөр нөлөөлж, намын хүний нөөцийн бодлогын асуудлыг дахин авч үзэх дараагийн сорилт болж байна.

4. НАМ УЛС ТӨР БОДЛОГО ТОДОРХОЙЛОГЧ, ТОДОРХОЙ ҮҮРЭГ ХҮЛЭЭДЭГ УЛС ТӨРИЙН ИНСТИТУТЫН ХУВЬД:

Улс төрийн намын нийгэмд хүлээх үүрэг нь түүний мөн чанар, зорилгоор илэрч, нам судлалын онол болон практикийн уялдаа холбоог хангах чухал үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн нам байх шалгуур үзүүлэлт болон түүний гадаад, дотоод үүргийн үр дүнгээр дамжуулан нийгмийн өмнө хүлээх хариуцлага тодорхойлогдоно гэсэн үг. Дээрх хэсгүүдэд гарсан намын өмнө тулгамдаж буй асуудлыг

нэгтгэн үзвэл орчин үеийн улс төрийн намын үүргүүдийг хөндсөн байгааг ажиглаж болно. Тоймлон үзвэл:

- Нийгмийн бүлэг, төлөөллийн эрх ашиг, сонирхлыг илэрхийлж, дамжуулж, нэгтгэх;
- Тодорхой үнэт зүйлс, үзэл баримтлалд тулгуурласан улс төрийн үзэл сурталтай байж, түүндээ нийцэхүйц улс төр-эдийн засгийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Улс төр-эдийн засгийн бодлогоо хэрэгжүүлэх хүний нөөцийн бүрэлдэхүүнтэй, нийгмийн элит лидерүүдийг шилж, сонгох, нөхөн сэлгэх ардчилсан механизмтай байх;
- Чадварлаг хүний нөөцөөр дамжуулан иргэдийн улс төрийн мэдлэг, оролцоог дээшлүүлж, улс төрийн соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх үүргүүд юм.

Нийгмийн харилцаанд оролцож байгаа тодорхой эрхтэй хувь хүн, бүлэг, хуулийн этгээд бүхэн үүрэг хүлээж, түүнийхээ төлөө хариуцлага үүрч, хохирлыг барагдуулах ёстой байдаг. Хариуцлага нь хамрах хүрээ, шинж чанар, үйлчлэх орчноосоо хамаарч янз бүр байх боловч аливаа хүн, этгээд өөрийн эрх, үүрэгт хамаарч байгаа үйл ажиллагааныхаа үр дүн, үр дагаварыг бүрэн хариуцах гэсэн утга санаа илэрхийлэгддэг. Хариуцлага хүлээнэ гэдэг нь үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас үүдэх эерэг, сөрөг үр дагавраар тодорхойлогдоно. Иймд улс төрийн намын хариуцлага нь нэг талаас нийгмийн гишүүдийн намд өгсөн үнэлгээ буюу сонгуулийн санал өгөх үйл явцаар илэрнэ, нөгөө талаас улс төрийн намын гишүүдийн өөрсдийнх нь ёс зүйн үйлдлээр илэрхийлэгдэх боломжтойг судлаачид онцлон үзэж байна. Харин өнөөгийн практикт улс төрийн систем дэх намын байр суурийг үгүйсгэх, үл итгэх, хандлага нэмэгдэж, сонгуулийн үр дүн, иргэдийн улс төрийн оролцоо буурч байгаа зэргээс харахад орчин үеийн улс төрийн намын төлөвшилд шинэчлэлийн шинэ сорилтууд тулгарч байгаа нь тодорхой байна.

Улс төрийн намын хувьд нийгмийн өмнө хүлээх хариуцлага нь хамгийн ил тод зарчмаар хэрэгжих түүний улс төрийн эвлэлдэн нэгдэх эрхийн үнэ цэнэ, нэр хүндийг өсгөх учиртай юм. Харин практикт энэ зарчим хэрэгжиж чадахгүй тохиолдолд нийгэм олон нийтийн зүгээс аяндаа шахалт ирж, намгүйгээр улс төр болон төрийн засаглалыг хэрэгжүүлэхийг шаардах боловч “нам мөхөх” үндэслэл биш гэдгийг онцлон дүгнэж байна. Иймд судлаачийн зүгээс гарчгийн асуултанд “нам мөхөхгүй” гэж хариулж байна. Харин орчин үеийн ардчилсан иргэний нийгмийн хэв маягт илүү нийцэхүйц, нийгмийн үүргээ хариуцлагатайгаар үүрдэг, илүү зөв зохион байгуулалттай,

мэргэжлийн улс төрийн байгууллагын түвшинд байх шинэчлэлийн үе намд тулгарч буйг дээрх санаануудаар илэрхийлэхийг оролдлоо. Эцэст нь улс төрийн намыг сайн ойлгохын тулд нам судлалыг онол болон практикийн, бодлогын 3 түвшинд авч үзэж, судалгаа шинжилгээг гүнзгийрүүлэн хийх шинэ сэдэв, орон зай нэмэгдсээр байгааг онцлон дурдахад илүүдэхгүй гэж бодож байна.



Д.БУМДАРЬ

МУИС, Улс төр судлалын тэнхимийн багш,
дэд профессор

Ардчилсан институт ба Монголын ардчиллын тухай эрэгцүүлэл: БИД ХААНА ЯВЖ БАЙНА ВЭ?

Гарчгийн дагуу уншвал төөрсөн хүн, төөрсөн төр хаана яваагаа лавлаж байгаа мэт сэтгэгдэл төрөх нь тодорхой. Гэвч бодит амьдрал дээр бид ардчилал, ардчилсан засаглал дор төөрч байна гэсэн нийгмийн үнэлэмж бодит үзэгдэл болоод байгааг судалгааны олон дүнгээр харч болно. Ялангуяа ковид-19 цар тахалтай зэрэгцэн ардчиллын үзэл санаа, мөн чанарыг үгүйсгэх шүүмжлэх хандлага олон улсад гарсаар байгаа нь нууц биш юм. Манай улсын хувьд ардчилсан институт төдийлөн сайн бэхжиж чадаагүй, улс төрийн эрүүл тогтолцоо бүрэлдэж амжаагүй үед ардчиллын талаарх үнэлэмж дэлхийд буурах нь сайн үзэгдэл биш юм.

Монголын ардчиллын тухай ярихын тулд эхлээд бид өөрсдийнхөө дэлхийд үнэлэгдэх “үнэ цэнэ, эрэмбээ” мэдэх хэрэгтэй. Манай улс нь ардчилсан засаглал болон хөгжлийн түвшингээрээ хаана явааг бид дэлхийн тэргүүлэгч улсуудтай харьцуулах нь утгагүй. Ардчиллын гурав дахь

давалтгаанд өртөн бидэнтэй нэг зэрэг шилжилт хийсэн посткоммунист улс орнуудтай харьцуулж харах нь илүү бодитой юм.

Посткоммунист орнуудын төлөөлөл болгон дараах 26 улстай Засаглал, Ардчилсан эрх чөлөө, Эдийн засгийн хөгжил, Хүний хөгжлийн индексийн үзүүлэлтээр манай улс хэдэд нь жагсаж байгааг харахыг зорилоо (Хүснэгт.1). Хамгийн сайн үзүүлэлттэй нь “Freedom House” судалгааны хүрээлэнгийн 2019 оны судалгаагаар 100 онооноос 89 оноог авч үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сонгуульд оролцох буюу улс төрийн эрх эдлэж байгаагаар хамгийн чөлөөтэй гэсэн үнэлгээг манай улс авч 26 улсаас эхний аравт жагсаж байна.

Харин эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтээр нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээгээр 26 улсаас 19-д жагсаж байна. Хүний хөгжлийн индексээр бид бүхэн эрүүл мэнд, боловсролын салбарын хөгжлийг



давхар харах боломжтой байдаг. Гэтэл энэ үзүүлэлтээр бид 26 улсаас 19-д бичигдсэн байна. Ардчиллын гурав дахь давалгаанд өртсөн төр улсуудтай харьцуулахад улс төрийн эрхээс бусад хөгжлийн асуудлаар арын эгнээнд бичигдэж байгааг статистик үзүүлэлтээс харлаа.

Манай ардчилал, хөгжлийн түвшин ямар байгааг бид тоон үзүүлэлтээр харахад хамгийн чухалд тооцогдох улс төрийн эрх чөлөөг бид эдэлж чадаж байна.

Харин яагаад бид нийгэм, эдийн засаг, боловсрол гээд бусад нийгмийн асуудлаар хөгжихгүй байна. Ардчиллын амин сүнс, мөн чанар болох тэгш эрх, шударга ёс, эрх чөлөө нь бидэнд хуулийн хүрээнд баталгаажиж, түүний институт болох Үндсэн хуульт ёс, Шүүх тогтолцоо, Олон намын систем, Хэвлэл мэдээллийн бие даасан байдал, Сонгуулийн эрх, Иргэний нийгмийн байгууллагын хөгжлийг бодит болгох гэж олон арван хуулийн өөрчлөлтийг хийсээр ирсэн байдаг.

Төрийн засаглалын хэлбэр, бидний өдөр тутмын ярианы сэдэв ардчилал нь хүсэж байгаа шигээ төсөөлж байгаа шигээ тооцоолж байгаа шигээ хөгжихгүй байна вэ. Энэ 30 жилийг эргүүлж дүгнэх гээд оролдвол хамгийн том хүчин зүйлсийн нэг нь иргэдийн оролцооны асуудал юм болов уу. Учир нь ардчилал иргэдийн оролцоон дээр тогтож байдаг. Нөгөө талаар ардчилсан нийгэмд олонхийн хяналтыг иргэд хийдэг. Иргэд өөрсдийн эрхээ сонгуулиар шилжүүлж, төлөөлүүлж буй улс төрийн нам, улс төрчийг таньж мэдэх шаардлага, хэрэгцээг ач холбогдлыг ойлгохгүй хөсөрдүүлж байна. Шууд утгаараа бол рационал сонголт, хандлагыг иргэдэд төлөвшүүлэх ёстой боловсролын салбарын хангалтгүй үр дүн юм.

Бид 30 жил ардчилсан засаглалыг хөгжүүлнэ хэмээн итгэж найдаж, олон намын системийг хүндэтгэж сонгуулиа өгсөөр ирсэн нь талархууштай юм. Сонгуулийн

Хүснэгт. Посткоммунист улс орнуудтай Монголыг харьцуулах нь
Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт.

№	УЛСЫН НЭР	FREEDOM HOUSE-Н ҮНЭЛГЭЭ 2019		ДНБ-Н ХЭМЖЭЭ 2018	ДЭЛХИЙН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ	ЗАСАГЛАЛЫН ХЭЛБЭР	ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС 2018
1	АЗЕРБЕЙЖАН	10	ХААЛТТАЙ	4,139	0.05%	ХАГАС ЕРӨНХИЙЛӨГЧ	87
2	АРМЕН	53	ХАГАС ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ	3,918	0.01%	ПАРЛАМЕНТ	81
3	АФГАНИСТАН	27	ХААЛТТАЙ	538	0.02%	ЕРӨНХИЙЛӨГЧ	170
4	БЕЛОРУСЬ	19		5,762	0.07%	ЕРӨНХИЙЛӨГЧ	50
5	БОЛГАР	80	ЧӨЛӨӨТЭЙ	8,197	0.07%	ПАРЛАМЕНТ	52
6	БОСНИ	53	ХАГАС ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ	5,387	0.02%	ПАРЛАМЕНТ	75
7	ГҮРЖ	61		3,762	0.02%	ПАРЛАМЕНТ	70
8	КАЗАХСТАН	23	ХААЛТТАЙ	9,009	0.20%	ЕРӨНХИЙЛӨГЧ	50
9	КИРГИСТАН	39	ХАГАС ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ	1,222	0.01%	ПАРЛАМЕНТ	122
10	ЛАТВИ	89	ЧӨЛӨӨТЭЙ	15,613	0.04%	ПАРЛАМЕНТ	39
11	ЛИТВА	91		16,709	0.06%	ХАГАС ЕРӨНХИЙЛӨГЧ	34
12	МОЛДОВА	60	ХАГАС ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ	2,002	0.01%	ПАРЛАМЕНТ	107
13	МОНГОЛ	83	ЧӨЛӨӨТЭЙ	3,672 (19-д)	0.01%	ПАРЛАМЕНТ	92 (19-д)
14	МОНТЕНЕГРО	62	ХАГАС ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ	7,720	0.01%	ПАРЛАМЕНТ	52
15	ОХУ	20	ХААЛТТАЙ	10,846	1.95%	ХАГАС ЕРӨНХИЙЛӨГЧ	49
16	ПОЛЬШ	84	ЧӨЛӨӨТЭЙ	13,871	0.65%	ХАГАС ЕРӨНХИЙЛӨГЧ	32
17	РУМЫН	83		10,781	0.26%	ХАГАС ЕРӨНХИЙЛӨГЧ	52
18	СЛОВАК	88		17,551	0.12%	ПАРЛАМЕНТ	36
19	СЛОВЕНИ	94		23,488	0.06%	ПАРЛАМЕНТ	24
20	ТАЖИКИСТАН	9	ХААЛТТАЙ	805	0.01%	ЕРӨНХИЙЛӨГЧ	125
21	ТУРКМЕНИСТАН	2		6,587	0.05%	ЕРӨНХИЙЛӨГЧ	108
22	УЗБЕКИСТАН	10		1,554	0.06%	ЕРӨНХИЙЛӨГЧ	108
23	УКРАИН	62	ХАГАС ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ	2,521	0.14%	ХАГАС ЕРӨНХИЙЛӨГЧ	88
24	УНГАР	70		14,364	0.17%	ПАРЛАМЕНТ	43
25	ЧЕХ	91	ЧӨЛӨӨТЭЙ	20,291	0.27%	ПАРЛАМЕНТ	26
26	ЭСТОНИ	94			0.03%	ПАРЛАМЕНТ	30

ирц тогтмол буурсан хэдий ч хуульд заасан босго хэмжээнд хүрэн төрийг эмхлэн байгуулж засаглалын легитим шинжийг хангасаар л байна.

Гэтэл сонгогчийн найдаж, итгэж сонгосон төлөөлөгч, улс төрийн нам нь амлалт, мөрийн хөтөлбөрөө умартах, зөвхөн амин хувь, фракц, бүлгийн эрх ашгийн төлөө ажиллан “төрөөс төрсөн тэрбумтан” хэмээх нэр томъёолол хүртэл улс төрд хэвшмэл болсон. Бизнесийн байгууллага үргэлж ашгийн төлөө байдаг бол Монголын парламентад тэрхүү ашгийг хамгаалах хуулийг батлах компанийн төлөөлөгчийг сонгодог болсон гэж



<https://ikon.mn/n/1nzb>

хэлэхэд дэгсдэхгүй. Улмаар энэ нь өнөөгийн улс төрийн соёл болчихсон нь хамгийн том ухралт болж байна. Тиймээс тэдгээр төлөөлөгчдийн хувьд нийтийн эрх ашгийг хангах үйл ажиллагаанд хойрго хандах нь тодорхой. Өнөөдөр манайд ямар улс төрийн тогтолцоо байна гэхээр: сонгуулийн дөрвөн жилийн амьдралтай буюу улс төрийн эдийн засгийн мөчлөгтэй, нэг үгээр хэлбэл сонгуулийн ардчилалтай

улс болсон.

Учир нь ээлжит сонгуулиар хэвлэл мэдээлэл, судалгаа, пи-ар, тээвэр, хүнсний гээд маш олон чиглэлийн аж ахуйн нэгжүүд богино хугацаанд ашигтай ажилладаг. Тухайлбал ажлын гэрээ хийгээд хэдэн сарын турш нэр дэвшигч, нам, эвсэлийн төлөө ажиллана. Мөнгөтэй нөхөд нь сонгуулийн хандив дор албан тушаалын бялуу хуваарилалтыг хүлээнэ.

Нийгмийн зарим түвшний төлөөлөл болох оюутан, ажилгүй иргэн, тэтгэврийн насныхан өдрийн мөнгөөр сонгуулийн сурталчилгаанд ажиллаж, ухуулга хуудас тараачихна. Нэг үгээр, сонгууль бол ашгийн төлөө үйл ажиллагаа болон хувирч иргэдийн олон ургальч үзэл санааг илэрхийлэх, хамгаалах, төлөөлөх, бодлогын өрсөлдөөн байх гэдэг үндсэн шинжээ гэж байгаа нь харамсалтай. Уг чанартаа бол ямар нэгэн санхүүгийн харилцаанд орохгүйгээр сайн дураар сонгуулийг өрнүүлэх нь нийгэмд улс төрийн зөв соёлыг суулгах учиртай байдгийг бид Германы сонгуулийн кампанит ажлаас харж болно.

Ардчилсан засаглал төлөвших маш хэцүүт бид хөгжингүй улс орнуудын олон туршлагаас харч болно. Хамгийн гол хөшүүрэг нь иргэдийн идэвхтэй байдал, зөв оролцоо, хяналтын асуудал гэдгийг ухамсарласан цагт хөгждөг, чанартай ардчилал болдог. Манайд мөн тийм л зам байгаа бусдаар бол ардчиллын институт бүгд байна.

СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР НЬ АМЛАЛТ УУ БОДЛОГО УУ?

Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жил бүр нийгэм даяараа хаваржингаа хүсээгүй байхад хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр “нүдүүлдэг” нэг зүйл нь сонгуулийн мөрийн хөтөлбөр. Мэдээллийн замбараагүй эх сурвалжаас үүдэн сонгуулийн мөрийн хөтөлбөр хэрэгжих эсэх, амлалт уу бодлого уу гэдэгт бодиттой хандах, үнэлгээ өгөх хэцүү болдог. Иймээс иргэддээ санаа зовж, сонгуулийн зөв соёл, бодлогын сайн хувилбарыг сонгуулах үүднээс Үндэсний Аудитын Газарт сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хуулийн хугацаанд гардуулж, сонгуульд өрсөлдөх эрхээ олж авах эрхзүйн тогтолцоог 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Удахгүй УИХ-ын ээлжит 8 дахь удаагийн ээлжит сонгууль болох гээд улс төрийн нам, эвсэл сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аудитын газар гардуулахтай зэрэгцэн өрсөлдөж буй сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилгоос бага зэрэг танилцуулсан. Нэг талаар “поп”, нөгөө талаар яагаад байж болохгүй гэсэн дуу хоолой, үзэл санаа нийгмийн сүлжээгээр хүчтэй өрнүүлж нам, эвсэлүүд сонгуулийн кампанит ажлын эхний шатаа амжилттай эхлүүлсэн гэж үзэж болно. Сонгуулийн мөрийн хөтөлбөр амлалт уу аль эсвэл бодлого уу гэдэгт хөл хорионы үед цахим хэлбэрээр мэдээлэх үүргээ биелүүлэх үүднээс гэж бодон энэхүү багахан тайлбарыг бичиж байна.

СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн амлалтыг олон улсад тэр дундаа улс төрийн шинжлэх ухаанд “Manifesto” гэсэн нэр томъёогоор илэрхийлж ойлгодог. Үгийн гарал нь латин үгний manus- гар, fendere- цохих гэсэн утгатай гараараа тэмтэрч үзсэн юм шиг тодорхой байх гэсэн утгыг илэрхийлдэг. Манай салбарт орж ирэхдээ итали хэлнээс англи хэлэнд хөрвөж орж ирсэн ба Английн Ерөнхий сайд асан Роберт Пеел ард иргэддээ хандсан илтгэлийг 1835 онд Манифесто гэж нэрийдсэнтэй холбон тайлбарладаг. Маш товчхондоо “Сонгуулийн гэрээ” гэж ойлгож болно.

Сонгуулийн гэрээ нь Англиас эхтэй парламентийн засаглалтай болон хууль тогтоох байгууллагыг сонгох үед улс төрийн нам, нэр дэвшигчид түлхүү ашигладаг гэдгийг ойлгож авлаа. Дээр нь нэмж хэлэхэд АНУ-д бол “Party Platform” хэмээн нэрлэдэг ба намын байр суурь чухал хэмээн үзэх хандлага нь энэ нэр томъёонд хүчтэй агуулагддаг. Өөрөөр хэлбэл сонгуулийн мөрийн хөтөлбөрт намын үзэл баримтлал, бодлого шингэсэн байх ёстой гэсэн үг. Аль ч талаас нь тайлбарласан манифесто, парти платформ хоёр сонгуулийн мөрийн хөтөлбөр, намын бодлогыг илтгэх юм. Манайд манифесто хэлбэр нь илүү хэрэгжих талтай. Учир нь мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт гэдгийг хувьчлан тайлбарлаж, оноо өгч байгаатай шууд холбож болно. Яг ийм хэлбэрээр ашигладаг улс нь Япон улс. Японы парламентийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүний

хэрэгжилтэнд үнэлгээ өгөх улстөрийн соёлоос тодорхой харж болно.

СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР ЯМАР БАЙХ ЁСТОЙ ВЭ?

- Өнөөдрийн бодит нөхцөл, улс төрийн хурцадмал асуудлыг тодорхой оруулсан байх;
- Ирээдүйн хөгжлийн загварыг тодорхойлж, хэрэгжих боломжтой тооцоолол хийсэн бодлогын хувилбарыг маш тодорхой харуулсан байх;
- Хязгаарлагдмал нөөцийг ашиглахдаа хамгийн үр дүнтэй байхаар тооцоологдсон байх;
- Нэн шаардлагатай хөгжүүлэх салбарыг тодорхой болгосон байх;
- Сонгогчдод таалагдахуйц бодит бус амлалтуудыг амлахгүй байх;
- Сонгуулийн гэрээгээ хамгаалах, биелүүлээгүй тохиолдолд сонгогчийн өмнө улс төрийн хариуцлага хүлээхээ тодорхой тусгасан байх зэрэг ерөнхий зарчим заавал тусгагдсан байх учиртай.

Улс төрийн намууд сонгуулийн Манифесто-ыг боловсруулахын тулд:

- Сонгуулийн гэрээндээ үзэл баримтлалдаа үндэслэсэн засаглалын оновчтой хувилбарыг оруулах;
- Салбар тус бүрийн бодлого, түүний зорилго, хэрэгжих арга зам, эрхзүйн орчин, нөөцийг тодорхойлж тооцоолсон байх;
- Хугацаа, нөөц хязгаарлагдмал бодлогын хэрэгжилтэнд ойлгомжтой тоон үзүүлэлт оруулах;

- Хэрэгжилтийн дараах үнэлгээг тодорхой байлгах, мэргэжлийн бус нийт иргэдэд ойлгомжтой байдлаар тусгаж өгөх;
- Сонгуулийн кампанит ажлаас өмнө судалгаа, тооцооллыг дуусгасан байх үндсэн зарчмыг баримтлан боловсруулдаг.

Сонгуулийн гэрээг хэрэгжүүлэхийн тулд PDCA (Plan-Do-Check-Action) дарааллын зарчмыг баримталдаг. Сонгуулиар бодлогоо танилцуулах нь Plan, Сонгуулийн дараа хэрэгжүүлэх нь Do, үнэлгээ өгөх нь Check, дараагийн сонгуульд бодлого өрсөлдүүлэх нь Action нь болдог. Монгол хэлээр илэрхийлбэл Бодлогын танилцуулга-Бодлогын хэрэгжилт-Бодлогын үнэлгээ-Дараагийн сонгуульд өрсөлдөх бодлогын хувилбар хэмээн тайлбарлаж болно.

Тэгэхээр сонгуулийн мөрийн хөтөлбөр буюу сонгуулийн гэрээ нь амлалт бус шинжлэх ухаанч тооцоолол, судалгаан дээр үндэслэсэн тухайн улс төрийн намын үзэл баримтлалд нийцсэн улсаа хөгжилд хөтөлсөн бодлогын хувилбар байдаг байх нь. Ээлжит сонгуулиар бид бүхэн бодлогын хувилбаруудыг өрсөлдүүлэн сонголт хийх ёстой гэдгээ ухамсартайгаар ойлгон, сонгуулийн мөрийн хөтөлбөртэй зайлшгүй танилцаж зөв сонголт хийж сурах цаг нэгэнт ирсэн дурдмаар байна.



БАЙГАЛЬ, ОРЧНЫ АСУУДАЛ

Байгаль орчныг хамгаалах түүнд иргэдийн оролцоо

Бэлчээрийн мал аж ахуй ба байгаль орчин



Б.БУЛГАН

МУИС-ийн Улс төрийн
сэтгүүл зүйн магистрант

Байгаль орчныг хамгаалах, түүнд иргэдийн оролцоо

Эртлэн босож саравчаа нээн
өглөөний сэнгэнсэн агаар
амьсгалаад зогсож байтал “хог
түүдэг” хүмүүс зэргэлдээ орцны
хогийн бункераас ундаа, усны
хуванцар савнуудыг ялган түүж
харагдана. Өмнө тэдгээр хүмүүсийг
нийгмийн орхигдсон хэсэг, архичид
гэж тоомжиргүй өнгөрдөг байснаа
Цэнд гэдэг ахимаг насны эмэгтэйтэй
ярилцсанаас хойш тэднийг өөр нүдээр
харах болсон билээ. Бидний өөрсдөө
л болж байвал бусад хүмүүс тэр бүү
хэл байгаль дэлхий бохирдож байгааг
юман чинээ боддоггүй бэртэгчин
үзлийн нэг илрэл бол хамаг хогоо
хольж, ил задгай хаяж байгаа бидний
увайгүй үйлдэл бөгөөд харин хаясан
хогноос тушааж болох хэсгийг түүж
байгаа эдгээр хүмүүс бол хөрсөнд
он удаан жил үл задрах хог хаягдлын
хэмжээг бууруулахад бодитой хувь
нэмэр оруулж байгаа үйлстнүүд юм
билээ. Цэнд эгч бол тэдгээр хүмүүсийн
нэг бөгөөд архины мөнгө олохын тулд
биш харин амьдралаа залгуулахын тулд
хогноос хэрэгтэй зүйлээ түүдэг нэгэн.

Тэрээр дунд сургуулийн
нэг хүүхэдтэй өрх толгойлсон ээж.
Зах зээлийн нийгэмд шилжих үед
нөхрийнхөө хамт найман нэрийн
дэлгүүр ажиллуулж боломжийн
амьдарч байж. Гэтэл нэг шөнө дэлгүүрт
нь гал гарч дэлгүүрээ, хайрт ханиа
нэгэн зэрэг алджээ. Амьдралыг зүхэн
архи ууж зовлонг түр ч гэсэн мартмаар
санагдавч торойтол харах үрээ бодоод
үхэх эрхгүй нэгэн болохоо голдоо
ортол ойлгож, олон янзын ажил хийж
амьдралаа залгуулах болжээ. Нэг хэсэг
оёдлын үйлдвэрт туслах оёдолчноор,
үйлчлэгчээр, эцэст нь зам цэвэрлэгчээр
ажиллажээ. Гадаа халуун, хүйтэнд олон
цагаар ажиллахдаа хүүгээ гал алдах вий
хэмээн айх, дулаан бүлээн хоол ундтай
байлгах, хичээл номонд нь анхаарахын
тулд арга буюу ажлаасаа гарчээ. Тэрээр
зам цэвэрлэдэг байхдаа ямар их ундаа
усны сав, лааз хаягдлагийг анзаарсан
тул хогийн машинд хийж ачуулахаас
өмнө түүж тушаагаад байвал хоолны
мөнгөө олоод байж болмоор
санагджээ. Ингээд өөрийн амьдарч
буй гудамжнаас эхлэн сав, лааз түүж

тэдгээрийг овор хэмжээг нь багасгаад шуудайлаад гудамжны нөгөө үзүүр хүрэхэд хоёр шуудай дүүрчээ. Түүсэн савнуудаа ойролцоо хоёрдогч түүхий эд авах цэгт хүргэж өгснөөр оройхон хоолны материалаа цуглуулсаар цаана нь хэдэн төгрөгтэй ч харьдаг болжээ.

Айлуудын хогноос хуванцар сав, лааз, архины шил түүж явахдаа сэтгэлээр унах үе гардаг эсэхийг нь асуухад тэрээр телевиз, сониноор хуванцар савнууд, шил, лааз, гялгар уут хөрсөнд булагдахаараа задардаггүй асар хор хөнөөлтэй зүйл гэх юм байна лээ. Тэдгээрийг хөрсөнд булагдахаас өмнө авч дахин боловсруулах үйлдвэрт тушааж байгаагаа буянтай ажил хийж байна гэж бодох болсон. Нэг хэсэг хуванцар сав авах газар байхгүй хэцүү байлаа. Худалдаж авдаг байсан хятадууд нь авахаа больж энд тэндгүй хуванцар сав лааз хөглөрдөг байлаа. Харин саяхнаас үндэсний компаниуд дахиварууд авдаг болоод өөр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа нь тун сайн хэрэг. Бид мэт нь ч ажилтай, орлоготой л явна. Сэтгэлээр унах үе байна аа. Айлууд бүхий л хогоо холиод нэг уутанд хийгээд хаяна. Тэр хогоо хольж хаясан уутыг задалж үйлдвэрт тушаах боломжтой шил, лааз, хуванцраа ангилан авдаг. Энэ бол маш хүнд хөдөлмөр. Хүнсний хогтойгоо холиод хийчихсэн ууттай хог хүний



эрүүл мэндэд, агаарт маш хортой шүү дээ. Дахин ашиглах боломжтой хогоо тусад нь уутанд, ашиглах боломжгүй хаягдлаа өөр уутанд хаяж хэвшвэл аль аль талдаа л хэрэгтэй. Энэ тал дээр төр засаг маань хог дахин боловсруулах үйлдвэрүүдээ дэмжээд, иргэддээ хог хаягдлаа ангилан ялгах талаар хангалттай мэдээлэл өгч, дорвитой ажил хийгээсэй гэж боддог. Хог түүж амьдарч байгаа иргэдээ хог түүгчид гэж нүд үзүүлэхийн оронд тэднийг хог ангилах үйлдвэрт цалинжуулан ажиллуулж болмоор санагддаг юм гэнэ билээ.



Хүмүүс “хог түүдэг” хүмүүсийг олсон мөнгөөрөө архи уудаг, архичдын л хийдэг ажил гэж бодох нь бий. Тан шиг хог түүж амьдралаа залгуулдаг хэр олон хүн байдаг тухай асуухад тэрээр олон хүн бий. Хог түүдэг гээд адгийн амьтан болчихно гэсэн үг биш шүү дээ. Амьдралд алдаж, онож яваад архи гэдэг зүйлээс хамааралтай болчихсон, олсон хэдэн төгрөгөөрөө архинд зориулж байгаа хүмүүсийг харахад үнэхээр харамсалтай. Гэтэл дан төмрийн хог цуглуулаад түүнийгээ бизнес болгоод арваад хүн ажиллуулаад явж байгаа Дорж гэдэг залуу бий. Хотод ээжийгээ эмчлүүлэхээр 80,000 төгрөгтэй хөдөө орон нутгаас ирээд тушааж болох төмрийн хог хаягдал энд тэндгүй

байгааг олж бизнес хийх санаа анх төрсөн гэдэг. Ийм хөдөлмөрч хүмүүсээс залуус үлгэр дуурайл аваасай.

Өдөрт хэдэн төгрөгийн орлого олдог тухай сонирхоход өдөрт багадаа 20 мянга ихдээ 40 мян төгрөг олно шүү ер нь. Баярын өдрүүдэд үүнээс ч их. Хүү минь том болоод ээжээ та энэ ажлаа битгий хий, таны бие дийлэхгүй гээд надад санаа зовоод байдаг болсон. Надад өгнө гээд ундааны сав, лааз, гялгар уутаа тусад нь хураачихсан айлууд нэлээд хэд бий, гараа хумхин зүтээр сууж чадахгүй юм билээ. Ажил хүнийг голохоос хүн ажлыг голдоггүй



гэж эцэг эх маань сургадаг байсан. Би муу муухай ажил хийж байна гэж боддоггүй харин байгаль дэлхийдээ тустай, хүнд хэрэгтэй ажил хийж байна гэж боддог шүү гэснээр биднээр яриа өндөрлөсөн юм.

Монгол улсын хэмжээнд хогноос дахин боловсруулах боломжтой хогийг ялгаж түүдэг хорин мянга гаруй хүн байдаг. Гялгар уут, хуванцар, төмөр, лааз, машины дугуй зэргийг худалдан авч дахин боловсруулдаг улсын хэмжээнд 29 үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2019 оны байдлаар 300,000 тонн хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж үйлдвэрийн түүхий эд

болгосноор нийт хог хаягдлын 13%-ийг дахин боловсруулсан тухай БОАЖЯ-наас мэдээлж байна. 300 мян.- тонн дахин боловсруулах дахивар түүхий эдийн талаас илүү хувийг хог түүгч иргэд бүрдүүлсэн бөгөөд 2017 оноос нийслэлийн хот тохижуулах газраас хог ангилах сав тодорхой байрлалуудад тавьсан нь тодорхой нөлөө үзүүлжээ. Хөдөө орон нутгаас дээрх дахивар нөөц буюу хог хаяг эдийн засгийн эргэлтэд орохоор буцаж ирдэггүй. Яагаад гэвэл дахивар бүтээгдэхүүнийг авч цуглуулж хотод авчрах тээврийн зардал их, овор хэмжээ их байдгаас орон нутгийн иргэдэд тэдгээр дахивар түүхий эдийг цуглуулах зарж борлуулах сонирхол төдийлөн байдаггүй. Өнгөрсөн онд БОАЖЯ-аас 8 аймагт хуванцар, лаазыг шахаж овор хэмжээг багасгадаг прэссний машиныг олгосон бөгөөд хэрэв эдгээр машин бүрэн хүчин чадлаараа ажиллавал орон нутгаас дахивар бүтээгдэхүүн үйлдвэрүүдэд нийлүүлэгдэж ирэх онд хогны хэмжээ орон нутагт буурах боломжтой. Дахин боловсруулах үйлдвэрүүд бүрэн хүчин чадлаараа ажиллахад шаардагдах түүхий эдээ дотоодоосоо бүрэн хангаж чаддаггүй талаар үйлдвэрлэгчид ярьдаг. Тухайлбал хатуу хуванцрыг хайлуулан сантехник, цахилгаан утасны бүрээс үйлдвэрлэдэг компани дотоодоос цуглуулсан хаягдал хуванцраас үйлдвэрлэлийн түүхий эдийнхээ дөнгөж 30%-ийг үлдсэн 70%-ийг Хятад, Солонгосоос импортолдог байна. Хоёрдогч түүхий эд үйлдвэрлэгч үндэсний компаниуддаа төрийн зохицуулалт бодлогоор эдийн засгийн урамшуулал олгох, хөнгөлөлт,

чөлөөлөлт үзүүлэлгүй үйлдвэрүүдийг өрсөлдөөний зарчмаар байр сууриа олно гээд зөнд нь орхивол энэ салбар өндийн хөгжих боломжгүй гэдгийг өнөөдрийг хүртэл орхигдсоор ирсэн нөхцөл байдал тод харуулна.

Хөгжил гэдэг зүйл бол зөвхөн эдийн засгийн материал баялгийн хөгжил биш болохыг хүн төрөлхтөн туулаад, хөгжсөн улсууд нь сануулсаар, төсөл хөтөлбөр хэрэгжүүлсээр байхад бид өнөөдөр хогоо хольж хаясаар, хогны хэмжээ, бүтэц нэмэгдсээр атал энэ бүхнийг өөрчлөхийн төлөө үйл ажиллагаа яст мэлхийн хурдаар явж байгаад зовнино. Энэ салбарт хөрөнгө оруулах, менежментийг шинэчлэх хүсэл сонирхол үе үеийн шийдвэр гаргагч нарт, салбарынханд төдийлөн байсангүй. Урт хугацаанд, тогтвортой, иргэдтэй тулж ажиллаж байж хог хаягдлын салбарт ахиц гарна.

Байгаль орчны асуудал бол гагцхүү хогны эргэн тойрны асуудал биш нь тодорхой боловч НҮБ-ын гишүүн 193 орнуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн тогтвортой хөгжлийн 17 зорилтуудын цэвэр усны хангамж, иргэдийн амьдрах ээлтэй хотыг бий болгох, хариуцлагатай хэрэглээг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг багасгах, далай тэнгисийн нөөцийг хамгаалах, хуурай газрын эко системийг хамгаалах зорилтуудтай хог хаягдлын асуудал нягтуялдаа холбоотой бөгөөд эдгээр зорилтуудыг хангах суурь нөхцөл нь хогийг байгальд ээлтэй аргаар устгах, дахин боловсруулах, үйлдвэрлэгчид сав баглаа боодлоо солих, өөрчлөхгүйгээр, иргэдийн хог хаягдлын хор хөнөөлийн талаар

ухамсар, дадал өөрчлөгдөхгүйгээр дээрх зорилтуудад хүрэх тухай асуудал хэт өрөөсгөл зүйл болох бөгөөд цаасан дээр бичсэн тунхаглал төдий болоод үлдэнэ.

Бидний өдөр тутам бий болгодог хог хаягдлын хэмжээ, төрөл жил ирэх бүр өсөн нэмэгдсээр байгаа нь эргээд бид хэрэглэндээ, хогондоо боомилуулахад хүргэж байна. Дөнгөж төрсөн нярай хүүхдээс эхлээд бүх хүн эх дэлхийнхээ оршин тогтнолд хамгийн аймшигт заналхийлэгч болон хувирлаа. Энэ бол хэрэглээг шүтсэн сэтгэлгээний үр дагавар.

Гэвч хог үүсгэгч нь бид юм бол алдаагаа залруулагч нь бас л бид. Хогоо ангилах, хэрэглээгээ бууруулах тухай асуудлыг ярихад зарим иргэд худалдан авах чадвар дорой, эдийн засгийн хөгжил сул байгаа энэ үед хог ангилах тухай асуудлыг хөндөх нь үр дүн багатай гэх нь бий. Харин би хөгжил гэдгийг хүний ухамсар, хариуцлага, бусдын өмнө хүлээсэн үүрэг, өөртөө итгэх итгэл, эх орон, эх дэлхийгээ хайрлах сэтгэл энэ бүгдийнхээ төлөө өөрөөс шалтгаалах бүхнээ цаг алдалгүй хийх зориг, ухаан гэж ойлгодог.

Үр хүүхдүүдийнхээ уух ус, амьсгалах агаар, гишгэх газрын төлөө зүрхээ зогсох хүртэл бусдад үгээ хүргэсээр, ихийг хэрэглэх шунаг сэтгэлийг дарж эгэл амьдрах сонголтдоо үнэнч байх болно.



А.ЦАНЖИД

ШУ-ны доктор, профессор

БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙ БА БАЙГАЛЬ ОРЧИН

Дэлхий дахинд уур амьсгал өөрчлөгдөн дулаарал болж, түүний гол шалтгааны нэг болох нүүрс хүчлийн хийн ялгарлыг багасгах талаар анхаарал тавих боллоо. Бэлчээр доройтож, бороо хур орох нь багасаж гол ус ширгэж байгаа зэрэг мал аж ахуйн оршин тогтнолд заналхийлсэн аюул нэмэгдсээр байгаа юм. Манай орны хувьд мал хэтэрхий өссөн, түүний дотор ямаа таван хошуу малын дотор эзэлж байвал зохих зохистой хэмжээнээсээ давж өссөнөөс үүдэн бэлчээр ихээхэн талхлагдаж байгаа ажээ. “Сүүлийн 40 гаруйхан жилд бараг бүх бүсэд бэлчээрийн ургац 20-30%-иар буурч, зүйлийн бүрэлдэхүүн 3-4 дахин багассанаар өндөр, сахлаг өвсөөр хооллодог үхэр сүрэг 1990 оноос илүү эрчимтэй хорогдох болсон, бэлчээрийн даац 2030-2040 он гэхэд одоогийнхоос 2 дахин буурах” хандлагатай болсон ажээ (Ж. Мижиддорж, 255). Энэ бол манай орны мал аж ахуйд төдийгүй, ерөөс хөдөөд бүхэлд тулгарч байгаа томоохон бэрхшээл юм. Улс орноо хүнсний болон бусад бүтээгдэхүүнээр хангадаг хөдөө нутагт, ХАА-д ийм бэрхшээл тулгарч байгаа нь улс оронд маань учирч байгаа аюул юм. Үүнтэй холбоотойгоор уламжлалт бэлчээрийн мал аж ахуй маань байхуу, үгүй юү гэдэг асуулт тавигдаж, сүүлийн жилүүдэд дотоод, гадаадын эрдэмтэн судлаачид янз бүрийн санал дэвшүүлэх болсон юм.

Тэдгээр саналыг тоймлох юм бол гурван үндсэн бүлэгт хувааж болно. Нэгд, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаа л авч үлдэх ёстой. Хоёрт, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаас татгалзаж, европ маягийн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ёстой. Гуравт, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан хөгжүүлэх хэрэгтэй. Эхний саналыг гаргаж байгаа судлаачид болон бусад хүмүүс уламжлалт бэлчээрийн мал аж ахуй нь олон мянган

жилийн тэртээд үүсэж, өдий болтол монголчуудын амь зуулгын гол эх булаг болж ирснээс гадна монгол ёс заншил, ахуй бүхэлдээ түүнтэй холбоотой, бэлчээрийн мал аж ахуй нь өргөн дэлгэр нутаг орноо бүхэлд нь эзэмшиж, аюулгүй байдлаа хангах боломж олгодог гэх мэт үндэслэлийг гаргадаг байна. Харин суурин эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх саналтай хүмүүсийн хувьд бэлчээрийн мал аж ахуй нь амиа аргацаасан шинжтэй, хөдөөгийн хөгжил хоцрогдонгүй байгаагийн шалтгаан болдог, малчид байгалийн хатуу ширүүн нөхцөл, соёл ахуйн дорой байдалд аж төрж байна. Уламжлалт мал аж ахуй ирээдүйгүй боллоо. Тийм учраас ашиг шим ихтэй мал бүхий томоохон фермерийн аж ахуйг байгуулах хэрэгтэй гэж үздэг байна. Хоёр төрлийн мал аж ахуйг хослох хэрэгтэй гэх үзэл нь бэлчээрийн болон суурин эрчимжсэн мал аж ахуйн аль алины нь сөрөг талыг зөөлрүүлэх, харин аль алины нь давуу талыг ашиглах боломж олдоно гэж үзэж байгаа юм.

БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙН ОНЦЛОГ ДАВУУ ТАЛ ЮУ ВЭ?

- Өртөг зардал харьцангуй багатай. Энэ талаар эрдэмтэн Т.Содной бичихдээ “... Төв Азийн уудам их нутагт тун бага өртөг зардлаар идэх хоол, өмсөх хувцас, суух орон байр, унаа тээврээр дуталгүй монгол хүн мянга мянган жилээр оршин аж төрсөөр ирсэн нэгэн түүхэн үнэн байгаа бөгөөд, түүний нууц нь газрын шим хээрийн зэрлэг ургамал, ус хужир, марцыг хоногийн 24 цагийн дотор мах, сүү, ноос, арьс шир болгон хувиргадаг гайхамшигт “амьд машин”, Монгол үүлдрийн мал агаад, түүнийг буй болгосон Монголчууд бид өөрсдөө үүнийгээ төдий л анзаардаггүй билээ” (Т. Содной, 170) гэжээ.
- Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Монголын хөдөө нутаг нь байгалийн бохирдол, эвдрэл багатай, хүчлийн бороо ордоггүй, хөрсөнд шингэсэн хорт бодис багатай юмуу огт байдаггүй, мал ийм цэвэр орчинд ургадаг олон төрлийн ургамал, түүний дотор эмт чанар бүхий ургамлуудыг иддэг. Сүүлийн үед адууны яс, тэмээний чөмөг, гүүний айраг, шар сүүний уураг, хар ямааны мах, сүүлний болон шар тос зэрэг малын гаралтай бүтээгдэхүүнийг үе мөч, элэг, чихрийн өвчинг анагаах чадвартай, хүний ядаргаа арилгах, дархлааг дэмждэг хэмээн үзэж хэрэглэх болсон байна.
- Байгаль орчинд үзүүлэх хор нөлөө багатай. Судлаачид бэлчээрийн мал аж ахуй болон газрыг өмчилж мал аж ахуйг суурин болгосон туршилтуудыг судлан үзсэний үндсэн дээр бэлчээрийн мал аж



ахуй нь байгаль орчинд хамгийн бага хор учруулдаг гэж үзэх болжээ. Хятадын судлаач А. Мөнхдалай, Жан нарын олон судлаач хамтын бүтээлдээ “Монголын нүүдэлчдийн соёл нь орчин үеийн экологийн соёлтой илүү ойр” бөгөөд энэ шинжээрээ газар тариалангийн соёлоос давуу юм хэмээн тэмдэглэсэн байна. (Е. Эндикоттоос дам эшлэв. 112) Минмин Фан, Венжун Ли, Ченжен Жан, Ланхай Ли нар Хятадын Шинжан мужийн Жинхе хошууны хоёр тосгонд хэрэгжүүлсэн нүүдэлчдийг суурьшуулах төслийн үр дүнг судлаад уг төсөл нь экосистемийн шинж чанарт тохиромжгүй, өргөн хүрээтэй хэрэгжүүлбэл сөрөг нөлөөтэй байж болно гэсэн дүгнэлт хийжээ (Минмин Фан нар). Сүүлийн үед манай улсад малын тоо, үүний дотор ямааны тоо толгой олширсоноос үүдэн бэлчээр талхлагдах тал гарч байгаа. Энэ нь нөгөө талаас малчид монгол нутгийн төв хэсэг рүү олноороо нүүдэллэн хүн, малын бөөгнөрөл үүссэнтэй холбоотой байна. Нэг малаас авах ашиг шимийг дээшлүүлэх, жил бүр мах экспортлох зэргээр малын тоо толгойг зохицуулж болох ажээ.

- Нүүдлийн мал аж ахуй нь хөдөөгийн давуу талын нэг болох байгалийн үзэсгэлэн, дуу чимээгүй тайван орчинг хадгалахад чухал нөлөө үзүүлдэг аж. Байгалийн сайханд зугаалах, аж төрөх нь хүний амрах, стрессийг тайлах зэрэг эрүүл мэндийн ач холбогдолтой. Түүнээс гадна хүний зан араншин, шийдвэр гаргах

чадварт хүртэл нөлөөлдөг байна. Профессор Алмаз Шарманы бэлтгэж интернетэд тавьсан мэдээллээс үзэхэд байгалийн сайханд амьдардаг, цэвэр агаарт байнга гарч зугаалдаг хүмүүс гэнэтийн үндэслэл муутай шийдвэр гаргах нь ховор бөгөөд бодож ул суурьтай үйлдэл хийдэг нь тогтоогдсон ажээ. Үүний учир шалтгаан нь байгальтай байнга харьцах нь стресс, бухимдал, сэтгэлийн түгшүүрийг намжааж байдагтай холбоотой ажээ.¹

- Монголын хөдөө нутаг нь монгол ёс заншил, язгуур урлаг гэх мэт болон бусад төрлийн монгол соёлыг агуулж байгаа ба энэ нь бэлчээрийн мал аж ахуйтай холбоо бүхий аж төрөх ёсноос үүдэлтэй ажээ.
- Монголын малчид монгол орны Алтай, Хангай, тал, говийн бүх нутгаар тархан суурьшиж, газар нутгийнхаа эзэн нь болж байдаг учраас улсынхаа нутаг дэвсгэрийг эзэмшиж, бүрэн бүтэн байлгах, харж хамгаалах чухал үүрэгтэй байдаг байна.

Гэвч бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид нь гол төлөв өрхийн аж ахуй байдаг учраас хүчин чадал багатай, байгалийн гамшигт өртөмтгий зэрэг сөрөг талуудтай. Тийм учраас тариан эрхэлдэг нутгууд болон хот суурин газрын ойролцоо эрчимжсэн мал аж ахуйг буй болгох нь зүйтэй гэж үзэж зарим эхлэл тавигдаж байна. Эрчимжсэн мал аж ахуй нь бүтээгдэхүүний гарц их байдаг учраас хүнсний хангамжийг сайжруулах, ХАА-н үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүнийг өсгөх замаар эдийн засгийн өсөлтөд сайн нөлөөтэй юм. Гэвч өртөг зардал ихтэй байдаг учраас мах, сүүний үнэ өндөр байдаг байна. Түүнээс гадна байгаль орчинд, ялангуяа дэлхийн дулааралд нөлөө бүхий хий ялгаруулах нь их байдаг учраас байгаль орчинд ч сөрөг нөлөөтэй гэж үзэх болжээ.

Энэ бүхнийг үндэслэн Монгол улс бэлчээрийн мал аж ахуйгаа цаашид хөгжүүлэн авч үлдэхийн зэрэгцээ суурин эрчимжсэн мал аж ахуйг тодорхой хэмжээгээр хөгжүүлэх хэрэгтэй хэмээн үзэж байна. Монголын бэлчээрийн мал аж ахуй орчин үеийн нөхцөлд зохицон оршин тогтнож, улс орондоо үр ашгаа өгөх чадвартай гэдгийг дотоодын төдийгүй гадаадын судлаачид хүлээн зөвшөөрч байна. Кэролин Хампри, Дэвид Снит нар Өвөр Азийн бүс нутагт орших Оросын Тува, Буриад, Монгол Улс болон Хятад улсын Өвөр Монгол, Шинжааны нүүдэлч малчдын байдалд харьцуулсан шинжилгээ хийсний үндсэн дээр ийм дүгнэлтэд хүрсэн байна (К.Хампри, Д. Снит 2006). Тэд “Шилжилт хөдөлгөөнтэй бэлчээрийн аж ахуй нь аливаа нийгэм, эдийн засгийн тогтолцоо, түүний дотор технологийн өндөр түвшин, зах зээлийн харилцаанд зохицож чадах бүрэн

¹ <https://mix.tn.kz/mixnews/kak-priroda-vliyaet-na-zdorove-cheloveka-358966/>

боломжтой юм. ... Бэлчээрийг дээд зэргээр сэлгэн ашиглах нүүдлийн аж ахуй нь гоц гойд хоцрогдмол маллагааны арга ажиллагаа бишээс гадна энэ нь өндөр өгөөжтэй, олон төрлийн салбарыг хамарсан, нарийн зохицуулалт бүхий үйлдвэрлэлийн нэгэн хэлбэр мөн бөгөөд технологийн дэвшил, зах зээлийн нөхцөлд ч тохируулан үйл ажиллагаа явуулах боломжтой” гэжээ. Элизабет Эндикот Монголын малчдын орчин үеийн эдийн засаг, соёлын нөхцөлд зохицон байгаа арга зам нь дэлхийн бусад малч, нүүдэлч ард түмэнд үлгэр жишээ туршлага болно гэж үзсэн байна (Elizabeth Endicott, 2007).

Ийнхүү байгаль экологийнхоо нөхцөлд дээд зэргээр зохицсон Монголын бэлчээрийн мал аж ахуй нь монголчуудын амьдралын гол эх булаг төдийгүй, аж төрөх ёс, оюун санааны нь тодорхойлогч хүчин зүйл байсаар ирсэн ба Монгол хүн монголоороо байя гэвэл мал аж ахуйгаа хөгжүүлж, хөдөө нутагтайгаа хүйн холбоотой байх ёстой ажээ.



ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Бүх дэлхийг бүрхсэн COVID-19



Д.МЯГМАРСҮРЭН
Удирдагын академийн
МДИ-ын захирал, доктор

БҮХ ДЭЛХИЙГ БҮРХСЭН

COVID-19

2020 он гарахтай зэрэгцэн дэлхий дахиныг донсолгосон хэрэг явдал гарсан нь коронавирус хэмээх цар тахал хүн төрөлхтнийг цочоов. 2020 онд зохиогдох Олимпын наадмаас аваад олон улсыг хамарсан бүхий л чуулга уулзалт, үзэсгэлэн яармаг, баяр ёслолын арга хэмжээ тэр чигтээ цуцлагдсан төдийгүй дэлхийн эдийн засаг, банк санхүүгийн индекс, аж үйлдвэр, аялал жуулчлал, үйлчилгээ, хүн амын шилжилт хөдөлгөөн, өсөлт бууралтын урьдчилсан таамаг, тооцоолол тэр чигтээ төөрч будилахад хүргэв.

Титэм вирус хэмээн нэрийдсэн өчүүхэн организм хүн төрөлхтний амьдралын хэмнэлийг бүхэлд нь өөрчилж, цаг хугацааны тооллыг Covid-оос өмнө ба хойно хэмээн хувааж, жинхэнэ ёсоор бүхнээс дээр залагдсан “Титэм”-тэй өвчин болж хувирлаа. Явган ярианд гарсан шиг “2020 онд чухам бүх ажлыг баллаж өгөх”-өөр төлөвлөсөн биш харин бүр

эсрэгээрээ бүх нийтээрээ балрахад хүрэх нь тэр. Үнэхээр “Covid-19 ба” хэмээн дурын сэдэв тавиад дуртай зүйлээ ярьж болохоор өргөн хүрээг хамарчээ. Ковид ба улс төр, ковид ба эдийн засаг, ковид ба шинжлэх ухаан, ковид ба шашин, ковид ба үзэл суртал, ковид ба монгол хүн, ковид ба онлайн бизнес, ковид хийгээд ариун цэврийн цаас... ер юуг ч холбоод нэг нийтлэл бүү хэл нилээн зузаан боть ном, тайлбар толь гаргахад багадаааргүй болжээ. Ийнхүү нуршуу оршлоо орхиод, хүн төрөлхтөнд тулгамдсан цар тахлын асуудал зарим салбарт хэрхэн нөлөөлж буйг ажиглалт, баримтад үндэслэн аль болох товч дүгнэн шинжлэхийг оролдъя.

ХЭРҮҮЛИЙН КОРОНАГААС ХЭЛЦЛИЙН КОВИД ХҮРТЭЛ...

Цар тахлын халдварын голомт гэгдсэн Хятадын төв хэсэгт орших зам тээврийн томоохон зангилаа боомт хот болох 11 сая хүн амтай Уханиас цагаан

сарын баяраар хэдэн зуун мянган иргэд тал тал тийш тарж явснаар үйл явдал эхлэв. Халдвар маш хурдтай тарсан төдийгүй үхлийн хэмжээгээр ч аюулын харанга дэлдсэнээр Хятад улс дэлхий нийтийн анхаарлыг төвд орлоо. Юунаас үүдсэн халдвар болох тухай дэлхийн хэвлэл мэдээллээр шуугиж, хятадууд бохир заваан амьтан, шавьж хорхойгоор хооллодгоос үүдсэн хэмээн нэг хэсэг нь ад үзэж, нөгөө хэсэг нь биологийн зэвсэг болгон бүтээж, Хятадыг хорлох зорилготой ажиллагаа хэмээн хардаж хүртэл үзэв. Бүр НҮБ-ын Биологийн зэвсгийн комиссын гишүүн асан Игорь Никулин, ОХУ-ын Төрийн Думын гишүүн Наталья Поклонская, Израилийн тагнуулын офицер Дани Шохам зэрэг дэлхийн нэр хүнтэй байгууллагын төлөөлөгчид хүртэл энэхүү “хуйвалдааны онол”-ыг хуваалцаж, АНУ эсвэл БНХАУ зэвсгийн зориулалтаар уг вирусыг гаргаж авсан хэмээн барин тавин мэдэгдэж байв. Хятадын засгийн газрыг хаалттай тогтолцоогоороо далимдуулан вирусын тархалт нэрээр олон хүний амь насанд хүрч байгаа тухай шижиг таамаг явсан төдийгүй олон сар сунжирсан Хонконгийн бослогийг намжаах зорилгоор тархалтад идэвхтгүй хандаж байгаа тухай хардалт ч ярианы сэдэв болоод авсан.

Ковид-19 нэн тэргүүнд “улс төрийн вирус” болон халдварлалаа. Хэдийгээр ДЭМБ-аас шинэ халдварыг албан ёсоор “Covid-19” хэмээн нэрлэхээр тогтсоноо 2-р сарын эхээр олон нийтэд зарласан ч үгээр наадсан хэл ам, хэрүүл тэмцлийг намжааж

чадсангүй. АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп 3-р сарын 17-нд твиттерт хийсэн мэдэгдэлдээ “Хятад вирус” гэсэн үг ашигласан нь хэрүүлийн алим тарив. Олон нийтийн зүгээс арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан хэмээн шүүмжлэлд өртөсний зэрэгцээ БНХАУ-ын албаны зүгээс Хятадыг доромжилсон алдаагаа яаралтай засахыг хариу шаардсан мэдэгдэл гаргалаа. Төд удалгүй АНУ-ын төрийн департаментаас хийх мэдэгдэлдээ “Ухань вирус” хэмээх нэршил ашиглахаар оролдсон нь галыг дахин өрдөхөө шахсан.

Гэвч улс орнуудад ковид-19 тойрсон улс төрийн бужигнаан намжсангүй. Хаалтай улсын сонгодог загварт тооцогддог Туркменистан Улсын Ерөнхийлөгч Гурбангулы Бердымухамедов ээлжит мэдэгдлээрээ өөрийгөө коронавирүсийн шинэ төрлийн халдварыг эдгээдэг ид шидтэй хэмээн ард түмэндээ зарлав. Тус улсын “Алмаз” нэртэй адуу Ашхабадын гудамжинд хятад жуулчдад үйлчилснийхээ дараа 39.4 хэм хүртэл халуурч коронавирүсээр өвчилсөнийг улсын тэргүүн тэр дор нь эмчилж эдгээжээ. Энэ нь коронавирүс адуунд халдварласан цорын ганц тохиолдлоор дэлхийд “бүртгэгдсэн”. Бердымухамедовын дараагийн алхам нь улс даяар “коронавирүс” гэдэг үгийг хориглох зарлиг байлаа. Уг зарлигийн дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дээрх үгийг ашиглахгүй төдийгүй иргэд олон нийтийн газар байхдаа хэрэглэж болохгүй аж. Энэхүү зарлигийн хэрэгжилтийг гүйцэлдүүлэх үүднээс энгийн

хувцастай цагдаа нар олон нийтийн газраар эргүүл хийн “коронавирус” гэж ярьсан хүмүүсийг баривчилсан тухай олон улсын мэдээллийн

мэргэжилтнүүдийн шаардлагаар 03 сарын 16-нд цуцлагдсан. Удалгүй Ерөнхий сайдын Жонсоноос халдвар илэрч, онолын дагуу өөрөө байгалийн



Энэтхэгт вирусын халдварын эсрэг үхрийн шээс сайн хэмээн олон хүн хэрэглэв

хэрэгслүүд шуугиад амжсан. Заримдаа ийм мэдээнд итгэхгүй хөөрхий улс орныг дамшиглаад ч байгаа юм шиг санагддагийг хэлэх юун.

Хөгийн марзан зүйл үүгээр дуусахгүй. Их Британийн Засгийн газрын шинжлэх ухааны ахлах зөвлөх, доктор Сэр Патрик Валлэнс тахлын эсрэг “herd immunity” буюу сүргийн дархлаа тогтоох онол дэвшүүлэв. Халдвар нилээн газар авсан хойно ч Британийн ерөнхий сайд Борис Жонсон “тайван байж, амьдралаа хэвийн үргэлжлүүлэх” бодлого барьж, ахмад настнуудыг халдвараас хамгаалж, хүн амын эрсдэл багатай бусад хэсгийг сул хаяхаар төлөвлөснөө зарласан. Гэвч түүний “сүргийн дархлаа” тогтоох энэ төлөвлөгөө анагаах ухааны

шалгаруулалтад өртөж нөгөө ертөнц рүү явангаа алдсан.

Дээрх хоёр улсын жишээнээс харахад л асуудалд эрүүл бусаар хандах явдал ардчилсан ба ардчилсан бус, хөгжингүй хийгээд хоцрогдож доройтсоноос үл хамаарч байгааг харж болно. Цар тахлын халдварт хайхрамжгүй хандаж байсан олон улс орон сандарч тэвдэн, хэрхэн хариу арга хэмжээ авахаа мэдэхгүй тэвдэж байна. Цар тахал хүний дархлааг сориод зогсохгүй улс орнуудын засаглал, удирдлагын чадамжид томоохон сорилт боллоо. Хүн амаа дайчлах, хүч нөөцөө оновчтой хуваарилах, урдчилан сэргийлэх арга хэмжээ шуурхай авах, зохион байгуулалтад орох, шинжлэх ухаан, технологийн



Ариун цэврийн цаасны хомсдол үүссэнийг
шоглосон гудамжны графит. АНУ, Лос
Анжелес хот.

чадвахийг ашиглах зэрэг чадвараараа Өмнөд Солонгос, Япон, Тайвань, Хятад, Сингапур зэрэг Азийн голдуу орнууд үлгэр жишээ үзүүлж байна.

Улс орнуудын дотоод эв нэгдлийн зэрэгцээ олон улсын хамтын ажиллагаанд онцлог олон үйл явдал өрнөв. Ядарсан цагт чанараа таниулж, Хятад улс өөрийн халдвараа дарсан даруй Европын орнууд, Америк, Ойрхи Дорнод, Өмнөд Ази руу тусламж илгээн, хүн хүчний дэмжлэг үзүүлж эхлэв. Тэвдэж явахад тэвнээр туслахын чухлыг мэдрүүлэх зорилгоор азийн жижигхэн улс гэгддэг Монголын тэргүүн БНХАУ-дайлчилж, 30000 хонь бэлэглэхээ амалсан явдлыг “Sheep diplomacy” хэмээн нэрийджээ. Халдварт өвчинтэй тэмцэх бүх нийтийн үйлсэд төр засаг, хувийн хэвшил төдийгүй жирийн иргэд ч эрвийх дэрвийхээрээ гар бие оролцож, хандив тусламжаа өөрийн болон бусдын улс орон руу илгээж байна. Ковидын халдвар хүн гэдэг амьтан хэр иргэншиж соёлжсон

хийгээд улс орнуудын хөгжил цэцэглэлт ямар түвшинд очсоныг бэлээхэн сорьж шалгаад өглөө.

ХҮНИЙ ЧАНАР, УЛСЫН СҮРИЙГ ТАНИУЛСАН КОВИД-19

Хүн төрөлхтөнд учирсан аюул гамшгийн үед хүний эрх дураар байдал, эрх чөлөө чухал уу, атгасан гар шиг нэгтгэх дэг журам, хариуцлага чухал уу гэдэг тухайд бүх нийтээр эргэцүүлж байна. Дорно ба Өрнийн сэтгэлгээний ялгааг өчүүхэн нэг муу вирус тодхон харуулаад өглөө. Азиуд аюул тохиолдоход хамтран ажиллах, зохион байгуулалтад шуурхай орох чанар, хариуцлага үүргээ ухамсарлах чадвараа хар тахлын үед гялалзтал харуулж чадаж байна. Харин Америк, европчууд салан назгай байдал, тогтолцоо ба шинжлэх ухааны давуу талдаа эрдэж бардсан чанар, ам бардам ч ачир дээрээ үйлдэл тааруу байдал нь нүдэн дээр тодров. Итали, испанид өвчтнөө хаяж зугатсан эмч нар, хөл хорионы дэглэмийг зөрчиж бөөн бөөнөөрөө зугатсан иргэдийг Азиуд хараад гайхширч суув. Хувь хүмүүсийн ааш авир гэлтгүй улс орны уг чанар танигдав.

Хэвлэл мэдээллээр “шартахал”, “шар түгшүүр” хэмээн гарчиглаж, улс орон бүрт Ази царай зүстэй бүрийг гадуурхан доромжилсон хэрэг олноор гарав. Ялангуяа тэгш байдал, хүний эрхийг дээдлэх зарчмыг үндэслэсэн гэгдэх Америк, Европын орнууд цаашлаад Австрали, Латин Америкт шар арьстнуудыг нүд үзүүрлэж, зодож занчсан хэрэг цөөнгүй гарсныг

нийгмийн сүлжээний дурын талбараас харж болно.



*Хөл хорио тогтоосон хотод
буга дураар бэлчиж байгаа нь.
Япон улс, Нара парк. 2020. 3-р сар*

Соёл иргэншил, ухамсар сэтгэлгээ төдийгүй тогтолцооны хувьд Европчууд ялзран доройтож, бүр мөхөж буй тухай сэтгэгдэл нийгмийн сүлжээгээр хангалттай явав. Хамгийн иргэншсэн хэмээх хүчирхэг улс орны иргэд ариун цэврийн цаасны төлөө зодолдож, амь насанд нь вирус биш хүн халдахаас эмээж буу шийдэм худалдан авахаар дугаарлаж, аль танагтай баян хөрөнгөтэй нь хүнс хоолоо их хэмжээгээр нөөцөлж, чадалтай нь халдварын голомтоос хувийн онгоцоо хөлөглөн зугатаж, ер хүний мөн чанар алган дээр тавьсан мэт танигдав. Дэлхийн сүйрлийг зөгнөсөн “2012” киноны үзэгдэл бодит амьдрал дээр

биелэхээ алдав. Алга дарам ариун цэврийн цаасан дээр хүмүүний ноён нуруу хуга явлаа.

Халдварт өвчний тархалт олон жилийн настай Европын холбооны эв нэгдлийг шалгаж, тун хэврэг байна гэсэн дүгнэлтийг олон нийт өгөх боллоо. Цагаа тулахаар “амь амиа бодоорой” гэсэн зарчмыг европын орнууд дагаж байгаа нь анзаарагдав. Сербийн Ерөнхийлөгч Александар Вучич “Европын эв нэгдэл зөвхөн цаасан дээр оршдог ба ноцтой нөхцөл байдалд бодит тусламжийг зөвхөн Хятадаас хүлээх нь найдвартай” хэмээн мэдэгдсэн бол “Итали улс Европын комисст эмнэлгийн тоног төхөөрөмж авах хүсэлт тавьж, гишүүн орнуудад уриалга илгээсэн ч бүтээгүй” хэмээн Италиас ЕХ-нд суугаа байнгын төлөөлөгч Маурицио Массари гомдолсон байдаг. Үүгээр зогсохгүй эртний түнш АНУ анд Франц орны захиалсан 60 сая амны хаалтыг замаас нь үнэ цохин худалдан авсан хачин хэрэг ч мандсан. Нэг ёсондоо дээрэм хийж, улс гүрнийхээ уг чанарыг таниулав.

Өрнө, Дорно ялгаатай ч бас адил зүйл хангалттай. Аль аль нь аюулт өвчнийг дарахын төлөө нойр хоолоо хасан зүтгэж байна. Хаана хаанаа халдварыг дарах вакцин олох гээд чармайж байна. Сайны хажуугаар саар гэдэг шиг дэлхий дахинд тэнэг үйлдэл, мухар сүсэг тархмал үзэгдэл болохыг олон жишээ баримт илчлэв. Солонгост гарсан халдварыг шашны гаж урсгалын сүмийн сүсэгтэн эмэгтэй газар сайгүй тараахыг хэн ч урьдчилан тооцсонгүй. Мэдээллийн технологи

өндөр хөгжсөн азийн бар улсын иргэд мухар сүсэг тэр чигтээ автсаныг дэлхий дахинд нотлов. Жирийн тэтгэврийн эмгэнээс аваад том улс төрчид нь шашны мунхруулгат гүн автсныг сая анзаарав. Дэлхийн нөгөө эрэгт нэгэн зэрэг хачин үзэгдэл өрнөв. Англи, Нидерландад иргэд коронагийн халдварын эх үүсвэр хэмээн хардаж, 5G сүлжээний цамхаг шатаасан хэрэг дуулдав. Ковидоос эмээсэн Энэтхэгт үхрийн шээс сүүний эрэлтээс давж ууж, Иранд сүсэгтнүүд сүмийн ханаа долоохоор шамбааралдаж, Японд “Амабиэ” хэмээх хүн дүрстийн хөрөг шүтэж, хүмүүс аль хир чадлаараа л халдвартай тэмцэж байна. Ковид бас орчин үеийн хүн төрөлхтний шинжлэх ухаан хийгээд сүсэг бишрэлийн түвшин ямар байгаад дүн тавьж өглөө.

Вирус хүнд муу зүйл учруулсан ч байгальд сайн нөлөө үзүүлснийг хэвлэлийн мэдээнүүд шуугиж байна. Бүх нийтийн хөл хорио тогтоосноор агаар, орчны бохирдол эрс буурав. 2008-2009 оны хямралаас хойш анх удаа хөрс усны хорт хаягдал, агаар мандалд хаягдаж буй азотын давхар ислийн хэмжээ эрс буурсаныг сансараас авсан зургууд нотолж байна. Зарим хот суурин, далайн эрэгт олон зуун жилийн дараа зэрлэг амьтад тайвнаар бэлчиж эхэлснийг нийгмийн сүлжээгээр үзүүлэх болов.

КОВИДООС ХОЙШХИ ДЭЛХИЙ ЕРТӨНЦ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨХ ВЭ?

Судлаач, шинжээчид ковид-19 халдвар дэлхий ертөнцийг хэрхэн өөрчлөх талаар аль хэдийн өөр өөрийн таамаглал, дүгнэлтээ дэвшүүлээд эхэлсэн. Үнэхээр нийгмийн бүхий л салбар хүрээнд асуудлыг цоо шинээр харах, төлөвлөх, тооцох, ажиллах шаардлага тулгарч байна. Нэн тэргүүнд халдвар хамгааллын дэглэмийг шинэ түвшинд авч үзэх дохио сануулгыг дэлхий нийтэд өгч байна. Наад зах нь хүмүүс цаашдаа яаж мэндчилж, ёсолж байх уу гэдгээс аваад аливаа олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хэрхэн аюулгүй зохион байгуулах уу зэрэг соёл, хандлага, сэтгэлгээ, менежмент, арга барилын томоохон өөрчлөлтүүд гарч эхлэнэ хэмээн судлаачид үзэж байна.

Дэлхийн ардчилсан орнуудын чансааг тодорхойлох судалгааны дүгнэлтээр ковид-19 халдварт өвчний эсрэг эрс шийдэмгий арга хэмжээ авсан засгийн газруудын рейтинг ихээр өссөн тухай судалгааны дүгнэлт хүртэл гарч амжжээ. Цаашдаа ардчилал оршин тогтнох уу эсвэл мөхөх үү гэдэг талаар мэтгэлцээн ид өрнөж байна. Тогтолцооноос үл хамаараад бүх улс орнуудад маш том дохио өгсөн зүйл бол бүх салбарт мэдээлэл технологийг нэвтрүүлэх явцыг эрчимжүүлэх шаардлага нэн тэргүүнд тулгарч байна. Улс төрийн салбарт гэхэд санал хураалтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим байдлаар сонгууль ба улс төрийн аливаа арга хэмжээг явуулах хэрэгцээ улам бүр өсч байна. Айлын хаалга

нүдэж, сурталчилгааны материал тараадаг, олон хүн бөөгнүүлж, хурал уулзалт зохиодог, эсэргүүцэл дургүйцлээ илэрхийлж талбай дээр жагсаж цугладаг уламжлалт улс төрийн үйл явдал шинэ шатанд гарах нөхцөл шаардлага тавигдаж байна. Улс орнууд парламентын хуралдаанаа онлайн горимоор явуулж үндсэндээ хэвшив.

Үндэсний аюулгүй байдал, улс орны батлан хамгаалах хүч нөөц хэмээх ойлголтыг өөрөөр харж, цоо шинээр үзэл баримтлал, онолоо дэвшүүлэхийг “ноён вирус” сануулав. Халдварт өвчний үед улс орны батлан хамгаалах хүч, цэрэг зэвсгийн хүч чадал ямар ч хэрэггүй үзүүлэлт болж орхив. Шинэ төрлийн биологийн дайнд хил хязгаар, фронтын шугам гэж үүсэхгүй нь болтой. Цэрэг арминд зэвсэг барьсан эрс биш чагнуур зүүсэн эмэгтэйчүүдийг идэвхтэй элсүүлж бэлдэх шаардлагатай болсоныг эрх баригчдад илтгэн харуулав. Ямар ч хүчирхэг гүрэн халдварын эсрэг дангаараа хүчгүйдэж, бусад улсын тусламж дэмжлэг, хамтын ажиллагаанд суурилан даван туулахаас өөр аргагүй болохыг ухамсарлуулав. Дэлхийн дахин ОУВС-гийн гүйцэтгэх захирал Кристалина Георгиева “хүн төрөлхтөн 1930 оны их хямралаас хойшхи хамгийн том хямралтай нүүр тулж байна, цар тахал зогсоход дэлхийн 7.8 тэрбум хүн амын тэн хагас нь ядуу ангилалд орсон байх магадлалтай гэдгийг анхааруулж, доройтсон эдийн засгийг сэргээхэд олон жил шаардагдана” хэмээн дүгнэжээ. “Америк нэгдүгээрт” лоозон ганхаж, Хятад мөрөөдөл, БНХАУ-

ын үсрэнгүй хөгжлийн тухай үзэл баримтлалд ч засвар орох шинжтэй болов. Бүхэлдээ өнөөгийн дэлхийн дэг журамд өөрчлөлт орж буйг дэлхийн нэр хүндтэй судлаачид дуу нэгтэй илэрхийлж байна. АНУ-ын олон улсын харилцааны ахмад судлаач Хенри Киссинжер “Нэгэнт тогтсон дэлхийн дэг журамд эргэлт буцалтгүй өөрчлөлт орж байгаа”-г хүлээн зөвшөөрсөн байна.

Хүн төрөлхтөн нэг завин дээр байгаагаа харь гаргийн аварга зочин айлчилснаар бус нүдэнд үл өртөн жижиг организмын дайралтаар л мэдэрлээ. Даяаршил ямар түвшинд хөгжсөнийг богино хугацаанд мэдрүүллээ. Даяаршлын хэрмэл хүү гэртээ бүгэж, улс орнууд хамаг хил хязгаараа хааснаар хүчирхэг гүрнүүд сансарт нисэх, ертөнцийг эзлэх амбициа орхиж, бор гэртээ богд байсан нь дээр хэмээх сонголт руу буцлаа. Хүн амын шилжилт хөдөлгөөн, аялал жуулчлал хумигдаж, гадны зочинд хянамгай болгоомжтой хандах сэтгэлгээ нэг хэсэгтээ үргэлжлэхээр байна.

“Ямар ч муу юм эцэстээ сайн тал руугаа эргэдэг” гэдэг хэлц шиг өчүүхэн жижиг биетэй ч бэлчээр нь бүх дэлхийг бүрхсэн ковид-19 хүн төрөлхтний хөгжил цэцэглэлтэд дүн тавиад зогсохгүй цаашдаа юун дээр анхаарах талаар хангалттай их сургамж үлдээсэн онцгой үйл явдал байх болно...



Монгол дахь Конрад-Аденауэр-Сан
Сөүлийн гудамж Браухаус 22
Улаанбаатар хот 14253
Монгол улс

Утас: +976-11-319135/36
www.kas.de/mongolei
www.facebook.com/kas.mongolei
info.mongolia@kas.de